

Нэгдүгээр бүлэг

1 Анханд Бурхан нь огторгуй болон дэлхийг бүтээв. 2 Дэлхий гэвэл, төлөвгүй болон хоосон байсан бөгөөд гүн нуурын дээр харанхуй нь байсан ба Бурханы тодотгол нь усны дээр хөдөлсөн билээ. 3 Тийм бөгөөд Бурхан нь зарлиг болгон; Гэрэл бүтэх болтугай! гэж зарлиг болгосноор гэрэл бий болов. 4 Бас Бурхан нь гэрлийг сайн гэж үзээд, Бурхан нь гэрлийг харанхуйгаас ангижруулав. 5 Бас Бурхан нь гэрлийг өдөр гэж нэрлээд, харанхуйг шөнө гэж нэрлэв. Тийнхүү үдэш болон өглөө нь нэг дэхь өдөр буй билээ. 6 Жич, Бурхан нь; Уснуудын дунд агаар бүтэх болтугай! Тэр нь уснуудыг уснаас салгатугай! 7 гэж зарлиг болоод, Бурхан нь агаарыг бүтээж, агаарын доор байгч болон агаарын дээр байгч уснуудыг хооронд нь салгав. Тийнхүү түүнчлэн боллоо. 8 Бас Бурхан нь агаарыг огторгуй гэж нэрлэв. Түүнээр үдэш болон өглөө нь хоёр дахь өдөр билээ. 9 Жич, Бурхан нь; Огторгуйн доор байгч уснууд нь нэг оронд хуралдах бөгөөд, хуурай газар нь үзэгдэх болтугай! гэж зарлиг болгосонд түүнчлэн болов. 10 Тийм бөгөөд Бурхан нь хуурайг газар гэж нэрлэж, уснуудын хуралдсаныг далай гэж нэрлээд, Бурхан нь үүнийг сайн гэж үзэв. 11 Бас Бурхан нь; Газар нь өөрийн дээр үрийг үрлэгчүүдийн өвсийг гарган, өөрийн дотор өөрийн үрийг баригч болон зүйл зүйлийн ёсоор жимсийг өсгөгч жимст моднуудыг гаргах болтугай! гэж зарлиг болгосонд түүнчлэн болов. 12 Тийм бөгөөд газрын өөрийн зүйлийн ёсоор үрийг үрлэгчүүдийн өвс болон өөрийн дотор баригч ба зүйл зүйлийн ёсоор жимсийг өсгөгч модыг гаргасанд, Бурхан нь үүнийг сайн гэж үзэв. 13 Тийм бөгөөд үдэш болон өглөө нь гурав дахь өдөр билээ. 14 Бас Бурхан нь зарлиг болруун; Огторгуйн агаарт гэрлүүд бүтээд, өдрийг шөнөөс салгах болтугай! Жич, тэд нь тэмдгүүд болон цагууд ба өдрүүд болон жилүүдийн төлөө болох болтугай! 15 Бас тэд нь дэлхийг гийгүүлэхийн төлөө огторгуйн агаарт байх болтугай! гэж зарлиг болгосонд түүнчлэн бүтэв. 16 Тийнхүү Бурхан нь хоёр их гэрлийг бүтээв гэвэл ихийг нь өдрийг тэргүүлэхийн тул болон шөнийг тэргүүлэхийн төлөө бүтээгээд, оддыг ч бүтээв. 17 Бас Бурхан нь дэлхийн дээр гийгүүлэх бөгөөд 18 өдөр болон шөнийг тэргүүлэх ба гэрлийг харанхуйгаас салгахын тулд огторгуйн агаарт тэднийг тавиад, Бурхан нь үүнийг сайн гэж үзэв. 19 Тийм бөгөөд үдэш болон өглөө нь дөрөв дэхь өдөр билээ. 20 Тийм бөгөөд Бурхан нь; Уснууд нь хөдлөгч амьтныг үлэмжлүүлэх бөгөөд огторгуйн агаараар шувууд нь нисэх болтугай! гэж зарлиг болгов. 21 Бас Бурхан нь их бүү загас болон өөрийн зүйлийн ёсоор усны гаргагч хамаг аталзагч амьтан ба өөрийн зүйлийн ёсоор хамаг жигүүртэн шувуудыг бүтээгээд, үүнийг сайн гэж үзэв. 22 Тийм бөгөөд Бурхан нь тэднийг адистадлаж, ийн зарлиг болгов; Үргэлж үржигтүн! Далайн усыг дүүргэгтүн! Шувууд нь газрын дээр үржтүгэй! гэлээ. 23 Тийнхүү үдэш болон өглөө нь тав дахь өдөр билээ. 24 Жич, Бурхан нь; Газар нь өөрийн зүйлийн ёсоор амьтан болон өөрийн зүйлийн ёсоор мал ба хорхой болон ангуудыг гаргатугай! гэж зарлиг болгосонд түүнчлэн болов. 25 Энэ мэтээр Бурхан нь өөрийн зүйлийн ёсоор газрын ан болон өөрийн зүйлийн ёсоор мал ба өөрийн зүйлийн ёсоор хорхойнуудыг бүтээгээд, үүнийг сайн гэж үзэв. 26 Тийм бөгөөд Бурхан нь; Бидний дүрсээр бидэнтэй адил болох хүнийг бүтээе! Тэд нь далайн

загас болон огторгуйн шувууд ба мал болон бүхэл дэлхий ба газрын дээр аталзагч хамаг хорхойнуудыг эзлэх болтугай! 27 гэж зарлиг болгоод, Бурхан нь өөрийн дүрсээр хүнийг бүтээв. Тэр нь Бурханы дүрсээр түүнийг бүтээж, эр болон эм тэднийг бүтээв. 28 Жич, Бурхан нь тэднийг адистадлаж, Бурхан нь тэдэнд; Та үржин олон болж, дэлхийг дүүргэгтүн! Бас түүнийг эрхэндээ оруулаад, далайн загас болон огторгуйн шувууд ба газрын дээр хөдлөгч амьтныг эзлэгтүн! 29 Бас Бурхан нь зарлиг болгон; Мана. Би хамаг газрын дээр үр үрлэгчид болон үр үрлэгчүүд ба өөрийн дотор модны жимсийг баригч аливаа модны жимсийг тань идээ болгохын тулд танд өгөв. 30 Бас газрын аливаа амьтан болон огторгуйн аливаа шувууд ба газар дээр байгч аливаа амины амьсгалт аталзагчуудын идээ болгохын тулд би хамгуудыг өгөв. гэж зарлиг болгосонд түүнчлэн болов. 31 Бас Бурхан нь өөрийн боловсруулж бүтээсэн бүрийг сайн гэж үзэв. Тийнхүү үдэш болон өглөө нь зургаа дахь өдөр билээ.

Хоёрдугаар бүлэг

1 Энэ мэтээр огторгуй болон дэлхий ба тэдний хамаг чуулган нь бүтээгдэж дуусав. 2 Бас бурхан нь өөрийн үйлдсэн үйлсийг зургаан өдрийн дотор бүтээж дуусгаад долоо дахь өдрөө амрав. 3 Тийм бөгөөд бурхан нь өөрийн амралтын өдөр болох долоо дахь өдрийг адислаж, ариун болгов. Яагаад гэвэл, бурхан нь бүх зүйлээ бүтээж дуусаад, тэр өдөр амрав. 4 Огторгуй болон дэлхийг боловсруулахад Жахуа бурхны огторгуй болон дэлхийг бүтээх өдөр тэдний уг нь тэр мэт билээ. 5 Бас тэр нь газрын дотор булаггүй, хээрийн шугуй болон ургаагүй хээрийн нуга бүрийг бүтээв. Тэр юуны тулд гэвэл, бурхан нь газрын дээр бороог оруулаагүй бөгөөд газрыг урвуулах хүнгүй билээ. 6 Зүгээр нэг будаг нь газраас гарч, шорооны нүүрийг норгожээ. 7 Тийм бөгөөд Жахуа бурхан нь газрын шорооноос хүнийг бүтээгээд, түүний хамарт амины амьсгалыг үлээв. Тийнхүү хүн нь амьд сүнс болов. 8 Бас Жахуа бурхан нь зүүн зүгт нэг тариаланг тариад, өөрийн бүтээсэн хүнийг тэнд суулгав. 9 Бас Жахуа бурхан нь газраас аливаа сайхан үзэсгэлэнтэй болон сайн идээт мод болон тариалангийн дунд амины мод болон сайн ба мууг таниулах модыг ургуулав. 10 Жич, тариаланг услахын тулд нэгэн гол гаргав. Тэр нь тэндээс дөрвөн салаа болж, урссан юм. 11 Анхны салаа голын нэр нь Писон билээ. Тэр нь Хавела гэдэг алттай газар бүрийг тойров. 12 Тэр газрын алт нь сайн бөгөөд тэнд оюу эрдэнэ чулуу байгаа. 13 Хоёр дахь голын нэр нь Гихан бөгөөд тэр нь Кус газар бүхнийг тойров. 14 Гурав дахь голын нэр нь Хиджил бөгөөд тэр нь Ашүрийн зүүнээр урсав. Дөрөв дэхь голын нэр нь Ефредис билээ. 15 Тийм бөгөөд Жахуа бурхан нь тариаланг тарих бөгөөд сахихын тулд Адаам гэдэг хүнийг суулгав. 16 Бас Жахуа бурхан нь Адаамд захин; Чи тариалангийн аливаа модноос дураараа идтүгэй! 17 Харин сайн ба мууг таниулах жимстэй модноос бүү ид! Яагаад гэвэл, хэрэв чи түүнээс идвэл, тэрхүү өдрөө чи үхэх юм.. гэж зарлиг болгов. 18 Тэгээд бурхан нь; Ганцаар байх нь сайн биш. Бүү түүний тулд нэг зохист туслагчийг үйлдсүгэй! гэж зарлиг болгов. 19 Тэгээд Жахуа бурхан нь хээрийн аливаа ан болон огторгуйн аливаа шувуудыг шорооноос бүтээгээд, тэднийг Адаамаар нэрлүүлэхийн тулд Адаамын дэргэд ирүүлэв. Тэгээд Адаамын

аливаа амьд юмыг нэрлэсэн нэр нь тэр амьтдын нэр нь болов. 20 Хүн нь мал болон огторгуйн шувууд ба хээрийн бүх ангуудад нэрийг өгөв. Тийм боловч Адаамд зохистой туслагч олдоогүй билээ. 21 Тэгээд Жахуа бурхан нь Адаамд нэг бөх нойрыг хүргэж, унтуулаад, түүний нэг хавиргыг аваад, түүний оронд махыг холбов. 22 Тэгээд бурхан нь Адаамаас авсан хавиргаар нэг эмэгтэйг бүтээгээд, Адаамд ирүүлэв. 23 Тэгээд Адаам нь; Энэ нь миний ясны яс болон махны мах билээ. Тэр нь эр хүнээс бүтээгдсэн тул Эм. гэж нэрлэе! гэж өгүүлэв. 24 Тийм учраас эр нь эцэг болон эхээ орхиж, өөрийн гэргийтэй нөхцөх юм. Тийнхүү тэр хоёр нь ганц мах болох юм. 25 Бас Адаам болон түүний гэргий хоёр хоёулаа нүцгэн байсан боловч эс ичсэн билээ.

Гуравдугаар бүлэг

1 Тийнхүү могой нь Жахуа Бурханы бүтээсэн газрын амьтан бүгдээс аргат болгоод эмд өгүүлрүүн; Бурхан нь тариалангийн аливаа модноос таныг бүү идтүгэй хэмээн зарлиг болсон биш үү? 2 гэсэнд эм нь могойд ийн өгүүлрүүн; Тариалангийн моддын жимснээс иднэ бид. 3 Зүгээр Бурхан нь тариалангийн дунд байгч модны жимсний учир ийн зарлиг болов; Та үл үхэхийн тул түүнээс бүү идэгтүн! Түүнийг ч бүү хөдөлгөгтүн! 4 хэмээн өгүүлсэнд могой нь эмд өгүүлрүүн; Та тун үхэхгүй. 5 Тэр юуны тул гэвэл, та аль өдөр түүнээс идвэл таны нүд нь нээгдэх бөгөөд, та Бурхантай адил болоод сайн ба мууг мэддэг болно хэмээн Бурхан нь мэднэ. 6 хэмээн хэлсэнд эмэгтэй нь тэр модны жимсийг идэхэд сайн бөгөөд нүдэнд сайхан ба цэцэн болохын тул хүсэмжит хэмээн үзээд түүний жимснээс аваад идэв. Бас өөрийн эрдээ өгсөнд тэр ч идэв. 7 Тийнхүү тэр хоёрын нүд нь нээгдсэнд тэд нь нүцгэн байснаа мэдээд модны навчсыг уяад хормогчийг үйлдэв. 8 Тийн бөгөөд тэд нь өдрийн сэрүүн цагт тариалангийн дотор өөд бологч Жахуа Бурханы дууг сонсоод тэр эр болон түүний гэргийг нь Жахуа Бурхны нүүрээс тариалангийн дунд нуув. 9 Тэгэхээр Жахуа бурхан нь Адаамыг дуудаж зарлиг болруун; Чи хаана байна? 10 хэмээн зарлиг болсонд айлтгаруун; Би тариалангийн дотор чиний дууг сонсоод нүцгэн байхын учир айгаад нуув. 11 хэмээн айлтгасанд тэр нь зарлиг болруун; Чиний нүцгэн байсныг чамд хэн зааваа. Чи миний хорьсон модноос идэв үү? 12 хэмээн зарлиг болсонд Адаам айлтгаруун; Чиний надад өгсөн эхнэр ийн тэр модны жимснээс надад өгсөнд би идэв. 13 хэмээн айлтгаруун; Жахуа нь эхнэрт зарлиг болруун; Чи юунд үүнийг үйлдэв. Энэ чиний үйлдсэн нь юу буюу? гэж зарлиг болсонд эхнэр нь айлтгаруун; Могой намайг мэхлэв. Тиймийн тул би идэв. 14 хэмээн айлтгасанд Жахуа Бурхан нь могойд зарлиг болруун; Чи үүнийг үйлдсэний тул хамаг мал хийгээд хээрийн хамаг ангуудаас үлэмж хараагдах болтугай! Чи өөрийн амины хамаг өдрүүдэд хэвлийгээр явах бөгөөд тоосыг идэх болно. 15 Бас би, эхнэр та хоёрын хооронд ба чиний үрс болон түүний үрсийн хооронд өшөөг тавьсугай! Тэр нь чиний толгойг хамхлах бөгөөд чи түүний өсгийг хамхлах болно. хэмээн зарлиг болов. 16 Бас эхнэрт зарлиг болруун; Би чиний жирэмсэн цагийн зовлонг ихэд үлэмжлүүлэх, чи бээр зовлонгоор хүүхдээ төрөхөд чиний дур нь чиний эрд болох бөгөөд чамайг тэргүүлэх болно. хэмээн зарлиг боловоо. 17 Бас Адаамд зарлиг болруун; Чиний эм нь зөвхөн дууг сонсоод миний

Бүү идтүгэй! хэмээн хорьсон модноос идсэний тул чиний учир газар нь хараалт болох болтугай! Чи өөрийн амины хамаг өдрүүдэд түүнээс зовлонгоор идэх болно. 18 Тэр газар нь өргөст хийгээд халгайнуудыг ургуулах бөгөөд чи хээрийн өвсийг идэх буй. 19 Чи шорооноос автсаны тул шороонд буцах бий. хэмээн зарлиг болов. 20 Тийн бөгөөд Адаам нь өөрийн эмийн нэрийг Ива хэмээн нэрлэвээ. Тэр юуны тул гэвэл, тэр нь хамаг амьтнуудын эх болохын тул билээ. 21 Бас Жахуа бурхан нь Адаам болон түүний эмийн тул арьсаар хувцсыг хийгээд тэдэнд өмсгөв. 22 Бас Жахуа бурхан нь ийн зарлиг болруун; Мана. Хүн нь сайн мууг мэдэж бидний нэгэнтэй адил болов. Одоо тэр нь гараа сунган амины модноос авч идээд наст амийг олох болуузай. хэмээн зарлиг болов. 23 Тиймийн тул Жахуа Бурхан нь шорооноос авсан хүнээ шороог урвуулахын тул Эден тариалангаас гаргав. 24 Энэ мэтээр тэр нь Адаамыг гаргаад амины модны замыг сахихын тул Эден тариалангийн зүүн этгээдэд Грубим болон эргэгч бадрангуй галт илдийг тавив.

Дөрөвдүгээр бүлэг

1 Адаам өөрийн гэргий Иватай нөхчсөнөөр Ива нь жирэмсэн болж, Кэйн төрөхөд Адаам ийн өгүүлэв; Би бурхнаас нэг эрийг хүртэв. 2 Бас тэр нь Ива нь дахиж Кэйний дүү Абицыг төрүүлэв. Эбол нь хонь хариулагч бөгөөд Кэйн нь тариачин билээ. 3 Кэйн нь нилээн хугацаа өнгөрсний дараа газрын үрсээс нэгэн тахилыг бурханд өргөв. 4 Бас Абил нь өөрийн хоньдын анхны төрсөн хориод хурга болон тэдний өөхнөөс тахил болгон өргөв. бурхан нь Абил болон түүний тахилыг таалав. 5 Кэйн болон түүний тахилыг эс таалав. Тийм учраас Кэйн нь ихэд уурлаж, царай нь ч хувирав. 6 Кэйний уурлаж байх үед Жахуа нь Кэйнд; Чи юунд уурлаж, царай чинь хувирав? Хэрэв чи сайныг үйлдвэл чи тааламжит болох биш үү? Хэрэв чи сайныг үл үйлдвэл, хилэнц нь үүдний өмнө хэвтэнэ. 7 Бас түүний дүр нь чамд болох бөгөөд чи түүнийг тэргүүлэх болно. гэж зарлиг болгов. 8 Кэйн нь өөрийн дүүтэйгээ хээр газар хэлэлцэж байгаад, Кэйн нь Абил дүүгийнхээ эсрэг босоод түүнийг алав. 9 Тийм бөгөөд бурхан нь Кэйнд зарлиг болгон Чиний Абил дүү нь хаана байна вэ? гэж асуусанд Кэйн нь; Би мэдэхгүй. Би өөрийн дүүг сахигч юм уу? 10 гэхэд бурхан нь зарлиг болгон Чи юуг үйлдэв? Чиний дүүгийн цусны дуу нь газраас надад сонсогдоно. 11 Тийм учраас чиний гараас чиний дүүгийн цусыг авахын тулд амаа нээсэн газраар чи одоо хараагдах болтугай! 12 Хэзээ чи газрыг урвуулахад тэр нь хүчээ үл өгөх юм. Чи ертөнцийн дээр төөрөгч болон хэрэгч болох болтугай! 13 гэж зарлиг болгосонд Кэйн нь Жахуад; Миний зовлон нь миний даах чадлаас их юм. 14 Чи одоо өдөр намайг энэ газрын дээрээс хөөн гаргав. Би ч чиний нүүрээс нуугдаад, ертөнцийн дээр төөрөгч болон хэрэгч болов. Тийнхүү хэн ч намайг олбол намайг алах юм. 15 гэж хэлсэнд Жахуа нь түүнд ийн Тийм учраас хэн ч Кэйнийг албал ал! Түүнээс долоон давхраар нээгдэх юм. гэж зарлиг болгов. Бас хэн ч Кэйнийг олоод, түүнийг үл алахын тулд Жахуа нь түүний дээр нэгэн тэмдгийг тавив. 16 Тийм бөгөөд Кэйн нь бурхны өмнөөс гараад, Ээдэнгийн зүүн зүгээр байгч Нод гэдэг газарт нутаглав. 17 Тийм бөгөөд Кэйний өөрийн гэргийтэй нөгцсөнөөр тэр нь жирэмсэн болж, Инаг гэдэг хүүхдийг төрүүлэв. Бас тэр нь нэгэн балгасыг эвдээд, тэр балгасыг өөрийн хөвгүүний нэр мэт Инэг гэж нэрлэв. 18

Инагт Ирад нь төрөгдөв. Ирад нь Михуяаилыг төрүүлэв. Михуяаил нь Митушаил төрүүлэв. Митушаил Ламигийг төрүүлэв. 19 Ламиг нь хоёр гэргийг биедээ авав. Нэгний нэр нь Аа Даа болон нөгөөгий нь нэрийг Цила билээ. 20 Аа Даа нь Явалыг төрүүлэв. Тэр нь цачир гэрт суугчид болон малыг баригчдын эцэг билээ. 21 Түүний дүүгийн нэр нь бил билээ. Тэр нь ятга болон биба хөгжмийн хуурдагчдын эцэг билээ. 22 Бас Цила нь Түбэлкаянийг төрүүлэв. Тэр нь гууль болон төмрийн дархан бүгдийг сургагч билээ. Түбэлкаяний охин дүүгийн нэр нь На Ама билээ. 23 Ламиг Аа Даа болон Цила хоёр гэргийдээ өгүүлэв; Ламигийн гэргийдээ! Та миний дууг сонсон, миний өгүүлэхийг чагнагтун! Яагаад гэвэл, би өөрийн шархын төлөө нэгэн хүнийг алж, өөрийн битүү шархын төлөө нэгэн залууг алсан юм. 24 Хэрэв Кэйний тулд долоон давхраар нээгдвэл, Ламигийн төлөө далан долоон давхраар нээгдэх юм. гэж өгүүлэв. 25 Жич, Адаам өөрийн гэргийтэйгээ нөгчсөнөөр тэр нь нэг хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Шид гэж нэрлэв. Яагаад гэвэл, Кэйнд алагдсан Абилын оронд бурхан нь надад өөр хөрөнгийг тавив гэж өгүүлэв. 26 Бас Шидэд нэг хөвгүүн нь төрөгдөв. Түүнийг Инос гэж нэрлэв. Тэр цагт улс нь бурхны нэрэнд эхэлж дуудав.

Тавдугаар бүлэг

1 Адаамын төрлийн бичиг нь энэ юм. Бурхан нь хүнийг бүтээх өдрөө бурхны дүрсээр түүнийг бүтээв. 2 Бас тэднийг эр болон эмээр бүтээгээд, тэднийг адистидлаад, тэднийг бүтээсэн өдрөө тэднийг Хүн. гэж нэрлэв. 3 Адаам нь зуун гучин настай болоод, өөрийн дүрс болон янзаараа нэгэн хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Шид гэж нэрлэв. 4 Бас Адаам нь Шидийн төрүүлсний дараа найман зуун жилийн туршаар суун байтлаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 5 Тийнхүү Адаамын хамаг нас нь гэвэл, тэрээр есөн зуун гучин настай болоод нөгцөв. 6 Шид нь зуун таван настай бөгөөд Инагийг төрүүлэв. 7 Шид нь Инагийг төрүүлсний дараа найман зуун долоон жилийн турш суун байтлаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 8 Тийнхүү Шидийн хамаг нас нь гэвэл, тэр нь есөн зуун арван хоёр настай болоод нөгчжээ. 9 Инаг нь ерэн настай болоод, Кэйнэныг төрүүлэв. 10 Инус нь Кэйэнийг төрүүлсний дараа найман зуун арван таван жилийн туршаар суун байтлаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 11 Тийнхүү Иногийн хамаг нас нь гэвэл, тэр нь есөн зуун таван настай болоод нөгчив. 12 Кэйнэн нь далан настай болоод, Махалалилыг төрүүлэв. 13 Кэйнэн нь Махалалилыг төрүүлсний дараа найман зуун дөчин жилийн туршаар суун байтлаа хөвгүүд болон охидыг ч төрүүлэв. 14 Тийнхүү Кэйэний хамаг нас нь гэвэл, тэр нь есөн зуун арван настай болоод нөгчив. 15 Махалалил нь жаран таван настай бөгөөд Зэридийг төрүүлэв. 16 Махалалил нь Зэридийг төрсний дараа найман зуун гучин жилийн туршаар суун байтлаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 17 Тийнхүү Махалалилын хамаг нас гэвэл, тэр нь найман зуун ерэн настай болоод нөгчөв. 18 Зэрид нь зуун жаран хоёр настай болоод Иногийг төрүүлэв. 19 Зэрид нь Иногийг төрүүлсний дараа найман зуун жилийн турш суун байтлаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 20 Тийнхүү Зэридийн хамаг нас гэвэл, тэр нь есөн зуун жаран хоёр настай болоод нөгчив. 21 Иног нь жаран таван настай болоод Митүсэлийг төрүүлэв. 22 Иног нь Митүсэлийг төрүүлсний

дараа гурван зуун жилийн турш бурхантай яван байтлаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 23 Тийнхүү Иногийн хамаг нас нь гэвэл, гурван зуун жаран таван нас билээ. 24 Иног нь бурхантай явсан билээ. Яагаад гэвэл, бурхан нь түүнийг авав. 25 Митүсэл нь зуун наян долоон настай болоод Ламигийг төрүүлэв. 26 Митүсэл нь Ламигийг төрүүлсний дараа долоон зуун наян хоёр жилийн турш суун байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 27 Тийнхүү Митүсэлийн хамаг нас нь гэвэл, тэр нь есөн зуун жаран есөн настай болоод нөгчив. 28 Ламиг нь зуун наян хоёр настай болоод нэг хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Нуах гэж нэрлээд ийн өгүүлэв. 29 Энэ нь Жахуагийн хараасан газраас бидний гарын үйл болон зовлонгийн тухай биднийг егүүтгэх буй. 30 Ламиг нь Нуаг төрүүлсний дараа таван зуун ерэн таван жилийн турш суун байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 31 Тийнхүү Ламигийн хамаг нас нь гэвэл, тэр долоон зуун далан долоон настай болоод нөгчив. 32 Нова нь таван зуун настай болоод Шэм болон Хам ба Яфидыг төрүүлэв.

Зургадугаар бүлэг

1 Тийм бөгөөд хүмүүсийн дэлхий дээр үржиж эхлэхэд, тэдэнд охид нь төрөгдөв. 2 Бас бурхны хөвгүүд нь хүний охидыг үзэсгэлэнтэй гэж үзээд, өөрийн намаг сонгогсдоос биедээ гэргийдийг авав. 3 Тийм бөгөөд Жахуа нь зарлиг болруун; Миний тодотгол нь хүмүүсийн дотор үл тэмцэх буй. Яагаад гэвэл, тэд нь махбод мөн. Бас тэдний нас нь зуун хорин нас болох юм. 4 Тэр үед дэлхий дээр өндөр биетэй чадалтан буй билээ. Бас түүнээс хойно бурхны хөвгүүдийн хүний охидод явснаар тэдэнд хүүхэд нь төрөгдөөд, хүчтэн болон эрт цагийн алдартан боллоо. 5 Тийм бөгөөд Жахуа нь хүний хилэнцийг дэлхий дээр их бөгөөд түүний санаа болон сэтгэлийг өдөр бүр ганцхан муу байсныг үзээд, 6 Жахуа нь хүнийг дэлхий дээр бүтээсэндээ гэмшин, зүрхээрээ гомдов. 7 Тийм бөгөөд Жахуа нь зарлиг болруун; Би өөрийн бүтээсэн хүнийг дэлхийн дээрээс гарган, хоослох гэвэл, хүн болон мал ба хорхой болон огторгуйн шувуудыг хоосруулах юм. Яагаад гэвэл, би тэдгээрийг боловсруулсандаа гэмшинэ. 8 Нова нь Жахуагийн өмнө хайрыг олов. 9 Новагийн төрлүүд нь; Нова нь өөрийн үед хийгээд шулуун хүц агаад бурхантай явлаа. 10 Бас Нова нь Шим, Хам, Зэпид гэдэг гурван хөвгүүдийг төрүүлэв. 11 Харин дэлхий нь бурхны өмнө доройтоод, дэлхий ч дээрэмдлэгээр дүүргэгдсэн билээ. 12 Тийм байхдаа бурхан нь дэлхийн доройтсныг үзэв. Дэлхий дээр хамаг махбод нь өөрийн явдлыг доройтуулсан билээ. 13 Тийм бөгөөд бурхан нь Новад зарлиг болруун; Миний өмнө хамаг махбодын эцэс нь ирсэн юм. Яагаад гэвэл, тэднээр дэлхий хороор дүүргэгдсэн учир би тэдгээрийг дэлхийтэй хоосруулах юм. 14 Чи биедээ давирхайтай модоор нэг онгоц хий! Тэр онгоцны дотор тасалгаануудыг үйлдэгтүн! Дотор болон гадрыг нь давирхайгаар давирхайдан, хийгтүн! 15 Чи түүнийг энэ мэтээр хийвэл, түүний урт нь гурван зуун тохой болон өргөн нь тавин тохой ба өндөр нь гучин тохой байх болтугай! 16 Бас онгоцондоо цонх хийж оройгоосоо нэг тохой бүтээн үйлд! Жич, онгоцонд үүдийг үйлдэж, түүний этгээдэд тавин үйлд! Бас доорхи ба хоёр ба гуравдугаар давхрыг үйлд! 17 Тийнхүү Мана. би дэлхий дээр ямар ч амьд амьсгалтай махбодыг огторгуйн доороос үхүүлэхийн тулд дэлхийн дээр усан үерийг оруулах юм. Дэлхий дээр байгч бүгд нь үхэх бий. 18 Зүгээр

чамтай би өөрийн тогтоолыг тогтоох бий. Тийм бөгөөд чи болон чиний хөвгүүд ба чиний гэргий нь онгоцонд орогтун! 19 Жич, хамаг амьтнаас эр эм хосуудыг амьдаар нь байлгахын тулд онгоцонд хамт оруул! 20 Зүйл бүрийн шувууд болон зүйл бүрийн дөрвөн хөлтөн ба зүйл бүрийн хорхойнуудаас амьд байхын тулд ямар ч зүйлийн амьтнаас хосууд чамтай орох болтугай! 21 Бас ямар ч идэх идээг хурааж, биедээ хадгал! Тэр нь чамд болон тэдэнд идээ болох юм. гэж зарлиг болов. 22 Энэ мэтээр Нова нь үйлдэв. Бурхны түүнд аль мэт тэр нь түүнчлэн үйлдэв.

Долдугаар бүлэг

1 Бас Жахуа нь Новад зарлиг болруун; Чи болон чиний гэр бүлийнхэн бүгд онгоцонд орогтун! Яагаад гэвэл, би энэ үед миний өмнө чиний зөв байхыг үзсэн юм. 2 Ариун дөрвөн хөлтний аливаа зүйлээс долоо долоогоор эр ба эмүүдийг биедээ аваад, ариун бус дөрвөн хөлтний аливаа зүйлээс эр эм хосуудыг ав! 3 Бас огторгуйн шувуудаас долоо долоон эр ба эмүүдийг ав! Яагаад гэвэл, хамаг дэлхийн дээр үрийг амьдаар байлгахын тулд билээ. 4 Яагаад гэвэл, эндээс долоон хоногийн болсонд, би дөчин өдөр болон дөчин шөнө бороог оруулж, миний аливаа бүтээсэн амьтныг газар дээрээс хоосруулах бий. гэж зарлиг болов. 5 Тийнхүү Нова нь бурхны түүнд захисан мэтээр үйлдэв. 6 Дэлхий дээр усан үер болоход, Нова нь зургаан зуун настай байлаа. 7 Энэ мэтээр Нова болон түүний хөвгүүд ба түүний гэргий болон бэрүүд нь усны үерийн шалтгаанаар онгоцонд оржээ. 8 Бас ариун дөрвөн хөлтний аливаа зүйл болон ариун бус дөрвөн хөлтөн, ба шувууд болон дэлхий дээр мөлхөгч хорхойн аливаа зүйлээс эр эм хосууд онгоцонд Новатай оров. 9 Бурханы Новад захисан ёсоор түүнчлэн болов. 10 Тийм бөгөөд долоо хоног болсонд, үерийн усууд нь дэлхий дээр байлаа. 11 Новагийн зургаан зуу дахь насны хоёр дахь сар болон тэрхүү сарын арван долоо дахь өдөр болсонд, тэр өдөр их гүний хамаг булгууд нь дэлбэрсэн бөгөөд огторгуйн цонхнууд ч нээгдсэн билээ. 12 Тийнхүү бороо нь дөчин өдөр болон дөчин шөнө дэлхий дээр орон байв. 13 Тэр өдөр Нова болон Новагийн Шэм ба Хэм болон Зэпид хөвгүүд ба Новагийн гэргий болон түүний гурван бэрүүд нь онгоцонд оров. 14 Тэд болон ангийн зүйл бүр ба зүйл бүрийн мал болон дэлхий дээр мөлхөгч зүйл бүрийн хорхой ба зүйл бүрийн жигүүртэн шувууд оролцов. 15 Аливаа амьд амьсгалтай махбодоос хосууд онгоцон дотор Новатай оров. 16 Онгоцонд Бурханы түүнд захисан мэтээр хамаг махнаас эр эм хоёроор оров. Тийм бөгөөд Жахуа нь түүнийг хаав. 17 Тийм бөгөөд үер нь дөч хоногийн турш дэлхий дээр байлаа. Бас уснууд нь нэмсээр байгаад, онгоцыг дааж, дэлхий дээгүүр өргөсөн билээ. 18 Бас уснууд нь нэмж, дэлхий дээр маш их болов. Харин онгоц нь усны дээр явсан билээ. 19 Тийнхүү уснууд нь дэлхий дээр маш ихэд нэмэгдээд, бүхэл огторгуйн доор байгч уулсыг бүрхэв. 20 Уснууд нь уулсаас дээш арван таван тохойн төдий гараад, тэднийг бүрхэв. 21 Тийм бөгөөд дэлхийн дээр хөдлөгч махбод шувууд болон мал ба ан болон дэлхий дээр мөлхөгч хорхой ба хүн бүгдээр үхэв. 22 Энэ мэтээр дэлхийн дээр байгч хамаг амьтан хүн болон мал ба хорхой болон огторгуйн шувууд нь хоосруулагдав. 23 Гагцхүү Нова болон түүнтэй онгоцон дотор байгчид

нь үлдэв. 24 Энэ мэтээр уснууд нь дэлхий дээр зуун тавин өдрийн турш их байлаа.

Наймдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Бурхан нь Нова болон түүнтэй хамт онгоцонд байгч аливаа амьтан болон малыг санаж, Бурхан нь дэлхий дээр нэг салхийг салхилуулав. Тийм бөгөөд уснууд нь тогтов. 2 Бас гүний булгууд болон огторгуйн цонхнуудын хаагдсанаар, огторгуйгаас бороо зогсов. 3 Бас уснууд нь газрын дээрээс буцсаар татарчээ. Зуун тавин өдрийн эцэст уснууд нь татарсан билээ. 4 Тийм бөгөөд долоо дахь сарын арван долоо дахь өдрөө онгоц нь Арарад гэдэг уулны дээр зогсов. 5 Уснууд нь арав дахь сар болтол татарсаар байсанд, арав дахь сарын нэг дэхь өдөр уулын орой нь харагдах болов. 6 Тийм бөгөөд дөчин хоногийн эцэст Нова нь өөрийн хийсэн онгоцны цонхыг нээгээд, нэг хэрээг гаргав. 7 Тэр нь гараад, дэлхий дээрх уснуудыг хаттал, нааш цааш яван байв. 8 Бас уснууд нь газраас татарч уу? гэдгийг үзэхийн тулд тэр нь нэгэн тагтааг гаргав. 9 Тэр тагтаа нь өөрийн хөлийн уланд түших газрыг эс олоод, Новад онгоцондоо буцав. Яагаад гэвэл, уснууд нь хамаг газрын дээр байгаа билээ. Тийнхүү Нова нь гараа сунгаж, тагтааг нь биедээ авч, онгоцонд оруулав. 10 Тийм бөгөөд тэр нь өөр долоон өдөр хүлээгээд, тагтааг онгоцноос дахин гаргав. 11 Тэр тагтаа нь үдшийн үед алгандаа тосны модноос түүсэн навчтай түүнд ирэв. Үүгээр Нова нь уснууд дэлхий дээрээс татрав гэж мэдэв. 12 Бас тэр нь өөр долоон өдөр хүлээгээд, тагтааг тавьсанд, тэр нь дахин эс ирэв. 13 Энэ мэтээр зургаан зуун нэг жилийн нэг дэхь сарын нэг дэхь өдөр уснууд нь дэлхий дээрээс хатав. Нова нь онгоцны бүтээлгийг аваад, газрын нүүрийг хатсаныг үзэв. 14 Тийм бөгөөд хоёр дахь сарын хорин долоо дахь өдөр газар нь хуурай болов. 15 Тийм бөгөөд Бурхан нь Новад зарлиг болруун; 16 Чи болон чамтай чиний гэргий ба чиний хөвгүүд болон чиний бэрүүд нь онгоцноос гарагтун! 17 Бас чамтай байгч аливаа зүйлийн амьтан шувууд болон дөрвөн хөлтөн, ба газар дээр мөлхөгч хорхойнууд өөртэйгөө гарган, тэдгээр нь газар дээр үржин олон болох болтугай! 18 гэж зарлиг болгосонд Нова болон түүний хөвгүүд ба түүний гэргий болон түүний бэрүүд нь түүнтэй гарав. 19 Бас аливаа ан болон хамаг мөлхөгч ба хамаг шувуу газрын дээр ямар ч хөдлөгч нь өөрийн зүйлийн ёсоор онгоцноос гарав. 20 Тийм бөгөөд Нова нь нэг тахилын ширээг Бурханд өргөөд, аливаа ариун малаас болон аливаа ариун шувуудаас аваад, ширээн дээр шатаасан тахилуудыг өргөв. 21 Тийнхүү Бурхан нь түүний тахилыг таалж аваад, зүрхэндээ ийн зарлиг болруун; Хүний санаа нь залуу наснаас муу боловч би хүний төлөө үүнээс хойш газрыг үл харааж, миний үйлдсэн мэт хамаг амьтныг дахин үл таслах юм. 22 Ертөнцийн хамаг байх цагийн туршаар цацах болон хатах ба хүйтэн болон халуун ба зун болон өвөл ба өдөр болон шөнө нь үгүй үл болох бий. гэж зарлиг болжээ.

Есдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд бурхан нь Нова болон түүний хөвгүүдийг адислаж, тэдэнд зарлиг

болруун; Та үрстэй болон үржиж, дэлхийг дүүргэгтүн! 2 Бас танаас аюул болон эмээл нь газрын аливаа ангийн дээр болон огторгуйн аливаа шувуудын дээр ба газрын дээр байгч аливаа мөлхөгчийн дээр болон дэлхийн аливаа загаснуудын дээр болох болтугай! Тэд нь таны гарт өгөгдсөн юм! 3 Аливаа амьд хөдлөгч нь та нарт идээ болох юм. Би тэр бүгдийг нуга мэт танд өгсөн юм. 4 Махыг түүний амины цустай бүү идэгтүн! 5 Бас таны амины цусыг би аливаа амьд юмнаас нэхэн, аливаа хүнээс болон хүний ах дүүгээс би хүний амийг нэхэх юм. 6 Хүний цусыг асгагч түүний цус нь хүнд асгагдах бий. Яагаад гэвэл, бурхан нь өөрийн зангаар хүнийг бүтээв. 7 Харин та үрстэй болж үржээд, дэлхий дээр олон болж, түүний дээр үржигтүн! гэж зарлиг болов. 8 Бас бурхан нь Нова болон түүний хөвгүүдэд 9 Би тантай болон танаас хойно таны үрстэй ба 10 тантай байгч шувуу болон мал ба газрын ангийн аливаа зүйлийн амьтан ба онгоцноос гаргагчид болон хамаг амьтантай миний тогтоолыг тогтооно. 11 Бас хамаг махбод нь үерийн усаар дахин үл таслагдах бөгөөд дэлхийг сөнөөх үер дахин үл болно гэж тантай миний тогтоолыг тогтооно. гэж зарлиг болов. 12 Бас бурхан нь зарлиг болруун; Миний болон таны ба тантай байгч аливаа зүйлийн амьтны хооронд миний мөнх тогтоох тогтоолын тэмдэг нь гэвэл, 13 би үүлний дотор өөрийн солонгыг тавина. Тэр нь миний болон дэлхийн хооронд байгч тогтоолын тэмдэг болох юм. 14 Тийнхүү миний болон таны ба махны хамаг амьтны хооронд байгч миний тогтоолыг би санах бөгөөд уснууд нь үер болж, хамаг амьтныг дахин үл эвдрүүлэх юм.

* Verse 15 missing.

16 Тэр солонго нь үүлний дотор байх бөгөөд бурхны болон дэлхийн аливаа махбодын хамаг амьтны хооронд байгч миний мөнх тогтоолыг санахын тулд би түүнийг үзэх болно. 17 Энэ нь миний болон дэлхийн дээр байгч хамаг махны хооронд миний тогтоосон тогтоол билээ. гэж бурхан нь Новад зарлиг болов. 18 Онгоцноос гарсан Новагийн хөвгүүд гэвэл, Шэм болон Хам ба Зэпид билээ. Хам нь Ханаваны эцэг билээ. 19 Энэ гурав нь Новагийн хөвгүүд билээ. Тэднээс хамаг дэлхий нь нутаглагдсан билээ. 20 Тэр үед Нова нь тариачин болоод, нэгэн үзмийн цэцэрлэгийг тарив. 21 Тийм бөгөөд тэр нь үзмийн ундаанаас ууж, согтоод, майхан дотор нүцгэн хэвтэв. 22 Тийнхүү Ханаваны эцэг Хам нь өөрийн эцгийн нүцгэн байгааг үзээд, өөрийн ах дүү хоёртоо хэлэв. 23 Тийм бөгөөд Шэм болон Зэпид нь хувцас аваад, хоёулаа мөрний дээр тавиад, гэдрэг явж, өөрийн нүцгэн эцгийг бүтээв. Тэд нь гэдрэгээ явснаар өөрийн эцгийн нүцгэнийг эс үзэв. 24 Тийм бөгөөд Нова нь өөрийн үзмийн ундаанаас сэрээд, өөрийн дунд хөвгүүний үйлдсэнийг мэдээд, өгүүлэв 25 Ханаван нь хараагдах болтугай! Тэр нь өөрийн ах дүү нарт боолын боол болох буй. 26 Бас тэр нь өгүүлруун; Шэмийн Жахуа бурхан нь магтагдах болтугай! Ханаван нь тэдний боол болох гэж өгүүлэв. 27 Бурхан нь Зэпидийг зөвтгөх бөгөөд тэр нь Шэмийн майхнуудын дотор суух юм. Ханаван нь тэдний боол болно. гэж өгүүлэв. 28 Нова нь үерээс хойш гурван зуун тавин жил амьдрал. 29 Тийнхүү Новагийн хамаг нас нь гэвэл, тэр нь есөн зуун тавин настай болоод нөгчив.

Аравдугаар бүлэг

1 Новагийн хөвгүүд Шэм болон Хэм ба Зэпид нарын төрлүүд нь гэвэл, үерийн дараа хөвгүүд нь тэдэнд төрөгдөв. 2 Зэпидийн хөвгүүд гэвэл, Кэмир болон Магог ба Мадай болон Жаван ба Түбил болон Мишиг ба Тирас билээ. 3 Кэмирийн хөвгүүд нь; Аскинас болон Ринэть ба Түгарлиа билээ. 4 Явяны хөвгүүд нь; Алеша болон Таршаш ба Ктэм болон Дуданэм билээ. 5 Эдгээрээр улсын нутгууд нь газруудаар хуваагдав. Өөрийн улсын дотор хэн хэн өөрийн хэлтэй ба өөрийн төрөлтэй болов. 6 Хэмийн хөвгүүд нь; Көш болон Мицрайем ба Пуд болон Ханаван билээ. 7 Күсийн хөвгүүд нь; Шиба болон Хавила ба Сабда болон Равама ба Сабтих билээ. Равамагийн хөвгүүд нь; Шэба болон Дитан билээ. 8 Күс нь Нимрудыг төрүүлэв. Тэр нь дэлхий дээр тэргүүлэн хүчтэй болов. 9 Тэр нь Жахуагийн өмнө хүчтэй анчин билээ. Тийм учраас; Жахуагийн өмнө хүчит анчин Нимруд мэт. гэж өгүүлэгдсэн билээ. 10 Түүний эзэлгүрэний эхэн нь Шинар газрын Бабил болон Ирэг ба Акад болон Гэлни билээ. 11 Тэр орноос Ашур нь гараад, Ниниви болон Рехоботир ба Кэлелийг үүдэн 12 бас Ниниви ба Килах хоёрын хооронд байгч Ресинийг үүдэв. Тэр нь их балгасад билээ. 13 Мицрайемаас Лүди болон Анами ба Лихабил болон Нафтухи ба 14 Падруси болон Каслүхим ба Кавтурим улс нь гарав. Каслүхим улсаас Пилишти улс нь гарав. 15 Ханаван нь Сидан гэдэг их хөвгүүн болон Хид ба 16 Жмбүши болон Амури ба Гиргаши болон Хиви ба 17 Арки болон Сини ба Арвади болон Цимори ба Хамати нарыг төрүүлэв. 18 Түүнээс хойш Кинааны төрлүүд нь тархагдсан билээ. 19 Ханаваны газрын хязгаар гэвэл, Гирард очихоор Цидоноос Газа хүртэл болон Содом болон Комура ба Адма болон Зибуймд очихоор Лэшэ хүртэл билээ. 20 Эд нь өөрийн хотын ёсоор болон өөрийн хэлний ёсоор ба өөрийн улсын дотор байгч Хэмийн хөвгүүд билээ. 21 Бас өөрийн хамаг хөвгүүдийн эцэг болон Зипэдийн ах болсон Шэмд хөвгүүд нь төрөгдөв. 22 Шэмийн хөвгүүд гэвэл, Илам болон Ашур ба Арфагсад болон Лүд ба Арам бөлгөө. билээ. 23 Арамын хөвгүүд нь Үзэ болон Күл ба Хитэр болон Мэс билээ. 24 Арфагас Ибэрт хоёр хөвгүүн төрөгдөв. 25 Нэгний нэр нь Пилэн билээ. Яагаад гэвэл, тэр үед дэлхий нь хуваагдав. Түүний дүүгийн нэр нь Цогтон билээ. 26 Цогтон нь Алмудэд болон Жиба ба 27 Хэдүрэм болон Үзэл ба 28 Дигла болон Убал ба Абимайл болон Шлба ба 29 Упир болон Хавила ба Зебэдийг төрүүлэв. Эд нар нь бүгд Цогтоны хөвгүүд билээ. 30 Тэдний нутаг нь гэвэл, Мишэгээс зүүн зүйн Шипир гэдэг ууланд хүрэв. 31 Эд нь өөрийн хот болон өөрийн хэлний ёсоор ба өөрийн улсуудын дотор байгч Шэмийн хөвгүүд билээ. 32 Эд нь өөрийн төрлүүд болон улсуудын ёсоор Новагийн хөвгүүдийн хотод билээ. Тэднээс үерийн дараа улсууд нь дэлхий дээр саллаа.

Арван нэгдүгээр бүлэг

1 Тэр үед дэлхий ганц хэлтэй болон ганц үгстэй байлаа. 2 Тийм бөгөөд тэдгээр нь зүүн зүгээс нүүж, Шинар газарт нэг талыг олоод, тэнд суужээ. 3 Бас тэдгээр нь өөр зуураа өгүүлрүүн; Бид тоосго хийж, тэднийг галаар түлье! гэж өгүүлэлдэв. Тэдэнд чулууны оронд тоосго байгаа бөгөөд шавах шавар байгаа билээ. 4 Бас

тэдгээр нь өгүүлрүүн; Бид өөрийн төлөө нэгэн хот нэг асрыг босгохоор явъя!
Түүний орой нь огторгуйд хүрэх болтугай! Бид хамаг дэлхийн нүүрний дээр үл тархагдахын тулд биеэ нэртэй болгоё гэж өгүүлэлдэв. 5 Тийм бөгөөд Жахуа нь хүний хөвгүүдийн босгосон хот болон асрыг үзэхийн тулд буугаад, 6 Жахуа нь зарлиг болруун; Мана, энэ улс нь ганц буй бөгөөд тэдний хэл нь ганц юм. Тийм байтал, тэдгээр нь энэ мэтийг эхэлж, үйлдэн одоо юуг үйлдэхээ сэтгэснээс үл зогсох буй за. 7 Тийм учраас тэднийг өөрийн хэлийг үл сонсгохын тулд бид буугаад, тэдний хэлийг өөрчлөө! гэж зарлиг болов. 8 Тийм бөгөөд Жахуа нь тэднийг хамаг дэлхийн нүүрэнд тэдгээрийг ч тараав. Тэд хотыг босгохоо зогсов. 9 Тийм учраас түүний нэр нь Бэбил гэж нэрлэгдэв. Яагаад гэвэл, Жахуа нь тэнд бүхэл дэлхийн хэлийг өөрчлөөд, тэндээс бурхан нь тэднийг хамаг дэлхийн нүүрэнд тараав. 10 Шэмийн төрлүүд нь гэвэл ийн; Үерээс хойш хоёр жилийн дараа Шэм нь зуун настай болоод Арфагсадыг төрүүлэв. 11 Шэм нь Арфагсадыг төрүүлээд, таван зуун жилийн турш амьдран байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 12 Арфагсад нь гучин таван настай болоод Салийг төрүүлэв. 13 Арфагсад нь Салийг төрүүлснээс хойш дөрвөн зуун гурван жил амьдран байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 14 Сала нь гучин настай болоод Ибэрийг төрүүлэв. 15 Сала нь Ибэрийг төрүүлсний хойш дөрвөн зуун гурван жилийн турш амьдран байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 16 Ибэр нь гучин дөрвөн настай болоод Пилигийг төрүүлэв. 17 Ибэр нь Пилигийг төрүүлснээс хойш дөрвөн зуун гучин жил амьдран байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 18 Пилиг нь гучин настай болоод Риүг төрүүлэв. 19 Пилиг нь Риүг төрүүлснээс хойш хоёр зуун есөн жилийн турш амьдран байхдаа хөвгүүд охидыг төрүүлэв. 20 Риү нь гучин хоёр настай болоод Сэрүг төрүүлэв. 21 Риү нь Сэрүг төрүүлснээс хойш хоёр зуун долоон жилийн турш амьдран байхдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 22 Сэрүг нь гучин настай болоод Нахурыг төрүүлэв. 23 Сэрүг нь Нахурыг төрүүлснээс хойш хоёр зуун жилийн турш амьдрахдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 24 Нахур нь хорин есөн настай болоод Тираг төрүүлэв. 25 Нахур нь Тираг төрүүлснээс хойш зуун арван жилийн турш амьдрахдаа хөвгүүд болон охидыг төрүүлэв. 26 Тира нь далан настай болоод Абрам болон Нахур ба Хараныг төрүүлэв. 27 Тирагийн төрлүүд гэвэл ийн; Тэр нь Абрам болон Нахур ба Хараныг төрүүлэв. Харан нь Лодыг төрүүлэв. 28 Харин Харан нь Халдийн өр гэдэг өөрийн төрсөн газраа өөрийн Тира эцгээс өмнө нөгчив. 29 Абрам болон Нахур нь гэргийдийг авав. Абрамын гэргийн нэр нь Милха билээ. Милха болон Исха нь Хараны охид билээ. 30 Сарай нь хүүсэр болоод үргүй билээ. 31 Тийм бөгөөд Тира нь өөрийн Абрам хөвгүүн болон өөрийн Харан хөвгүүний Лод хөвгүүн Абрамын гэргий болсон өөрийн Сарай бэрийг аваад, Ханаван газарт очихын тулд Халдийн өрөөс гараад, Харанд хүрээд, тэнд нутаглав. 32 Тира нь хоёр зуун таван настай болоод Харанд нөгчив.

Арван хоёрдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Жахуа нь Абрамд зарлиг болруун; Чи өөрийн газар болон өөрийн төрлүүд ба эцгийн гэрээс гараад, миний чамүзүүлэх газарт оч! 2 Би чамайг их улс болгон үйлдэж чамайг адистидлан, чиний нэрийг их болгоно. Тийнхүү чи адистид

болох буй. 3 Чамайг адистидлагчдыг би адистидлах, чамайг доромжлогчдыг би хараах юм. Бас чамаар хамаг улсууд нь адистидлагдах буй. гэж зарлиг болов. 4 Тийнхүү Абрам нь Жахуагийн зарлиг болгосон ёсоор явав. Түүнтэй Лод ч явав. Абрам нь Харанаас гарахад, далан таван настай байлаа. 5 Энэ мэтээр Абрам нь өөрийн Сарай гэргий болон өөрийн дүүгийн хөвгүүн Лод ба өөрийн хураасан хамаг эд таваар болон Харанд болгосон боолуудыг аваад Ханаванд очихоор гараад, Ханаванд хүрэв. 6 Тийм бөгөөд Абрам нь Шихимийн орон гэвэл, Тирибинта гэдэг модны орон хүртэл хүрэв. Тэр үед Ханаван улс нь тэр газарт байсан билээ. 7 Тийм бөгөөд Жахуа нь Абрамд үзүүлэгдээд, зарлиг болруун; Би чиний үрсэд энэ газрыг өгье! гэж зарлиг болов. Тэнд Абрам нь түүнд үзүүлэгдсэн Жахуад нэгэн тахилын ширээг өргөв. 8 Тэндээс тэр нь нүүж, Битилийн зүүн зүгт нэгэн ууланд очоод, гэрээ тэнд барив. Битил нь баруун зүгт байгаа бөгөөд Ай гэдэг зүүн зүгт байгаа билээ. Бас тэр нь тэнд ч Жахуад нэг тахилын ширээг өргөөд, Жахуагийн нэрэнд дуудав. 9 Тийм бөгөөд Абрам нь нүүж, өмнө зүгт очив. 10 Тэр нутагт зуд болсонд Абрам нь Египет нутагт суухаар явав. Яагаад гэвэл, зуд нь тэр нутагт бэрх билээ. 11 Тийм бөгөөд Египетэд шатардаад, тэнд орох болсонд Сарай гэргийдээ өгүүлрүүн; Чи сайхан үзэсгэлэнтэй эхнэр юм гэж би мэднэ. 12 Тийм бөгөөд Египетийн улс нь чамайг үзээд Тэр нь түүний гэргий юм. гэж өгүүлээд намайг алж, чамайг амьд байлгах юм. 13 Чи миний охин дүү юм гэж өгүүлж хайрла! Тэгвэл чиний тухай надтай сайн болох бөгөөд чиний төлөө миний амьд байх юм. 14 Тэгээд Абрамыг Египетэд орсонд Египетийн улс нь тэр эхнэрийг маш үзэсгэлэнт гэж үзэв. 15 Бас Вораугийн ноёд нь түүнийг үзээд, Ворауд сайшаасанд тэр эхнэр нь Вораугийн гэрт автав. 16 Тэр нь түүний учир Абрамд сайныг үйлдэв. Бас түүнд хоньд болон үхрүүд ба азарга илжгүүд болон боолууд ба шивэгчид болон гүү илжигэд ба тэмээнүүд билээ. 17 Зүгээр Жахуа нь Абрамын Сарай гэргийн тухай Вораус болон түүний гэр бүлийн их зовлонгоор зовоов. 18 Тийм бөгөөд Ворау нь Абрамыг дуудан өгүүлрүүн; Энэ чиний надад үйлдсэн нь юу вэ? Энэ нь миний гэргий юм. гэж чи яагаад надад эс мэдүүлэн 19 миний охин дүү гэж яагаад өгүүлэв? Би түүнийг гэргий болгон авч чадах билээ. 20 Бас Вораугийн түүний тухай хүмүүстээ захиснаар тэдгээр нь түүний гэргий ба түүний хамаг эд таваарыг тэндээс илгээв.

Арван гуравдугаар бүлэг.

1 Тийн бөгөөд Абрам хийгээд түүний гэргий ба түүнд юу байлаа. Бас түүнтэй Лод нь Египетээс гараад өмнө зүгт одов. 2 Абрам нь мал хийгээд мөнгө ба алтнууд маш баян билээ. 3 Тийн бөгөөд тэр нь явж өмнө зүгээс Битилд одоод эхэнд гэрээ баригдсан, Ай хийгээд Битил хоёрын хооронд байгч газарт гэвэл, 4 эхэнд тахилын ширээг өргөсөн газартаа ирээд тэнд Абрам нь Жахуа бурхны нэрэнд дуудав. 5 Бас Абрамтай явсан Лодод хонь болон үхэр ба гэрүүд буй билээ. 6 Тийн бөгөөд тэдний хамтаар суухыг газар нь эс багтаав. Тэдний эд таваарын их болсны тул хамтаар сууж эс чадсан билээ. 7 Бас Абрам малын малчид болон Лодын малын малчид нь өөр зуураа эвгүй билээ. Тэр цагт Хануаны хийгээд Парижийн улс нь тэр газарт суусан билээ. 8 Тийн бөгөөд Абрам нь Лодод өгүүлрүүн; Бид ах дүү нар мөн.

Тиймийн тул бид хоёрын хооронд болон миний малчид ба чиний малчдын хооронд эв үгүй үл болох болтугай! 9 Хамаг газар нь чиний өмнө биш үү? Чи надаас салж хайрла! Хэрэв чи зүүн этгээдэд оох болбол баруун этгээдэд одох болно.. 10 гэж өгүүлсэнд Лод нь нүдээрээ ширтэж Иорданы хамаг талын сайтар услагдсаныг үзэв. Тэр гэвэл Жахуа бурхны Содом болон Гомура хэмээгчдийг эвдрүүлэхээс урьд Зувар гэдэгт одох замаар хаана ч Жахуагийн тариалан мэт болон Египет газар мэт билээ. 11 Тийн байхад Лод нь Иорданы хамаг талыг сонгоод зүүн тийш явав. Энэ мэтээр тэд нь өөр өөрөөсөө салалцав. 12 Абрам нь Ханаван газарт суув. Лод нь талын балгадад сууж өөрийн гэрийг Содомын ойр барив. 13 Содомын улс нь Жахуагийн өмнө маш муу хийгээд хилэнцэт билээ. 14 Тийн бөгөөд Лодын Абрамаас хагацсны хойно Жахуа нь Абрамд зарлиг болруун; Чи ширтэн үйлд. 15 Тэр юуны тул гэвэл, чиний хамаг үзэх газрыг би чамд болон чиний үрсэд мөнхөд өгөх буй. 16 Бас би чиний үрсийг газрын тоос мэт болгох бий. Тийнхүү аль хэн газрын тоосыг тоолж чадвал чиний үрс нь ч тоологдох болно. 17 Тийн бөгөөд босож энэ газрын урт болон өргөнийг алсдаж од. Би түүнийг чамд өгөх буй. гэж зарлиг болов. 18 Тийн бөгөөд Абрам нь нүүж, Хибрүнд байгч Мамарийн Тирибинта модонд хүрээд суув. Тэнд тэр нь Жахуад нэг тахилын ширээг өргөв.

Арван дөрөвдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд Шинарын Амрапил хаан болон Илсарын Ариюуг хаан ба Иламын Кидурлаума хаан болон улсуудын Тидал хаадын үед 2 эдгээр хаад нь Содомын Бира хаан болон Гомурагийн Бирма хаан ба Адмагийн Шиног хаан болон Зибуймын Шимибэр хаан ба Била эсвэл Зовар гэгчийн хаадтай дайралцав. 3 Эд бүгдээр давсан далай болсон Сидимын талын тэнд цуглалцав. 4 Тэд нь арван хоёр жилийн турш Кидурлаумад зарагдаад, арван гурав дах жилдээ урвав. 5 Тийм бөгөөд Кидурлаумад болон түүнтэй байгч хаад нь арван дөрөв дэхь жилдээ ирээд, Аштируд Кранайм гэдэг газар Рипаймууд болон Хам газарт Зүжимүүд ба Шава Криятиймд Имимуудыг таслав. 6 Бас тэд нь Хоритныг тэдний Сийр уулнаас говийн ойр байгч Илпаран хүртэл таслав. 7 Тийм бөгөөд тэд нь буцаж, Цамшипд эсвэл Кадис хүртэл ирээд тэнд Амалигтны бүхэл газар болон Хажижун Тамарт суугч Амуританыг ч таслав. 8 Тиймхүү Содомын хаан болон Гомурагийн хаан ба Адамын хаан болон Зибуймын хаан ба Била эсвэл Зоварын хаад нь гараад 9 Иламын Кидурлаума хаан болон улсуудын Тидал хаан ба Шинарын Амрапил хаан болон Иласарын Аридог хаан дөрвөн хаад нь таван удаа Шидимийн бэлийн дотор дайнд оролцов. 10 Шидимийн бэлийн дотор олон шавартай нүх буй билээ. Содом болон Гомурагийн хаад нь тэнд зугтааж, унагаагдав. Үлдэгсэд нь уул руу зугтаав. 11 Бас тэд нь Содом болон Гомурагийн эд таваар болон хамаг хүнснүүдийг аваад харив. 12 Бас тэд нь Абрамын дүүгийн Лод хөвгүүн болон түүний эд таваарыг авч явав. Тэр нь Содомд суусан билээ. 13 Тийм бөгөөд зугтаагсдаас нэг нь ирээд Ибэри Абрамд мэдүүлэв. Тэр нь Амуритны Анирын ах болон Ишхүлийн Мамари ахын Тирибинта модны газарт суусан билээ. Тэд нь Абрамтай эвтэй билээ. 14 Тийм бөгөөд Абрам нь өөрийн дүүгийн нүүлгэгдсэнийг сонсоод, өөрийн гэрт

төрөгдсөн ба сургасан гурван зуун арван найман хүмүүсийг цуглуулаад, тэднийг Дэн хүртэл нэхэв. 15 Тийм бөгөөд тэр болон түүний боолууд нь тэдний тус шөнөөр салалцаад, тэднийг дийлээд, Дамаскийн зүүн зүгт байгч Хуба хүртэл нэхэв. 16 Бас тэр нь хамаг эд таваарыг хариулан, өөрийн Лод дүү болон түүний эд таваар ба эхнэрүүд болон хүмүүсийг ч хариулав. 17 Тийм бөгөөд түүний Шавагийн бэл эсвэл хааны бэл хүртэл Кидурлаурма болон түүнтэй байсан хаадыг дийлээд, харьсны дараа Содомын хаан нь түүнийг угтахын тулд гарав. 18 Бас Салимын Милгишидиг хаан нь дээд бурхны лам бөгөөтөл боорцог болон үзмийн ундааг гаргаж авчрав. 19 Тэр нь түүнийг адистидлан өгүүлрүүн; Абрам нь огторгуй болон дэлхийн эзэн дээд бурхнаар адистидлагдах болтугай! 20 Бас чиний дайснуудыг чиний гарт өгсөн дээд бурхан нь магтагдах болтугай! гэж өгүүлсэнд тэр нь хамгаас арав дахь говийг түүнд өгөв. 21 Тийм бөгөөд Содомын хаан нь Абрамд өгүүлрүүн; Чи улсыг надад өгч эд таваарыг биедээ ав! 22 гэж өгүүлсэнд Абрам нь Содомын хаанд өгүүлрүүн; Би огторгуй болон дэлхийн эзэн дээд бурхнаар тангараглав гэсэнд 23 Би Абрамыг баян болгов. гэж чиний үл өгүүлэхийн тулд би утас гутлын тасмыг чинийхээс үл аван 24 гагцхүү залуусын итгэсэн болон надтай одолцогсдын хувийг авах буй. Анир хийгээд Ишкүл ба Мамари эдгээр нь өөрийн говийг авах болтугай! гэж өгүүлэв.

Арван тавдугаар бүлэг

1 Энэ мэт болсны хойно Жахуагийн зарлиг нь Абрамд зүүдээр болж ийн; Халх хийгээд маш их шан мөн буй. 2 гэж зарлиг болсонд Абрам нь ийн айлтгав; Эзэн Жахуа аа! Чи надад юуг хайрлах вэ? Би үргүй бөгөөд энэ Дамаскийн Илияасар нь миний гэрийг сахигчийн хөвгүүн буй. 3 Бас Абрам айлтгаруун; Чи надад үрийг эс хайрласан. Харин миний гэрийн боол нь өмчийн эзэн болох. гэж айлтгав. 4 Тийм бөгөөд Жахуа нь түүнд зарлиг болруун; Тэр нь чиний өмчийн эзэн үл болно. Зүгээр, чиний биеэс гарах тэр нь чиний өмчийн эзэн болох буй. 5 Бас тэр нь түүнийг гадаа гаргаад, зарлиг болруун; Огторгуйг ширтэн, оддыг тоолж, болбол тэднийг тоол! Чиний үрс нь энэ мэт олон болох буй. 6 гэж зарлиг болсонд Абрам нь Жахуад итгэв. Тэр ч үүнийг түүнд зөв болгон тоов. 7 Бас Жахуа түүнд зарлиг болруун; Би энэ газрыг чамд өмч болгон өгөхийн тулд чамайг Халдийн үүр гэдэг газраас гаргасан Жахуа мөн юм. 8 гэж зарлиг болсонд тэр нь айлтгаруун; Жахуа эзэн ээ! Би үүнийг эзлэн авах гэж юугаар мэдэх буй? 9 гэж айлтгасанд тэр нь зарлиг болруун; Чи миний төлөө гурван настай нэг үхэр болон гурван настай нэг ямаа ба гурван настай нэг хуц болон нэг тагтаа ба нэг тагтааны зулзагыг авчир! 10 гэж зарлиг болсонд тэр нь энэ бүгдийг аваад, дундаа хуваан, зэрэглэн тавив. Шувуудыг эс хуваав. 11 Бас шувуудыг маханд бууж, ирэхэд Абрам нь тэднийг хөөв. 12 Тийм бөгөөд нар жаргах үед Абрамд бөх нойр хүрсэн бөгөөд айх мэт харанхуй нь түүнд буув. 13 Тийнхүү тэр нь Абрамд зарлиг болруун; Чиний үрс нь өөрийн бус газарт оролт болоод, тэр улсад зарагдах буй. Бас тэд нь тэднийг дөрвөн зуун жилийн турш зовоох юм. 14 Бас тэднийг зарсан улсыг ч би шүүх юм. Хожим нь тэд их зоорьтой гарч, ирэх буй. 15 Чи өөрийн эцэг нарт амраар очиж, ихэд насжиснаар болгогдох буй. 16 Тэд нь дөрөв дэх үед нааш ирэх юм гэвэл,

Амурын хүмүүсийн хилэнц нь дүүрээгүй гэж магадаар мэдтүгэй! гэж зарлиг болов. 17 Тийм бөгөөд нар жаргахад, харанхуй болоод, нэг утаат гу болон галтай гэрэвч нь тэд хувиудын хооронд өнгөрөв. 18 Мөн тэр өдрөө Жахуа нь Абрамтай тогтоолыг тогтоож, зарлиг болруун; Би чиний үрсэд Египет голоос Ифирад гол хүртэл энэ газрыг өгөв. 19 Тэр нь; Хинийн болон Хинижийн ба Кадамонын болон Хитийн ба 20 Парижийн болон Рипибнийн ба Амурийн болон Ханаваны ба Хиргишийн болон Жибумийн гэдэг улсуудын газар буй. гэж зарлиг болгов.

Арван зургадугаар бүлэг

1 Тийм бөгөөд Абрамын гэргий Сарай нь түүнд хүүхдийг эс төрүүлэн байтал нэг Хагар нэртэй Египетийн шивэгчинтэй билээ. 2 Тийнхүү Сарай нь Абрамд өгүүлрүүн; Мана. Жахуа нь намайг хүүхдийг эс төрүүлсэн буй. Тиймийн тул чи миний шивэгчинд нөхөр үйлд. Би түүнээс хөвгүүнийг хүртэх буй за. гэж өгүүлсэнд Абрам нь Сарайгийн дууг сонсов. 3 Тийм бөгөөд Абрамын Ханаваны газарт арван жил суусны дараа Абрамын Сарай гэргий нь өөрийн Египетийн Хагар шивэгчнийг аваад, Абрамд гэргий болгон өгөв. 4 Тийм бөгөөд Абрам нь түүнд нөхөр болсноор тэр нь жирэмсэн болов. Тэр ч жирэмсэн болсноо үзээд, өөрийн хатан эзнийг доромжлов. 5 Тийм учраас Сарай нь Абрамд өгүүлэв; Миний хор нь чамд болно. Би өөрийн шивэгчнийг чиний өвөрт өгөв. Тийнхүү тэр нь жирэмсэн болсноо үзээд, намайг доромжлов. Жахуа нь бидний хооронд шүүх болтугай! 6 гэж өгүүлсэнд Абрам нь Сарайд ийн өгүүлэв; Мана. Чиний шивэгчин нь чиний эрхэнд байдаг буй. Чи дураараа түүнтэй үйлд! Тийм бөгөөд Сарай нь түүнийг зовоож, байхад тэр нь түүнээс зугтаав. 7 Тийм бөгөөд Жахуагийн анхил нь түүнийг нэг усны булаг гэвэл, шүрийн хорхойн булагт олоод ийн өгүүлрүүн; 8 Сарайн шивэгчин Хагараа! Чи хаанаас ирэв. Хаана очих вэ? гэж өгүүлсэнд тэр нь Би өөрийн хатнаас зугтааж байна 9 гэж өгүүлсэнд Жахуагийн элч нь өгүүлэв; Чи өөрийн хатан эзэнд хариад түүний эрхэнд биеэ нохотгон үйлд. 10 Бас Жахуагийн анхил нь түүнд өгүүлэв; Би чиний үрийг ихэд үржүүлэх бөгөөд тэр нь олон болсон тул тоолшгүй болох бий. 11 Бас Жахуагийн анхил нь түүнд өгүүлрүүн; Чи жирэмсэн байгаа бөгөөд нэг хөвгүүнийг төрүүлэх буй. Түүнийг Ишмайл гэж нэрлэ! Яагаад гэвэл, Жахуа нь чиний зовлонг сонсов. 12 Тэр нь нэг догшин хүн болох бөгөөд түүний гар нь хамгийн тус болох бөгөөд хамгийн гар нь түүний тус болох буй. Тэр нь өөрийн ах дүү нарын өмнө суух буй. гэж өгүүлэв. 13 Тийм бөгөөд тэр нь биетэй үхүүлсэн Жахуаг; Чи намайг үзэгч бурхан. гэж нэрлэв. Яагаад гэвэл, би энд намайг үзэгчийн арыг үзэв. гэж өгүүлэв. 14 Тийм учраас тэр худаг нь Лахай Рой гэж нэрлэгдэв. Тэр нь Кидис Бирид хоёрын хооронд буй. 15 Тийм бөгөөд Хагарын Абрамд нэг хөвгүүнийг төрүүлсэнд Абрам нь Хагарын төрүүлсэн хүүхдийг Ишмайл гэж нэрлэв. 16 Хагар нь Абрамд хөвгүүнийг төрүүлсэн үед Абрам нь наян зургаан настай бөлгөө.

Арван долдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Абрамыг ерэн есөн настай болсонд бурхан нь үзэгддэг түүнд

зарлиг болруун; Би агуу хүчтэй бурхан мөн буй. Чи миний өмнө явж, төгс үйлд! 2 Би миний болон чиний хооронд тогтоолыг тавиад чамайг маш ихэд үржүүлэх буй. 3 гэж зарлиг болсонд Абрам нь нүүрээрээ хөсөр унасанд, бурхан нь түүнтэй өгүүлэлдэж, зарлиг болруун; 4 Миний тогтоол нь чамтай байх бөгөөд чи олон хүмүүсийн эцэг болох буй. 5 Бас чи үүнээс хойш Абрам гэж үл нэрлэгдэж, Абрахам гэж нэрлэгдэх буй. Яагаад гэвэл, би чамайг олон хүмүүсийн эцэг болгов. 6 Бас би чамайг маш их үрстэй болгон, чамайг улсууд болгох буй. Бас хаад ч чамаас гарах буй. 7 Би миний болон чиний хооронд ба чиний дараа өөрийн төрлүүдээр чиний үрсийн хооронд миний тогтоолыг тогтоох буй. Би чамд болон чиний дараа чиний үрсэд бурхан болох гэж мөнх тогтоол болох буй. 8 Бас би чамд болон чиний дараа чиний үрсэд хамаг Ханаваны газрыг мөнх өмч болгон өгөх буй. Бас тэдэнд бурхан болох буй. гэж зарлиг болов. 9 Бас бурхан нь Абрахамд зарлиг болруун; Чи болон чиний дараа өөрийн төрлүүдээр чиний үрс нь миний тогтоолыг сахин үйлд! 10 Миний болон таны хооронд таны сахих миний тогтоол гэвэл, энэ буй. Таны дотроос аливаа эр хүн нь хэрчигдэх болтугай! 11 Та өөрийн илүү махыг хэрчтүгэй! Тэр нь миний болон таны хооронд тогтоолын тэмдэг болох болтугай! 12 Таны төрлүүдийн дотор аливаа найман өдөртэй хөвгүүд гэвэл, гэрт төрөгдсөн буюу? Чиний үр биш байтлаа оролт хүнээс мөнгөөр худалдаж, авсан нь хэрчигдэх болтугай! 13 Чиний гэрийн дотор төрсөн болон чиний мөнгөөр худалдаж авагсад нь эрхгүй хэрчигдэх болтугай! Тийнхүү миний тогтоол нь таны маханд болж, мөнх тогтоол болох болтугай! 14 Эс хэрчигдсэн илүү махтай хүн нь миний тогтоолыг тасалсан буй. Тэр хүн нь өөрийн хүмүүсээс таслагдах болно. гэж зарлиг болов. 15 Бас бурхан нь Абрахамд зарлиг болруун; Чиний Сарай гэргий гэвэл, түүнийг Сарай гэж бүү нэрлэ! Харин түүний нэр нь Са Ра болох буй. 16 Би түүнийг адистидлаж, түүнээс чамд нэг хөвгүүнийг өгөн адистидлах буй. Тэр нь хүмүүсийн эх болох бөгөөд улсын хаад нь түүнээс гарах буй. 17 гэж зарлиг болсонд Абрахам нь нүүрээрээ хөсөр унаад инээж, дотроо өгүүлрүүн;; Зуун настайдаа хөвгүүн төрөгдөх юм уу? Са Ра нь ерэн настай болоод, хөвгүүнийг төрүүлэх буюу? 18 гэж бодоод, Абрахам нь бурханд айлтгаруун; Аяа, Ишмайл нь чиний өмнө амьд байх болтугай!. 19 гэж хэлсэнд бурхан нь зарлиг болруун; Чиний Са Ра гэргий нь лав чамд нэг хөвгүүнийг төрүүлэх буй. Тийм бөгөөд чи түүнийг Ишаг гэж нэрлэ! Би түүнтэй болон түүний дараа түүний үрстэй мөнх тогтоол болохын төлөө миний тогтоолыг тогтоох буй. 20 Бас Ишмайлын төлөө би чамайг сонссон буй. Би түүнийг адистидлаж, үрстэй болгон, маш их үржүүлэх буй. Тэр нь арван хоёр ноёдыг төрүүлэх бөгөөд би түүнийг их улс болгох буй. 21 Би өөрийн тогтоолыг Са Рагаас дараа жил төрөх Ишагтай тогтоох юм. гэж зарлиг болов. 22 Тийм бөгөөд бурхан нь түүнтэй ярилцаж, дуусаад Абрахамаас салав. 23 Тийнхүү Абрахам нь өөрийн Ишмайл хөвгүүн болон өөрийн гэрийн хамаг хүүхэд ба мөнгөөр худалдаж, авсан бүх хүүхэд ба өөрийн гэрийн бүх эрсийг аваад, бурхны түүнд зарлиг болсноор, мөн өдрөө тэдний илүү махыг хэрчив. 24 Абрахамын илүү мах хэрчигдсэн үед тэр нь жаран есөн настай байсан. 25 Бас түүний хүү Ишмайлийн илүү мах хэрчигдсэн үед тэр нь арван гурван настай байсан. 26 Түүний гэрийн бүх хүмүүс болон түүний гэрийн хүүхэд ба оролт улсаас худалдаж, авагсад нь түүнтэй хамт хэрчигдлээ.

Арван наймдугаар бүлэг.

1 Тийн бөгөөд Абрахамыг нэгэн өдөр дөлийн халуунд гэрийхээ үүдний дэргэд сууж байхад Жахуа нь түүнд Мамрийн талуудын дотор үзэгдэв. 2 Тэр нь нүдээрээ ширтэн харахад, Мана. өмнөө гурван хүн зогсож байхыг үзээд тэднийг угтахын тул гэрийн үүднээс гүйгээд хөсөр бөхийж мөргөв. 3 Тийн бөгөөд тэр нь айлтгаруун; Миний эзэн ээ! Хэрэв би чиний өмнө хайрыг олбол чи боолоо үл өнгөрөн 4 нэг багахан усыг авчруулж хөлөө угаан энэ модны доор амарч хайрла!. 5 Би боорцог авч ирье. Тийнхүү та зүрхээ тэнхрүүлэгтүн! Дараа нь алсдаж одогтун! Тиймийн тул та боолдоо ирэв. хэмээн айлтгасанд тэд нь Чи өгүүлснээрээ үйлд! хэмээн зарлиг болов. 6 Тийн бөгөөд Абрахам нь яарч гэрийн дотор Са Рад өгүүлрүүн; Гурилын гурван хэмжээг зуурч түргэн боорцгийг яаран үйлд. 7 гэж Абрахам нь сүрэгтээ очоод тэндээс нэг зөөлөн сайн тугалыг аваад залуу хүнд өгөв. Тэр ч түүнийг яаран бэлтгэв. 8 Бас тэр нь тос болон сүү ба өөрийн бэлтгэсэн тугалыг аваад тэдний өмнө тавиад тэдний ойр модны доор зогсож байв. Тэд нь зооглов. 9 Тийн бөгөөд тэд нь түүнд зарлиг болруун; Чиний Са Ра гэргий хаана байна вэ? гэж асуусанд тэр нь гэртээ байгаа гэж айлтгав. 10 Тэр нь зарлиг болруун; Амины цагийн энэ хирд би танд эрхгүй буцан ирэх бөгөөд чиний Са Ра гэргийд хөвгүүн болох буй. гэж зарлиг болсонд Са Ра нь хойно байгч гэрийн үүдний ойр сонсон байв. 11 Абрахам болон Са Ра хоёулаа хөгширч их настай болсон бөгөөд Са Ратай эхнэрүүдийн ёс нь зогссон билээ. 12 Тийн бөгөөд Са Ра нь инээж өгүүлрүүн; Миний ноёны хөгширсний дараа би ч хөгшрөөд жаргалтай болох уу? гэж өгүүлэв. 13 Тийнхүү Жахуа нь Абрахамд зарлиг болруун; Са Ра нь би хөгшрөөд үнэхээр нэг хөвгүүнийг төрүүлэх буюу. хэмээн юуны тул инээж өгүүлэв ээ. 14 Жахуад болохгүй юм байгаа буюу. Би тогтоосон болзолдоо амины цагийн хирд буцаж ирэх бөгөөд Са Рад хөвгүүн болох 15 гэж зарлиг болсонд Са Ра нь айж би эс инээв гэж мэхэлзэн өгүүлэв. Тэр нь ийн Тийн бус. Харин чи мөн инээв гэж зарлиг болов. 16 Тийн бөгөөд тэд хүмүүс нь тэндээс буугаад Содомын зүгт ширтэв. Абрахам нь тэднийг үдэхийн тулд тэдэнтэй явав. 17 Тийн бөгөөд Жахуа нь зарлиг болруун; Би өөрийн үйлдэхийг Абрахамаас нуух буюу. 18 Абрахам гэвэл их болон хүчтэй улс болох бөгөөд түүгээр дэлхийн хамаг улс нь адистидлагдах буй. 19 Тэр юуны тул гэвэл, Абрахам нь өөрийн хойно өөрийн хөвгүүд болон өөрийн гэр бүлсдээ зөв хийгээд шийдвэрийг үйлдэж Жахуагийн мөрийг сахихыг захирна. гэж би мэднэ гэвэл, Жахуагийн зарлиг болсон мэт Абрахамд бүтээхийн тул болно. 20 Тийн бөгөөд Жахуа нь зарлиг болруун; Содом болон Комурагийн цохионых болсон бөгөөд тэдний хилэнцийн маш хүнд болсны тулд 21 би бууж надад ирсэн тэдний цохионы ёсоор тэд нь тийм мөн үйлдсэн буюу. Эсвэл мэдэхийн тул үзэх больюу. 22 Тэд хүмүүс нь тэндээс хариад Содомын зүгт явав. Зүгээр Абрахам нь Жахуагийн өмнө зогсон байв. 23 Тийн бөгөөд Абрахам нь шадардаж айлтгаруун; Чи зөвтүүдийг хилэнцтэнтэй эвдрүүлэх үү? 24 Хэрэв тавин зөвт хүн тэр балгасны дотор байвал, чи эвдрүүлж тавин зөвтүүдийн тул тэр орныг үл хайрлах буюу. 25 Энэ мэтээр үйлдэх нь чамаас хол болох болтугай! Зөвтүүдийг хилэнцтэнтэй үхүүлэх бөгөөд зөвтүүдийг хилэнцтэн мэт болгох нь чамаас хол болох болтугай! Бүхэл дэлхийг

шүүгч нь зөв шийдвэрийг үл үйлдэх буй. 26 гэж айлтгасанд Жахуа нь зарлиг болруун; Хэрэв би Содом балгасны дотор тавин зөвт хүнийг олбол ал! Би тэдний учир хамаг орныг хайрлах буй. 27 гэж зарлиг болсонд Абрахам нь хариу айлтгаруун; Би тоос хийгээд үнс болгоод миний эзэнтэй эдүгээ өгүүлэлцэж эхлэв. 28 Хэрэв тавин зөвтүүдээс тав нь дутвал чи тавын учир хамаг орныг эвдрүүлэх үү? гэж айлтгасанд тэр нь Би тэндээс дөчин тавыг олбол түүнийг үл эвдрүүлэх буй. 29 гэж зарлиг болсонд тэр нь түүнтэй дахин өгүүлж ийн; Хэрэв тэндээс дөч олдвол. хэмээн айлтгасанд тэр нь би дөчийн учир үл үйлдэх хэмээн зарлиг болов. 30 Бас тэр нь айлтгаруун; Аяа, миний эзэн миний айлтгахад бүү хилэгнэх болтугай! Хэрэв тэндээс гуч олдвол. хэмээн айлтгасанд тэр нь Хэрэв би гучийг олбол би үл үйлдэх буй. 31 гэж зарлиг болсонд тэр нь айлтгаруун; Би эдүгээ миний эзэнтэй өгүүлэлцэж эхлэв. Хэрэв хорь тэнд олдвол. гэж айлтгасанд тэр нь ийн; Би хорийн учир үл эвдрүүлэх. гэж зарлиг болов. 32 Жич, тэр нь айлтгаруун; Аяа, миний эзэн нь миний ганц айлтгахад бүү хилэгнэтүгэй! Хэрэв тэндээс арав олдвол хэмээн айлтгасанд тэр нь Арвын учир би үл эвдрүүлэх. гэж зарлиг болов. 33 Тийн бөгөөд Жахуа нь Абрахамтай өгүүлэлцэж дуусаад өөд болов. Абрахам нь өөрийн оронд харьжээ.

Арван есдүгээр бүлэг

1 Тийн бөгөөд хоёр элч нь үдшээр Содомд ирэв. Лод нь Содомын хаалганы өмнө сууж байхдаа тэднийг үзээд угтахын тул босоод тэдэнд нүүрээрээ хөсөр мөргөв. 2 Тийн бөгөөд тэр нь айлтгаруун; Миний эзэд ээ! Таны боолын гэрт ороод хөлөө угааж хайрлагтун! Тийнхүү өглөө эрт босоод замдаа одогтун! гэж айлтгасанд тэд нь ийн; Тийм биш. Харин бид шөнө дуустал газарт байх буй. 3 гэж зарлиг болсонд тэр нь тэднийг маш их урьсан бөгөөд тэд нь түүнд буцааж түүний гэрт орсонд тэр нь талх барьж найр үйлдэв. Тийнхүү тэд нь зооглов. 4 Зүгээр тэдний хэвтэхээс урьд Содом балгасны залуу хийгээд хөгшин хүмүүс ба газар бүрээс бүх улс нь ирж гэрийг тойрч Лодыг дуудаж ийн өгүүлрүүн; 5 Танайд энэ шөнө ирсэн хүмүүс хаана байна вэ? Бид тэднийг мэдэхийн тул бидэнд гарга! 6 хэмээн өгүүлсэнд Лод нь тэдэнд гарч биеийн хойноо үүдийг хаагаад ийн өгүүлрүүн; 7 Миний ах дүү нар аа! Энэ хилэнцийг бүү үйлдэгтүн! 8 Надад эр хүнийг мэдээгүй хоёр охин буй. Би тэднийг танд гаднаа авчирна. Тийнхүү тэдэнтэй өөрийн дураар үйлдэгтүн! Зүгээр эд эр хүмүүстэй юуг ч бүү үйлдэгтүн! Тэр юуны тул гэвэл, түүний тул тэд нь миний гэрийн дээврийн доор орсон буй 9 гэж өгүүлсэнд тэдгээр нь өгүүлрүүн; Цааш од. Бас тэд нь өгүүлрүүн; Энэ нэг нь суухын тул ирэвч заргач болох дуртай буй. Тиймийн тул одоо бид чамтай тэднээс муугаар үйлдэх бий. гэж өгүүлээд тэд нь Лод гэдэг хүнийг ихэд дараад үүдийг эвдэхийн тул ойртож ирэв. 10 Тийн бөгөөд тэд хоёр хүн нь гараа сунгаж, Лодыг гэр дотор татан оруулаад үүдийг хаав. 11 Тийнхүү тэд нь үүдний өмнө байсан бага хийгээд том хүмүүсийг сохор болгов. Тэд ч үүдийг олж ядав. 12 Тийн бөгөөд тэд хоёр хүн нь Лодод зарлиг болруун; Чамд энд өөр хэн бий буюу гэвэл, Хүргэн буюу эсвэл хөвгүүд охид бий, бас энэ балгасны дотор өөр буй байгаа бол энэ газраас гарган үйлд. 13 Тэр юуны тул гэвэл, бид энэ газрыг эвдрүүлэх буй. Тэдгээрийн цохионы Жахуагийн нүүрийн

өмнө их болсны тулд Жахуа нь эвдрүүлэхийн тул биднийг илгээв. гэж зарлиг болов. 14 Тийн бөгөөд Лод нь гараад түүний охидыг авсан хүргэддээ өгүүлрүүн; Та нар босоод энэ газраас гарагтун! Тэр юуны тул гэвэл, Жахуа нь энэ балгасыг эвдрүүлэх буй. хэмээн өгүүлсэн боловч, тэдэнд наадам баригч хүнтэй адил үзэгдэв. 15 Тийнхүү өглөө болсонд тэр хоёр элч нар нь Лодыг түрэглүүлж ийн зарлиг болруун; Чи энэ балгасны хилэнцийн дотор үл үхэхийн тул босоод энд байгч гэргий болон хоёр охиноо аваачин үйлд. 16 гэж өгүүлээд Лодыг удаан байтал Жахуа нь түүнд нигүүлсэхүйд бүхийн тул тэр хоёр хүн түүний гар хийгээд түүний гэргийн гар ба түүний хоёр охины гараас бариад балгасны гадна гаргаад тэнд байлгав. 17 Тийн бөгөөд тэднийг гаргасны хойно тэдний нэгэн нь зарлиг болруун; Чи өөрийнхөө амины тул зайл! хэмээн зарлиг болов. 18 Тэгэхэд Лод нь тэдэнд айлтгаруун; Миний эзэн ээ! Тийм биш. 19 Эдүгээ чи боолоо хайрлан миний амийг тонилгохын тул үзүүлсэн хайраа егүүтгэсэн буй. Зүгээр би ууланд зайлж чадна. Тэр юуны тул гэвэл, зовлонгийн надтай учралдсанаар би үхэх болуузай. 20 Мана. Энэ балгаснаас зайлахын тул ойр бөгөөд бяцхан балгас бий. хэмээн хайрла! Тэд нь бяцхан бус буюу. Би тэнд зайлах болтугай! Тийнхүү миний бие амьд болох бий. 21 хэмээн өгүүлсэнд тэр нь зарлиг болруун; Бас үүний учир чамайг сонсоод, чиний өгүүлсний тул би энэ балгасыг эвдлэхгүй. 22 Чиний тэнд хүрэхээс урьд миний юуг ч үйлдэж үл чадахын тул тэнд яаран зайл. хэмээн өгүүлэв. Тиймийн тул тэр балгас нь Зувар хэмээн нэрлэгдсэн билээ. 23 Лодын Зуварт ороход нар нь дэлхийн дээр гарсан билээ. 24 Тийнхүү Жахуа нь Содом болон Гомурагийн дээр Жахуагаас гэвэл огторгуйгаас хүхэр болон галыг бороо мэт оруулав. 25 Бас тэр нь балгаснууд болон бүх тал ба балгасуудын дотор суугчид болон газар дээр юу ургасныг хөмрүүлэн эвдэрлээ. 26 Харин Лодын гэргий нь гэдрэгээ хараад давсан багана болов. 27 Тийн бөгөөд Абрахам нь өглөөгүүр эрт босоод Жахуагийн өмнө зогссон газар хүртэл одож 28 Содом болон Гомура ба хамаг талын газрыг хараад тэр орны утааны их гуугийн утаа мэт гарахыг үзэв. 29 Зүгээр Бурхан нь талын балгадыг эвдрүүлэхэд Абрахамыг санаж Лодын суусан балгасыг хөмрүүлж эвдэхээс урьд Лодыг эвдрэлийн дундаас илгээсэн билээ. 30 Тийн бөгөөд Лод нь Зуварын дотор байхаас айсны тул Зуvaraас гараад өөрийн хоёр охидтой ууланд одоод уулны нэг хөндийн дотор суув. 31 Тийнхүү эгч нь дүүдээ ийн; Бидний эцэг нь хөгширсөн бөгөөд бүхэл ертөнцийн ёсоор бидэнтэй нөгцөх эр хүн ертөнц дээр олдохгүй буй. 32 Бид эцгээ архиар согтоогоод бидний эцгээс үрийг барихын тул түүнтэй хэвтэлцье. гэж өгүүлэв. 33 Тийнхүү тэр шөнөдөө тэдний эцгээ архи уулгасанд эгч нь орж өөрийн эцэгтэй хэвтэвч тэр нь түүний хэвтэх хийгээд босохыг эс ажиглав. 34 Тийн бөгөөд маргааш нь эгч нь дүүдээ ийн; Мана. Би өнгөрсөн шөнө өөрийн эцэгтэй хэвтэв. Бас энэ шөнөдөө түүнийг архи уулгаад түүнээс үрийг барихын тул чи түүнд орж түүнтэй хэвт. гэж өгүүлэв. 35 Жич, тэр шөнөдөө эцэгтээ архи уулгасанд бага охин нь түүнтэй хэвтэвч тэр түүний хэвтэх хийгээд босохыг эс ажиглав. 36 Энэ мэтээр Лодын хоёр охид өөрийн эцгээс жирэмсэн болов оо. 37 Том охин нь хөвгүүнийг төрүүлээд үүнийг Муаб гэж нэрийдэв. Тэр нь Муаб гэдэг улсын эцэг одоо болтол мөн. Жич, бага охин нь хөвгүүнийг төрүүлж түүнийгээ Аммия гэж нэрийдэв. Тэр нь Аммуд гэдэг

хөвгүүдийн эцэг одоо болтол мөн.

Хорьдугаар бүлэг

1 Абрахам нь тэндээс өмнө оронд нүүж, Кадис Шүр хоёрын хооронд нутаглаад, Кирарын дотор суув. 2 Тийм бөгөөд Абрахам нь өөрийн Са Ра гэргийн тухай Тэр нь миний дүү буй. гэж өгүүлсэнд Кирарын Абимилиг хаан нь Са Раг авав. 3 Тийнхүү бурхан нь Абимилигийн зүүдэнд шөнө ирээд, түүнд; Чиний авсан гэргийн төлөө чи үхэх буй. Яагаад гэвэл, чиний эхнэр нь нэг эрийн гэргий буй. гэж зарлиг болгов. 4 Абимилиг нь түүнд эс ойртсон бөгөөд өгүүлэв; Эзэн минь ээ! Чи гэмгүй улсыг алах буй уу? 5 Абрахам нь Энэ миний дүү буй. гэж надад өгүүлсэн биш үү? Бас Са Ра нь ; Энэ миний ах буй. гэж өгүүлсэн. Би өөрийн зүрхний хиргүй болон өөрийн гарын цээрлэлээр үүнийг үйлдэв. 6 гэж хэлсэнд бурхан нь зүүдээр түүнд зарлиг болруун; Би чиний зүрхний хиргүйгээр үүнийг үйлдсэнийг би мэднэ. Тийм учраас чи миний төлөө нүглийг бүү үйлдтүгэй! гэж би чамайг түүний биед эс хүргүүлсэн буй. 7 Тийм бөгөөд одоо энэ хүний гэргийг буцааж өг! Тэр нь Парупид гэдэг бүхийн тулд чиний төлөө залбирах бөгөөд чи амьд байх буй. Хэрэв чи буцааж, өгөхгүй бол чиний болон чиний ах дүүс үхэхийг мэд! гэж зарлиг болов. 8 Тийм учраас Абимилиг нь өглөө эрт босож, хамаг боолуудаа дуудаад, энэ бүхнийг тэдэнд хэлэв. Тэр хүмүүс ч их айв. 9 Тэгээд Абимилиг нь Абрахамыг дуудаад, түүнд; Чи бидэнд юуг үйлдэв? Миний дээр болон миний орны дээр чиний их хилэнцийг ирүүлэхийн төлөө би чиний төлөө ямар бурууг үйлдэв? Чи надад ёсгүй үйлсийг үйлдэв. 10 Бас Абимилиг нь Абрахамд; Чи энэ үйлсийг үйлдсэний төлөө юуг үзэв? 11 гэсэнд Абрахам нь ; Би энэ оронд бурхнаас аюулгүй бөгөөд миний гэргийн төлөө намайг алах байх гэж айж өгүүлсэн буй. 12 Харин тэр нь миний дүү мөн буй. Миний эхийн охин биш боловч миний эцгийн охин бөгөөд миний гэргий болов. 13 Тийм бөгөөд бурхны миний эцгийн нутгаас намайг нүүлгэн, явуулахад би гэргийдээ Бидний очих ямар ч газарт чиний надад үзүүлэх хайр юу вэ? гэхэд Намайг чиний ах. гэж өгүүл 14 гэсэнд Абимилиг нь Абрахамд хоньд болон үхрүүд ба боолууд болон шивэгчдийг өгөөд, түүний Са Ра гэргийг буцааж өгөв. 15 Бас Абимилиг өгүүлрүүн; Чиний өмнө миний газар байгаа бөгөөд чи ямар ч таалагдсан газраа сууж болно. 16 Бас тэр нь Са Рад өгүүлрүүн; Би чиний ахад нэг мянган цэн мөнгийг өгөв. Тэр нь чамтай байгчид болон бусдаас чиний нүдний бүрхүүл буй. Энэ мэтээр тэр нь зэмлэгдэв. 17 Тийнхүү бурханд залбирснаар бурхан нь Абимилиг болон түүний гэргий ба түүний шивэгчдийг эдгээв. Тэд ч хүүхэд төрүүлэв. 18 Яагаад гэвэл, Абрахамын Са Рагийн төлөө бурхан нь Абимилигийн гэрт байгчдын умайг хаасан билээ.

Хорин нэгдүгээр бүлэг

1 Тийнхүү Жахуа нь зарлиг болсноороо Са Раг золгож, Жахуа нь зарлиг болсноороо Са Рад үйлдэв. 2 Тийнхүү Са Ра нь жирэмсэн болоод, Абрахамыг хөгширсөн хойно бурхны зарлиг болгосон цагт түүнд нэг хөвгүүн төрөв. 3 Абрахам нь өөрийн төрсөн хөвгүүнийг Ишаг гэж нэрлэв. Ишаг нь Са Рагийн Абрахамд

төрүүлсэн хөвгүүн буй. 4 Тэгээд Ишагийн төрснөөс найман өдрийн дараа бурхан нь Абрахамын бурхны захисан ёсоор хөвгүүндээ хэрчих ёсыг бүтээв. 5 Абрахам нь Ишагийг төрөхөд зуун настай байсан. 6 Тийм бөгөөд Са Ра нь өгүүлэв; Бурхан нь намайг инээлгэсэн бөгөөд хэн ч сонссон надтай хамт инээх байсан. 7 Бас өгүүлэв; Са Ра нь хөвгүүнээ хөхөөр тэжээх буй. гэж Абрахамд хэн хэлэх билээ. Яагаад гэвэл, би түүнийг хөгширсөн хойно нэг хөвгүүн төрүүлэв. 8 Тийм бөгөөд тэр хөвгүүн нь өсөж хөхнөөс салав. Ишагийг хөхнөөс салсан өдөр Абрахам нь их найр хийв. 9 Тийм бөгөөд Са Ра нь Египетийн Хагар гэгч нь Абрахамын хүү Ишагийг элэглэн байхыг үзэв. 10 Тийм учраас Са Ра Абрахамд өгүүлэв; Энэ шивэгчин болон түүний хөвгүүнийг гарга! Яагаад гэвэл, энэ шивэгчний хүү нь миний Ишаг хөвгүүнтэй өмчийг үл авалцах буй. 11 гэж өгүүлсэнд Абрахам нь өөрийн хөвгүүний төлөө үүний тухай ихэд гомдсон билээ. 12 Тийнхүү бурхан нь Абрахамд Чи энэ хөвгүүн болон чиний шивэгчний тухай үл гомдон, Са Рагийн хэлсэн ёсоор үйлд! Яагаад гэвэл, Ишагаар чиний удам нэрлэгдэх буй. 13 Жич, би тэр шивэгчний хөвгүүнээс их улсыг бий болгох буй. Яагаад гэвэл, тэр нь чиний үр мөн. 14 гэж зарлиг болсонд Абрахам нь өглөө эрт босож, болсон талх болон усны савыг авч, Хагарын мөрөн дээр тавиад, хөвгүүнийг өгөөд, түүнийг цааш явуулав. Тэр нь явсаар Биршиба гэдэг говьд төөрөн явав. 15 Тийнхүү саван дотор байсан ус дууссаны дараа хөвгүүнийг нэгэн шугуйн доор тавив. 16 Тэндээс нэг зэвийн төдий газар очоод, түүний дэргэд сууж, ийн өгүүлэв; Хөвгүүний үхлийг бүү үзсүгэй! гээд түүний дэргэд суугаад уйлав. 17 Тийнхүү бурхан нь тэр хөвгүүний дууг сонсов. Бас бурхны анхил нь огторгуйгаас Хагарыг дуудан, зарлиг болруун; Хагар аа! Чамд юу тохиолдов. Бүү айтугай! Яагаад гэвэл, хөвгүүн хаана байна тэнд бурхан нь түүний дууг сонсов. 18 Тийм учраас босоод, хөвгүүнийг өргөн, гартаа ав! Би түүнийг их улс болгон тавих буй. гэж зарлиг болгов. 19 Тийм бөгөөд бурхан нь түүний нүдийг нээснээр, тэр нь нэг усны худгийг үзээд, тэнд очиж, усны савыг усаар дүүргээд, хөвгүүндээ уулгав. 20 Тийм бөгөөд бурхан энэ хөвгүүнтэй хамт байсан бөгөөд тэр нь өсөж бүхий говийн дотор сууж, бэрх харваач хүн болов. 21 Бас түүнийг Паран гэдэг говьд сууж байхад нь түүний эх нь Египет газраас нэг гэргийг түүнд авав. 22 Тийм бөгөөд тэр үед Абимилиг болон түүний цэргийн тэргүүлэгч Пихул нь Абрахамд өгүүлэв; Чамайг юу ч хийсэн бурхан нь чамтай хамт байна. 23 Тийм учраас чи надад болон миний хөвгүүдэд ба миний ач нарт худлаар үл яван, миний чамд үйлдсэн өршөөнгүйн ёсоор түүнчлэн надад болон нутагласан газар үйлдэх буй. гэж одоо надад бурхнаар тангарагла! 24 гэж өгүүлсэнд Абрахам нь би тангараглана гэж өгүүлэв. 25 Бас Абрахам нь Абимилигийн боолуудын нэг нь усны худгийг булаан, авсны төлөө Абимилигийг зэмлэв. 26 Тийм бөгөөд Абимилиг нь өгүүлрүүн; Хэн үүнийг үйлдсэнийг би эс мэдсэн бөгөөд энэ өдөр болтол, чамаас өөр хүнээс үүнийг эс сонсов 27 гэсэнд Абрахамын хоньд болон үхрүүдийг авч, Абимилигт өгсөнд, тэр хоёр хоёулаа тогтоолыг тогтоов. 28 Бас Абрахамын сүргээс долоон эм хургыг тусад нь тавьсанд Абимилиг нь Абрахамд; 29 Чиний энэ тусд нь байлгасан долоон эм хурга нь юу вэ? 30 гэж өгүүлсэнд Абрахам нь; Энэ нь намайг худаг малтсаны гэрч болох тул энэ долоон эм хургыг миний гараас ав! гэж өгүүлэв. 31 Тэнд тэр хоёр хоёулаа амласан тул тэр газар нь Биршиба гэж

нэрлэгдэв. Яагаад гэвэл, тэд нь Биршибад тогтоолыг тогтоов. 32 Тийм бөгөөд Абмилиг болон түүний цэргийн тэргүүлэгч Пихул нь босоод, Пилисти таны газарт буцав. 33 Тийм бөгөөд Абрахам нь Биршибад нэг модыг тариад, тэнд цаглашгүй Жахуа бурхны нэрийг дуудав. 34 Бас Абрахам нь Пилиститний газарт олон өдөр нутагласан билээ.

Хорин хоёрдугаар бүлэг

1 Тийнхүү эдгээр үйлсийн дараа бурхан нь Абрахамыг шалгаж түүнд ийн; Абрахам аа! гэж зарлиг болсонд тэр нь; Би энд байна гэж айлтгав. 2 Тийнхүү бурхан нь зарлиг болруун; Чи өөрийн ганц хүү Ишагтай хамт Мурия гэдэг газар очоод, тэнд миний захих нэг уулны дээр түүнийг шатаалт тахил болгон өргөн үйлд! гэж зарлиг болов. 3 Тийнхүү Абрахам нь өглөө эрт босоод, илжгээ эмээллээд, хоёр залуустай болон өөрийн хүү Ишагтай хамт тахилын түлээг хагалаад, бурхны түүнд захисан газарт одов. 4 Тийнхүү гурав дахь өдрөө Абрахам нь нүдээрээ дээш ширтэж, тэр газрыг холоос харав. 5 Абрахам нь залуустаа ийн өгүүлрүүн; Та нар илжигтэй хамт хүлээж, бай! Би хөвгүүнтэйгээ тэнд очиж, мөргөөд буцаж, ирнэ 6 гээд Абрахам нь тахилын түлээг аваад, өөрийн Ишаг хөвгүүнд үүрүүлээд гартаа гал болон хутгыг барив. Тийнхүү тэр хоёр хамт явав. 7 Тийм бөгөөд Ишаг нь Миний эцэг ээ! гэсэнд Абрахам нь Миний хөвгүүн би энд байна гэсэнд хүү нь; Тахилын гал болон түлээ нь энэ байна. Харин хурга хаана байна вэ? 8 гэж өгүүлсэнд Абрахам нь ; Миний хөвгүүн ээ! Бурхан нь тахилын төлөө өөрт хургыг бэлтгэх буй гэж өгүүлсэнд тэр хоёр хамт явав. 9 Тийм бөгөөд тэд нар бурхны болгосон газарт хүрч, ирэв. Тийнхүү Абрахам нь тэнд нэг тахилын ширээг хийгээд, түлээг өрөөд, өөрийн хүү Ишагийг хүлж, тахилын ширээн дээр байгч түлээний дээр хэвтүүлэв. 10 Абрахам нь хүүгээ алахын тулд гараа сунгаж, хутгыг авав. 11 Энэ үед бурхны элч нь огторгуйгаас Абрахамаа, Абрахам аа! гэж түүнийг дуудахад тэр нь Би энд байна гэж хэлэв. 12 Элч нь Гараа хөвгүүний тус үл өргөн, түүнд юуг ч бүү үйлд! Яагаад гэвэл, чи ганц хөвгүүнээ бурхнаас айж, эс хайрласныг би мэднэ. гэж зарлиг болов. 13 Тийнхүү Абрахам нь нүдээрээ дээш ширтэн, хойноо шугуйд эврүүдээр баригдсан хуцыг үзээд, Абрахам нь очиж, хуцыг аваад, өөрийн хөвгүүний оронд шатааж тахил өргөв. 14 Тэгээд Абрахам нь тэр газрыг Жахуа Жар. гэж нэрлэв. Түүний учир; Жахуа Жарын уул. гэж одоо болтол өгүүлэгдэнэ. 15 Тийм бөгөөд бурхны элч нь Абрахамыг дуудаж; 16 Чи үүнийг үйлдэн, өөрийн ганц хөвгүүнээ надаас эс харамласан тул бурхан нь биеэрээ тангараглаж, ийн зарлиг болжсон буй. 17 Би адистидадар чамайг адистидлах, чиний үрсийг үлэмжлүүлэн огторгуйн одод мэт болон далайн хөвөөн дээр байдаг элс мэт олон болгох буй. Бас чиний үрс нь өөрийн дайснуудын хаалгыг эзлэх бөгөөд 18 миний дууг чи сонссон тул чиний үрсээр хамаг улс нь адистидлагдах буй гэж зарлиг болов. 19 Тэгээд Абрахам нь залуустай буцсанд тэд ч босч Биршибад хамтаар Абрахам нь Биршибд нутагдав. 20 Тийнхүү эдгээр үйлсийн дараа Абрахамд ийн өгүүлэгдэв; Милха гэдэг чиний дүү Нахурд хөвгүүнийг төрүүлэв. 21 Тэд гэвэл ир хөвгүүн Хүж. Түүний дүү Бүж ба Арамын эцэг Химү Ил. 22 Кисад болон Хэж ба Пилдас болон Жидлаб ба Битү Ил гэгчид болно. Битү Ил нь Рибикэг төрүүлэв. 23 Эд наймыг Милха нь Абрахамын

дүү Нахурт төрүүлэв. 24 Бас түүний Риум нэртэй бага гэргий нь Тиба болон Гахам ба Пахас хийгээд Ма Аа Хаг төрүүлэв.

Хорин гуравдугаар бүлэг

1 Са Ра нь зуун хорин долоон настай болоод 2 Кирчид Арав гэхэд нас барав. Тэр гэвэл, Ханаван газрын Хибрун бий. Тийнхүү Абрахам нь Са Рагийн төлөө цурхирах болон уйлахын тулд ирэв. 3 Тийнхүү Абрахам нь өөрийн гэргийн өмнөөс босоод, Хидан хөвгүүдэд өгүүлрүүн; 4 Би бол тантай оролт болон нутаглагч мөн. Тийм байтал тантай нэг болох газрын өмчийг надад өгөгтүн! Тийнхүү би өөрийн нөгчсөнийг өөрийн өмнөөс булах буй 5 гэж өгүүлсэнд Хидийн хөвгүүд нь Абрахамд хариу өгүүлрүүн; 6 Миний ноён оо! Биднийг сонс! Чи бидний дунд их ноён мөн. Бидний булшнуудаас сонгож, өөрийн нөгчсөн гэргийг бул! 7 гэж өгүүлсэнд Абрахам нь босоод, тэр газрын ард болсон Хидийн хөвгүүдийн өмнө мөргөж ийн өгүүлэв 8 Хэрэв та миний өмнөөс нөгчсөнийг булуулах дуртай бол намайг сонсож, миний төлөө Зухарийн Ипэрүн хөвгүүнээс эрэгтүн! 9 Тэр нь өөрийн тариалангийн үзүүрт байгч Махпила гэдэг хөндийг надад өгтүгэй! Танай дотор булшлагдсан бүхний төлөө тэр нь дүүрэн үнээр надад өгтүгэй? 10 гэж өгүүлэхэд Ипарун нь Хидийн хөвгүүдийн дунд сууж, байсан билээ. Тийнхүү Хидийн Ипарун нь өөрийн хотын хаалгаар орогч хамаг хөвгүүдийг сонсож, байхад Абрахамд ийн өгүүлэв; 11 Миний эзэн ээ! Тийм биш. Намайг сонс! Тэр тариаланг би чамд өгнө. Жич, түүний дотор байгч хөндийг чамд өгье! Миний улсын хөвгүүдийн өмнө чамд өгөх буй. Нөгчсөнөө бул! гэж өгүүлэв. 12 Тийнхүү Абрахам нь тэр орны хүмүүсийн өмнө мөргөөд, 13 тэр орны хүмүүсийг сонсож, байхад Ипарунд; Хэрэв чи үүнийг надад өгвөл намайг сонс! Би тариалангийн үнийг чамд өгнө. Чи ав. Тийнхүү нөгчсөнөө булна 14 гэж өгүүлсэнд Ипарун нь Абрахамд хариу өгүүлэв; 15 Миний эзэн ээ! Намайг сонс! Тэр газрын үнэ нь цагаан мөнгөний дөрвөн зуун цэн буй. Тэр бид хоёрын хооронд юу вэ? Тийм учраас нөгчсөнөө бул! 16 гэж өгүүлсэнд Абрахам нь Ипарун ба Хидийн хөвгүүдийг сонсож, байхад Ипаруны өгүүлснийг худалдагчийн ёсоор явах мөнгөний дөрвөн зуун цэнг түүнд өгөв. 17 Тийнхүү Махпилагийн дотор болон Мамарын өмнө байгч Ипаруны тариалан болон түүний дотор байгч хөндий ба тариалангийн дотор болон хамаг моднууд нь 18 хотын хаалгаар орогч Хидийн хамаг хөвгүүдийн өмнө Абрахамд өмчөөр тогтоогдов. 19 Түүнээс хойш Абрахам нь Мамарын өмнө байгч Махпилагийн тариалангийн хөндийн дотор өөрийн гэргий Са Раг булав. Тэр нь Ханаван газарт байгч Хибрун буй. 20 Энэ мэтээр тэр тариалан болон түүний дотор байгч хөндий нь булах өмч бүхний төлөө Хидийн хөвгүүдээр Абрахамд тогтоогдов.

Хорин дөрөвдүгээр бүлэг

1 Тийнхүү Абрахам нь хөгширч, их настай болов. Жахуа нь Абрахамыг хамгаар адистидалсан билээ. 2 Тийнхүү Абрахам нь түүний гэрт байгч ахлагч болон түүний хамаг эд таваарыг хариуцагч боолдоо; Чи миний гуян доор гараа тавь! 3 Тийнхүү чи миний суусан Ханаван газрын хүний охидоос миний хөвгүүнд гэргий бүү ав! гэж

огторгуйн бурхан болон дэлхийн бурхнаар болсон Жахуагаар би чи чамайг тангараглуулах буй. 4 Миний нутгийн газар болон миний төрөлд очоод, миний Ишаг хөвгүүнд гэргий ав! 5 гэж өгүүлсэнд боол нь түүнд Хэрэв тэр охин нь намайг даган, энэ газар ирэхийг хүсэхгүй бол би буцаж, чиний хөвгүүнийг өөрийн чинь ирсэн газар аваачих буй уу? 6 гэж өгүүлсэнд Абрахам нь түүнд өгүүлэв; Чи миний хөвгүүнийг тэнд аваачихгүй байхыг хичээ! 7 Миний эцгийн гэр болон миний төрлийн газраас намайг авсан ба надад зарлиг болсон болон чиний үрд энэ газрыг өгнө гэж надад тангарагласан огторгуйн бурхан нь өөрийн элчийг чиний өмнө илгээх буй. Тийнхүү чи миний хөвгүүнд тэндээс гэргий авчрах буй. 8 Тэр охин нь чамайг дагаж, ирэхийг хүсэхгүй бол чи энэ тангаргаас ариун болох буй. Харин миний хөвгүүнийг тэнд бүү аваач! 9 гэж өгүүлсэнд тэр боол нь өөрийн Абрахам эзний гуян доор гараа тавиад, энэ өгүүлснээр тангараглав. 10 Тэр боолын эзний хамаг эд таваар нь түүний гарт байсан тул тэр нь өөрийн эзний тэмээдээс арван тэмээ аваад, Мисупутамид байгч Нахурын балгасанд очив. 11 Тийнхүү тэр нь балгасны гадна усны худгийн өмнө үдшийн хутгах үед тэмээдийг хэвтүүлээд, ийн өгүүлэв; 12 Миний Абрахам эзний Жахуа бурхан аа! Чи миний Абрахамд хайрыг үйлдэж, одоо энэ өдөр намайг бүтэмжит болгон соёрх! 13 Одоо би усны худгийн дэргэд байгаа бөгөөд энэ балгасын хүмүүсийн охид нь усыг хутгахаар гарч ирэх буй. 14 Тийнхүү Чи саваа буулгаж, надад ус уулга! гэж аль нэг охинд би өгүүлэхэд Уу, би чиний тэмээдийг услах уу? гэж надад өгүүлэгч тэр чиний Ишаг боолын төлөө болох болтугай! гэж гуйна би. Тийн болбол, миний эзэнд чиний хайр үйлдсэнийг би үүнээр мэднэ гэж өгүүлэв. 15 Тэгээд түүнийг өгүүлж, дуусахаас өмнө Абрахамын Нахур дүүгийн Милха гэргийгээс Битү Илд төрөгдсөн Рибика нь өөрийн мөрөн дээр саваа барьж гарав. 16 Тэр охин нь маш сайхан үзэсгэлэнтэй бөгөөд эр хүн түүнийг эс мэдсэн билээ. Тэр охин нь худгаас саваа дүүргээд дахин гарав. 17 Тэр боол нь түүнийг угтахаар гүйгээд, Чи савтай уснаасаа надад багахан уулгаж, хайрла! 18 гэж өгүүлсэнд тэр нь Миний эзэн үү гэж өгүүлээд, өөрийн мөрөн дээрээс савыг гартаа буулгаж, түүнд ус уулгав. 19 Бас тэр нь түүнийг ус ууж, дуусахад Би чиний тэмээдийг цадтал ус уулгахаар хутгая! 20 гэж яаран саван дотор байсан усыг ховоонд асгаад, дахин хутгахын тулд худагт очоод, түүний бүх тэмээдийг услав. 21 Тийм бөгөөд тэр хүн нь түүнд гайхаж, бурхан түүний замыг бүтэмжтэй болсон уу? үгүй юу? гэдгийг мэдэхийн тулд дуугүй байв. 22 Тийм бөгөөд тэмээд ус ууж, дууссанд тэр хүн нь хагас цэн алтан сүйх болон арван цэнгийн хоёр гарын алтан бугуйвчийг аваад өгүүлрүүн; 23 Чи хэний хэн бэ? Надад хэлээч! Чиний эцгийн гэрт гэр дотор миний байх зай байна уу? 24 гэж өгүүлсэнд тэр нь түүнд өгүүлэв; Би бол Милхагийн төрсөн Нахурын Битү Илийн охин буй. 25 Жич, бидэнд талхны иш болон хүнс ба газар байгаа гэж өгүүлэв. 26 Тийм бөгөөд тэр боол хүн нь толгойгоо бөхийлгөж, Жахуад мөргөж өгүүлэв; 27 Миний Абрахам эзний Жахуа бурхан нь магтагдах болтугай! Тэр нь өөрийн хайр болон үнэнээр миний эзнийг эс орхисон буй. Харин намайг зам дээр байтал Жахуа нь миний эзний ах дүү нарын гэрт удирдан авч ирэв гэж өгүүлэв. 28 Тийм бөгөөд тэр охин нь гүйгээд, өөрийн эхийн гэр дотор байсан хүмүүст энэ мэтийг өгүүлэв. 29 Тийнхүү Рибикад нэг ах байгаа бөгөөд түүний нэр нь Лабан билээ. Лабан нь худагт гарч,

тэр хүнд гүйв гэвэл ийн дэргэд хүрч ирэв. 30 Тэр нь сүйх болон дүүгийнхээ гарт байгч бугуйвчуудыг хараад, тэр хүн нь надад ийн өгүүлэв гэж Рибика дүүгийнхээ үгсийг сонсоод, тэр хүнд очив. Тэр ч тэмээдтэй усны худгийн дэргэд байсан билээ. 31 Лабан нь түүнд өгүүлэв; Чи Жахуагийн адистидласан аа! Чи гэрт ортугай! Чи газарт юуны тул байна вэ? 32 Би гэр болон тэмээдийн газрыг бэлдэв гэж өгүүлээд тэр хүнийг гэрт оруулаад, түүний тэмээдийг тавиад, тэмээдэд тарианы иш болон идээг өгч түүний хөл болон түүнтэй байгчдын хөлийг угаахын тулд ус өгөв. 33 Тийнхүү түүний өмнө идэх идээ нь тавигдав. Боол нь өгүүлрүүн; Би миний эзэн надад юу захисныг өгүүлэхээс урьд юу ч идэхгүй 34 гэж хэлсэнд Лабан нь Өгүүл гэсэнд боол нь өгүүлэв; Би Абрахамын боол билээ. 35 Жахуагийн миний эзнийг маш адистидласнаар тэр нь их болов. Бас тэр нь түүнд хоньд болон үхрүүд ба мөнгө болон алт ба боолууд болон шивэгчид ба тэмээд болон илжигнүүдийг өгсөн буй. 36 Миний эзний Са Ра гэргий хөгширсөн хойноо миний эзэнд хөвгүүнийг төрүүлэв. Эзэн нь байгаа бүх зүйлээ түүнд өгөв. 37 Миний эзний өгүүлсэн нь; Миний суух Ханаван нутгийн хүмүүсийн охидоос миний хөвгүүнд гэргий бүү ав! 38 Чи миний эцгийн гэр болон миний төрөлд очоод, тэндээс миний хөвгүүнд гэргий ав! гэж намайг тангараглав. 39 Би өөрийн эзэнд өгүүлэв; Тэр эм намайг дагаж, ирэхгүй буй за 40 гэсэнд тэр надад өгүүлрүүн; Би хэний өмнө явсан гэвэл Жахуа бурхан нь өөрийн элчийг чиний өмнө илгээж, чиний замыг бүтэмжтэй болгох бөгөөд чи миний төрөл болон миний эцгийн гэрээс миний хөвгүүнд гэргий авах буй. 41 Чи миний төрөлд ирэх үедээ надад тангарагласнаасаа ариун болно. Бас тэд нь чамд үл өгвөл, чи надад тангарагласнаасаа ариун болох буй гэж өгүүлэв. 42 Энэ мэтээр өнөөдөр худгийн дэргэд ирээд, ийн өгүүлрүүн; Миний Абрахам эзний Жахуа бурхан аа! Хэрэв чи миний явах замыг бүтэмжтэй болговол 43 усны худгийн өмнө байгч намайг үзэн соёрх! Нэг охиныг ус хутгахын тулд гарч ирэхэд Чи савтай уснаасаа нэг балгыг өгөөч! гэж намайг түүнд хэлэхэд 44 тэр нь Уу бас Би чиний тэмээдэд ус хутгаж өгнө гэж надад өгүүлбэл тэр нь миний эзний хөвгүүнд Жахуа бурхны тогтоосон гэргий болох болтугай! 45 гэж намайг сэтгэлээр өгүүлж дуусахаас өмнө Рибика нь мөрөн дээрээ байгч савтай ирээд, ус хутгахын тулд худгийн дэргэд буув. Тийнхүү Ус балгуулаач гэж намайг өгүүлэхэд 46 тэр түрэглэж, өөрийн савыг дээрээсээ буулгаад Чи уу? бас би чиний тэмээдийг услах буй гэж өгүүлсэнд уув. Бас тэр нь тэмээдийг услав. 47 Тийм бөгөөд би түүнээс Чи хэний охин бэ? гэж асуув. Тэр нь Милхагийн Нахурын Битү Илийн төрсөн охин гэж өгүүлсэнд би түүний нүүрэнд сүйхийг зүүлгэж, түүний хоёр гарт бугуйвчуудыг зүүлгэв. 48 Тийнхүү би толгойгоо бөхийлгөн, миний эзний дүүгийн охиныг түүний хөвгүүнд авах зөв замаар намайг удирдсан бурханд мөргөж, өөрийн Абрахам эзнийг магтав. 49 Хэрэв та одоо өршөөнгүй болон үнэнээр миний эзэнтэй явахыг хүсвэл надад өгүүлэгтүн! Үгүй бол миний баруун гарт эсвэл зүүн гарт явахын тулд надад өгүүлэгтүн! гэж хэлэв. 50 Лабан болон Битү Ил нь хариу өгүүлэв Энэ буй нь бурхнаас гарсан буй. Бид чамд мууг эсвэл сайныг өгүүлж үл чадна. 51 Рибика нь чиний өмнө байна. Түүнийг авч яв! Бурхны зарлиг болгосноор Рибика чиний эзний хөвгүүний гэргий болох болтугай! , 52 гэж өгүүлснийг Абрахамын боол нь сонсоод газар хүртэл бурханд мөргөв. 53 Тийнхүү тэр боол нь мөнгөн сав болон алтан сав

ба хувцсыг гаргаж, өгөөд түүнийг ах болон эхэд эрдэнийн буйсыг өгөв. 54 Тэгээд боол болон түүнтэй байгч хүмүүс нь идээг идэн, ундааг уугаад хонов. Тийнхүү тэр боол нь маргааш босоод өгүүлэв; Намайг миний эзэн рүү явуулагтун! 55 гэж өгүүлэвч Рибикагийн ах болон эх нь өгүүлэв; Тэр охин нь бидэнтэй арваад хоног хамт байж байгаад очиж болох уу? гэж өгүүлэв. 56 Харин боол нь тэдэнд өгүүлэв Бурхан нь миний замыг бүтэмжтэй болсон тул намайг бүү саатуул! гэж өгүүлэв. 57 Тийнхүү охины ах болон эх нь өгүүлэв Бид охиныг дуудаж асууя! 58 гэж хэлээд, Рибикаг дуудаад Чи энэ хүнтэй явах уу? гэж асуухад охин нь; Би явна. гэж хэлэв. 59 Тийнхүү тэд нь өөрийн охин дүү Рибика болон түүнийг хөхүүлж өсгөсөн эмэгтэй ба Абрахамын боол болон түүнтэй хамт явсан хүмүүсийг явуулав. 60 Бас тэд нь Рибикаг адистидлаж; Охин дүү минь! Чи түмэн түмний эх болох бөгөөд чиний үрс нь тэднийг өшөөлөгчдийн хаалгыг эзлэх болтугай! гэж өгүүлэв. 61 Тэгээд Рибика болон түүний шивэгчид нь босоод, тэмээдийг унаж, тэр хүмүүсийг дагаж явав. Тийнхүү тэр боол нь Рибикаг аваад явав. 62 Тийм бөгөөд Ишаг нь өмнө зүгт сууж байхад лахаруй гэгч худгийн замаар ирэв. 63 Бас Ишаг нь үдшээр санаачлахын тулд хээр газар очиж, нүдээрээ дээшээ ширтэж, тэмээдийг ирж буйг харав. 64 Рибика нь нүдээрээ дээшээ ширтэж, Ишагийг хараад, тэмээнээсээ буув. 65 Яагаад гэвэл, тэр боолоос Бидэнтэй хээр дайралдагч хүн нь хэн бэ? гэхэд боол нь ; Тэр миний эзэн буй гэж түүнд өгүүлсэн билээ. Тийнхүү тэр нь нэг хөшгийг авч, биеэ ороов. 66 Тийм бөгөөд тэр боол нь хамаг үйлдсэнээ Ишагт өгүүлэв. 67 Тэгээд Ишаг нь Рибикаг аваад, өөрийн эх Сарагийн гэрт оруулав. Тэр нь Ишагийн гэргий болов. Ишаг нь түүнийг янаглаж, өөрийн эхийг нөгчсөний дараа амгалагдсан билээ.

Хорин тавдугаар бүлэг

1 Абрахам нь дахин гэргий авав. Түүний нэр нь Китүрэ билээ. 2 Тэр нь Жирмрэн, Зугшан, Мидан, Мидиян, Ишбаг, Шүва нарыг төрүүлэв. 3 Зугшан нь Шиба, Дидан хоёрыг төрүүлэв. Дидан нь; Ашурим, Литүүшим, Лизумим нарыг төрүүлэв. 4 Мидияны хөвгүүд нь Ича, Ипаир, Хануг, Абида, Илдаваар билээ. Эдгээр нь бүгд Китүрийн хөвгүүд билээ. 5 Абрахам нь өөртөө байсан бүх буйаа Ишагт өгөв. 6 Абрахам нь бага гэргийгээс гарсан хөвгүүддээ өглөгийг өгөөд, тэднийг Ишаг хөвгүүнээс өөр тийш зүүн зүг рүү явуулав. 7 Абрахам нь нэг зуун дал насласан билээ. 8 Абрахам нь өндөр настай болж, хөгшрөөд, нас барж, өөрийн улсад оршуулагдав. 9 Тийнхүү түүний Ишан, Ишмайл хоёр хөвгүүн нь Хэдийн Зухарын Махпала гэдэг хөндийд түүнийг булав. 10 Тэнд Абрахам болон түүний гэргий Са Ра хоёр хоёулаа булагдав. 11 Абрахам нь нөгчсөний дараа бурхан нь Ишагийг адистлав. Ишаг нь Лахаруй гэдэг худгийн ойролцоо суусан билээ. 12 Са Рагийн шивэгчин Хагарын Абрахамд төрүүлсэн хөвгүүн нь Ишмайлын хөвгүүд гэвэл, 13 Ишмайлын их хөвгүүн Нибамуд, Хидар, Адбиял, Мибшам, 14 Мишма, Дүмэ, Масса, Хадар, 15 Тимэ, Зитүр, Напис, Кидима нар билээ. 16 Эдгээр нь Ишмайлын хөвгүүд болон тэдний балгад ба цэргийн хүрээнүүдээр тэдний нэрс мөн гэвэл, арван хоёр улсын тэргүүлэгчид билээ. 17 Ишмайлын нэг зуун гучин долоон настай болоод, нас нөгчиж, өөрийн улсад оршуулагдав. 18 Тэр нь Ашүрт очих замаараа

Египетийн өмнөх Хавилагаас Шүр хүртэл нутаглан, өөрийн хамаг дүү нарын ойролцоо суусан билээ. 19 Абрахамын хөвгүүн Ишагийн хөвгүүд гэвэл, Абрахам нь Ишагийг төрүүлэв. 20 Ишаг нь Падан Арамын Сариягийн Битү Илийн охин болсон Лабаны дүү Рибикэг гэргий болгон авах үедээ дөчин настай байсан. 21 Ишагийн гэргий нь хүүсэр байсан тул Ишаг нь түүний төлөө бурханд залбирав. Бурхан нь түүнд хайрыг үзүүлснээр түүний гэргий Рибикэ нь жирэмсэн болов. 22 Тийм бөгөөд түүний дотор хүүхэд нь хөдлөхөд, тэр нь Яагаад энэ зүйл болов гэж өгүүлээд, бурхнаас асуухаар явав. 23 Бурхан нь түүнд Чиний умай дотор хоёр улс байгаа бөгөөд чамаас хоёр хүүхэд гарах буй. Нэг улс нь нөгөө улсаас хүчтэй болон ах нь дүүдээ зарагдах буй гэж зарлиг болгов. 24 Тийнхүү төрөх цаг болоход түүний умай дотор хоёр ихэр хүүхэд байсан. 25 Тийнхүү нэг дэх хүүхэд гарахад, тэр нь бүхэл биеэрээ үстэй, хувцас мэт ба улаан байсан. Түүнийг Ишау гэж нэрлэв. 26 Бас түүний дараа түүний дүү нь гарав. Түүний гар нь Ишаугийн өсгийг барин байв. Түүнийг Яахоб гэж нэрлэв. Тэднийг төрөх үед Ишаг нь жаран настай байсан. 27 Тийм бөгөөд хөвгүүд нь том болоход Ишау нь хэцүү ангууч болон хээрийн хүн байсан бөгөөд Яахоб нь гэрт суугч номхон хүн байсан. 28 Ишаг нь Ишаугийн агнасан ангийн махыг иддэг, учир түүнийг энхрийлж, хайрладаг байв. Рибикэ нь Яахобыг энхрийлж, хайрладаг байв. 29 Тийнхүү Яахобыг шөл чанаж байтал, Ишаг нь хээрээс ирээд ядарсан тул Яахобт; 30 Муна ядарсан тул чи надад улаан шөл идүүл! гэж өгүүлэв. Тийм учраас тэр нь Идум гэж нэрлэгдэв. 31 Яахоб нь түүнд өгүүлэв; Чи өөрийнхөө анх төрсөн ёсыг энэ өдөр надад худалд! гэж өгүүлсэнд Ишаг нь; 32 Би үхэх болсон тул миний анх төрсөн ёс нь надад ямар тустай вэ? 33 гэж өгүүлсэнд Яахоб нь; Энэ өдрөө надад тангарагла! гэж өгүүлсэнд тэр нь тангараглаж, өөрийн анхны төрсөн ёсыг Яахобт худалдав. 34 Тийнхүү Яахоб нь Ишагт талх болон улаан буудайны шөл өгсөнд, тэр нь идэж, ууж дуусаад, босож явав. Энэ мэтээр Ишаг нь өөрийн анхны төрсөн ёсоо доромжлов.

Хорин зургадугаар бүлэг

1 Абрахамын үед байсан нэгдүгээр зудаас өөр нэг зуд тэр газарт болов. Тийнхүү Ишаг нь Волиститны Абимилиг хааны Карарт очив. 2 Тийм бөгөөд бурхан нь түүнд оч! Миний чамд зарлиглах газарт очиж суу! 3 Энэ газарт нутагла! Тийнхүү би чамтай хамт байж, чамайг адистлах буй. Яагаад гэвэл, би энэ хамаг газрыг чамд болон чиний үрсэд өгч, чиний Абрахам эцэгт тангарагласан тангаргаа бүтээх буй. 4 Бас би чиний үрсийг огторгуйн одод мэт үлэмж олон болгож, хамаг газрыг чиний үрсэд өгөх буй. Жич, чиний үрсээр ертөнцийн хамаг улс нь адистлагдах буй. 5 Яагаад гэвэл, Абрахам нь миний дууг сонсож, миний захиа болон миний зарлиг ба миний тогтоол болон миний хуулиудыг сахисан билээ гэж зарлиг болов. 6 Тэгээд Ишаг нь Карарт суужээ. 7 Тийнхүү тэр орны хүмүүс нь түүний гэргийн тухай түүнээс асуусанд тэр нь; Миний дүү буй гэж өгүүлэв. Яагаад гэвэл, Рибикэ нь үзэсгэлэнтэй сайхан байсан тул түүний төлөө тэр газрын хүмүүс нь намайг ална гэж тэр айгаад, Энэ миний гэргий гэж хэлээгүй билээ. 8 Тийм бөгөөд түүнийг тэнд нь өнө удаан суусны дараа Волиститны Абимилиг хаан нь Ишагийг өөрийн гэргий Рибикэтэй наадан байсныг цонхоор харав. 9 Тэгээд Абимилиг нь Ишагийг дуудаж,

Рибикэ нь чиний гэргий мөн. Тийм байтал, Тэр нь миний дүү буй гэж чи юунд өгүүлэв гэсэнд Ишаг нь Би түүний төлөө эс үхэхийн тулд ийн өгүүлэв 10 гэж өгүүлсэнд Абимилиг нь Чиний бидэнд үйлдсэн нь юу вэ? Хүмүүсээс нэг нь чиний гэргийтэй хямдаар нөгцөж болох билээ. Тийм болсон бол чи бидний дээр хилэнцийг хүргэх байсан 11 гэж өгүүлсэнд Абимилиг нь бүх хүмүүст захин; Энэ хүнд эсвэл түүний гэргийд гараа хүргэгч нь эрхгүй үхэх буй гэж өгүүлэв. 12 Тийм бөгөөд Ишаг нь тэр оронд тариа тарьж, тэр жилдээ зуун давхарт өсгөврийг олов. 13 Тэр мэтээр Жахуа нь түүнийг адистидлав. 14 Түүнд хоньдын сүргүүд болон үхрийн сүргүүд ба олон боол буй билээ. 15 Тийм учраас Волиститан нь түүнд эцэг Абрахамын боолуудын малтсан хамаг худгийг Волиститан нь бөглөж, шороогоор дүүргэв. 16 Тийм бөгөөд Абимилиг нь Ишагт өгүүлэв; Бидний дотроос гар! 17 Яагаад гэвэл, чи биднээс илүү тэндээс гарч, Кирарын бэлд нутаглан тэнд суужээ. 18 Тэгээд Абрахамыг амьд байсан үед малтсан болон Абрахамыг нөгчсөний дараа Волиститаны бөглөсөн худгуудыг Ишаг нь дахин малтаад, өөрийн эцэг Абрахамын нэрлэсэн нэрээр нэрлэв. 19 Жич, Ишагийг боолууд нь бэлд газар малтаж, тэнд булгийн усны худгийг олов. 20 Харин Кирарын малчид нь Ишагийн малчидтай хэрэлдэж, Энэ бидний ус гэж өгүүлэв. Тийм учраас Ишаг нь тэр худгийг Эсэг гэж нэрлэв. Яагаад гэвэл, Кирарын малчид нь түүнтэй хэрэлдсэн тул билээ. 21 Тийм бөгөөд Ишагийн боолууд өөр нэг худаг малтсанд, Кирарын боолууд нь түүний төлөө эсэргүүцэлдэв. Тийм бөгөөд Ишаг нь тэр худгийг Шиүн Нэ гэж нэрлэв. 22 Жич, Ишаг нь тэндээс нүүж, өөр нэг худгийг малтаад, Кирарын боолууд тэр худгийн талаар эс эсэргүүцэлдсэн тул тэр худгийг Рихубуд гэж нэрлээд, өгүүлэв; Бурхан нь одоо биднийг аажим болгов. Бид ч газартай үрстэй болох буй гэж өгүүлэв. 23 Тэндээс тэр нь Биршибад очив. 24 Тэр шөнө Жахуа нь түүнд үзэгдэн, зарлиг болруун; Би бол чиний эцэг Абрахамын бурхан буй. Чи бүү айгтун! Яагаад гэвэл, би чамтай байгаа бөгөөд чамайг адистидлана. Миний боол Абрахамын төлөө чиний үрсийг үржүүлэх буй гэж зарлиг болов. 25 Тийнхүү тэр нь тэнд нэг тахилын ширээг өргөж, Жахуагийн нэрийг дуудаад, тэнд гэрээ барив. Ишагийн боолууд нь тэнд нэг худаг малтав. 26 Тийм бөгөөд Абимилиг болон түүний танил хүн Ахужад ба түүний цэргийн тэргүүлэгч Пихул нар нь Кирараас Ишагт ирэхэд тэр нь; 27 Та намайг өшөөлж, хүмүүсээ илгээгээд, яах гэж над дээр ирэв 28 гэж өгүүлсэнд тэд нь; Бид Жахуаг чамтай байхыг үзээд; Бид хоёрын хооронд тангараг байх болтугай! 29 Бид чамайг эс хилэгнүүлэн, чамд маш сайныг үйлдэн, чамайг амраар тавьсан мэт чи одоо Жахуагийн адистиданд хүртсэн тул бидэнд сайныг үйлд! гэж чамтай нэгэн тогтоолыг тогтооё! гэж өгүүлэв. 30 Тэгээд Ишаг нь тэдэнд нэг найрыг хийсэнд, тэд нь идэж, уусан буй. 31 Тэд маргааш нь босоод, өөр зуураа тангараглаад, Ишагийн тэднийг тавьсан ёсоор тэд нь түүнээс эвээр явав. 32 Мөн тэр өдрөө Ишагийн боолууд нь ирээд, тэдний малтсан худгийн тухай мэдүүлж, Бид усыг олов гэж өгүүлэв. 33 Ишаг нь түүнийг Шибэ гэж нэрлэв. Тийм учраас тэр балгас нь одоо болтол Биршиба нэртэй буй. 34 Тийм бөгөөд түүний хүү Ишау нь дөчин настай болоод, Хидийн улсаас Бийрийн охин Зүдид болон Илуны охин Башимадийг гэргийгээ болгон авав. Тэд нь Ишаг болон Рибикэд сэтгэлийн гашуудал болов.

Хорин долдугаар бүлэг

1 Тийнхүү Исаг нь хөгшрөөд, түүний нүд нь харж эс чадаад том хөвгүүн Ишаугаа дуудаад; Миний хөвгүүн ээ! гэхэд Ишау нь; Би энд байна. гэж өгүүлэв. 2 Ишаг нь; Би хөгшрөөд, өөрийн нөгчих цагийг эс мэднэ. 3 Тийм учраас одоо чи өөрийн саадаг болон нум зэвсгүүдийг аваад, хээр явж, миний төлөө гөрөөсийг агнаад, 4 миний дуртай амтат махыг бэлтгэж, надад авчирч идүүл! Тэгвэл намайг нөгчихөөс өмнө миний сүнс нь чамайг адистидлах буй. гэж өгүүлэв. 5 Тийм бөгөөд Рибикэ нь Ишагийн Ишауд өгүүлснийг сонсов. Ишау нь гөрөөсийг авчрахаар хээр ан хийж явав. 6 Тийм бөгөөд Рибикэ нь өөрийн Яахоб хөвгүүнд; Чиний эцэг нь чиний ахад; 7 Чи надад гөрөөсийг авч ирээд надад амттай идээг бэлд! Тэгвэл би нөгчихөөсөө өмнө идэж, Жахуагийн өмнө чамайг адистидлах буй гэж өгүүлэв. 8 Тийм учраас миний хөвгүүн ээ! Чи одоо миний дуу болон миний чамд захихыг сонс! 9 Чи сүрэгт очоод, тэндээс мянганы хоёр ишгийг авч ир! Би тэднийг чиний эцгийн дурладаг амтат идээ болгох буй. 10 Тэгээд чи эцэгтээ үүнийг аваачин үйлд! Тэр нь нөгчихөөсөө өмнө идэж, чамайг адистидлах буй. 11 гэсэнд Яахоб нь өөрийн эх Рибикэд; Би ах Ишау нь үстэй хүн бөгөөд би нирман хүн байтлаа 12 миний эцэг нь надад гараа хүргэвэл, би түүний өмнө мэхч мэт болоод, биедээ адистидныг бус харин хараалыг ирүүлэх буй. 13 гэж өгүүлсэнд түүний эх нь өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Миний дээр хараал болох болтугай! Гагцхүү миний дууг сонсоод, тэднийг авч ир! 14 гэж өгүүлсэнд Яахоб нь явж, тэднийг аваад эхдээ авч ирэв. Түүний эх нь түүний эцгийн дурладаг амтат идээг болгов. 15 Тийм бөгөөд Рибика нь гэрийн дотор өөртөө байдаг том хүү Ишаугийн сайн хувцаснуудыг аваад, өөрийн бага хүү Яахобт өмсгөв. 16 Бас тэр нь ишигний арьсыг түүний гар болон үсгүй хүзүүнд өмсгөөд, 17 өөрийн бэлтгэсэн амтат идээ болон талхыг өөрийн хүү Яахобт өгөв. 18 Тийм бөгөөд тэр нь өөрийн эцэгт очоод; Миний эцэг ээ! гэж өгүүлсэнд тэр нь; Миний хөвгүүн ээ! Би энд байна. Чи хэн бэ? 19 гэж өгүүлсэнд Яахоб нь эцэгтээ Би бол чиний том хүү Ишау бөгөөд чиний өгүүлснийг үйлдэв. Одоо чиний сүнс нь намайг адистидлахын төлөө чи босож, суугаад миний идээнээс ид! 20 гэж өгүүлсэнд Ишаг нь өөрийн хөвгүүнд өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Чи энэ мэтийг яаж хурдан олов. гэж өгүүлсэнд тэр нь; Чиний Жахуа бурхан нь түүнийг миний өмнө ирүүлэв. 21 гэж өгүүлсэнд Ишаг нь Яахобт өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Надад ойртож ир! Чи миний Ишау хөвгүүн мөн үү? Биш үү? гэж би чамд гараа хүргэсүгэй! 22 гэж өгүүлсэнд Яахоб нь өөрийн эцэг Ишагт ойртож, очиход тэр нь түүнд гараа хүргээд өгүүлэв; Дуу нь Яахобын дуу байна. Харин гар нь Ишаугийн гар буй гэж өгүүлэв. 23 Тийнхүү Яахобын гар нь түүний ах Ишаугийн үстэй гартай адил байсан тул тэр нь түүнийг эс таниад, адистидлав. 24 Бас Ишаг нь; Чи миний Ишау хөвгүүн мөн үү? гэж өгүүлсэнд тэр нь; Би мөн байна гэж өгүүлэв. 25 Тийм бөгөөд Ишаг нь өгүүлэв Миний хөвгүүн ээ! Би чамайг адистидласан тул чи надад ойртон, ир! Би чиний бэлтгэсэн идээнээс иднэ. гэж өгүүлээд Яахобыг ойртоход Ишаг нь түүний бэлтгэсэн идээ болон түүний авчирсан үзмийн ундааг уув. 26 Бас Ишаг нь Яахобт өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Ойртож ирээд намайг үнс! 27 гэж өгүүлсэнд Яахоб нь ойртоод түүнийг үнсэв. Тийм

байхдаа Ишаг нь түүний хувцасны үнэрийг үнэртэж, түүнийг адистидлаад, ийн өгүүлэв; Миний хөвгүүний үнэр нь Жахуагийн адистидлагдсан хээрийн үнэр мэт буй. 28 Тийм учраас Бурхан нь огторгуйн шүүдэр болон газрын элбэглэл ба их талх болон дарсыг чамд өгөх болтугай! 29 Улс нь чамд зарагдах бөгөөд ард нь чамд мөргөх болтугай! Чамайг хараагч хараагдах бөгөөд чамайг адистидлагч нь адистидлагдах болтугай! гэж өгүүлэв. 30 Тийм бөгөөд Ишаг нь Яахобыг адистидлаж, дууссанд Яахоб ч эцгийнхээ зүүн өмнөөс гарсантай зэрэгцэх түүний их Ишау нь ангаасаа ирэв. 31 Тэр ч амтат идээг бэлтгээд, өөрийн эцэгт ирээд, өгүүлэв; Миний эцэг нь өөрийн хөвгүүний бэлтгэсэн идээнээс идэхийн тулд бостугай! Яагаад гэвэл, чиний сүнс нь намайг адистидлахын төлөө билээ. 32 гэж өгүүлсэнд Ишаг нь; Чи хэн бэ? гэсэнд тэр нь; Би чиний хөвгүүн Ишау байна. гэж өгүүлэв. 33 Тийнхүү Ишаг нь маш их айн чичирч, өгүүлэв; Гөрөөсийг агнаад, махыг надад авчирсан хүн хэн бэ? Хаана байна вэ? Чамайг ирэхээс өмнө би цөм амтат идээнээс идэж, түүнийг адистидласан. Тэр ч адистидтан болсон. 34 гэж өгүүлсэнд Ишау нь өөрийн эцгийн үгсийг сонсоод, маш их гашуудан чанга дуугаар уйлж, эцэгтээ ийн өгүүлэв; Миний эцэг ээ! Намайг ч адисла! 35 гэж өгүүлсэнд эцэг нь Чиний дүү нь арга залиар ирээд, чиний адистидыг хүртэв. 36 гэж өгүүлсэнд тэр нь өгүүлэв Тэр нь намайг хоёр дахин мэхэлсэн тул Яахоб гэж зөв нэрлэсэн биш үү? Миний анхны төрсөн ёсыг аваад, одоо миний адисыг авав. Чи миний төлөө адисыг эс байлгав. 37 гэж өгүүлсэнд Ишаг нь Ишауд хариу өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Би түүнийг чиний ноён болгон, түүний хамаг ах дүү нарыг түүнд боол болгон өгөөд, түүнийг талх болон дарсаар тэтгээд, одоо чамд юуг үйлдэх вэ? 38 гэж өгүүлсэнд Ишау нь эцэгтээ ийн өгүүлэв; Чамд тэр ганцхан адис төдий буй уу? Миний эцэг ээ! Намайг , намайг ч адистидла! гэж өгүүлээд Ишау нь уйлав. 39 Тийм бөгөөд түүний эцэг Ишаг нь хариу өгүүлэв; Чиний нутаг нь газрын элбэглэлтэй болон дээд огторгуйн шүүдэртэй болох бөгөөд 40 чи сууж, дүүдээ зарагдах буй. Харин чи түүний дарсны дараа түүний ачааны тэргийг хүзүүнээсээ эвдэх буй. гэж өгүүлэв. 41 Тийм бөгөөд Ишау нь өөрийн эцгийг Яахобыг адистидласан адисын төлөө түүнийг өшөөлөөд, сэтгэлээрээ ийн өгүүлэв; Миний эцгийн тухай цорхирох цаг ойр байгаа бөгөөд би Яахоб дүүгээ алах буй. 42 гэж Рибикагийн том хүү Ишаугийн өгүүлсэн үгс нь түүнд өгүүлэгдэв. Тэр ч хүн илгээж, өөрийн бага хүү Яахобыг дуудаад, түүнд өгүүлэв; Чиний ах нь чамайг алсугай! гэж чиний тухай амлав. 43 Тийм учраас миний хөвгүүн ээ! Чи одоо миний дууг сонсож, босоод Хэрэн газарт байгч миний Лэбэн ахад зугтаан очоод 44 өөрийн ахынхаа хилэнг номхортол түүнтэй суу! 45 Тийм бөгөөд чиний ахын уурлал өнгөрөх бөгөөд тэр чиний үйлдсэнийг мартахад би хүн илгээж, чамайг тэндээс авах буй. Би та хоёрыг нэг өдөр яагаад гээх вэ? 46 гэж өгүүлсэнд Рибика нь Ишагт өгүүлэв; Энэ Хидийн охидын тухай би аминдаа дургүй болов. Хэрэв Яахоб нь Хидийн охидтой адил байгч энэ газрын охидоос гэргийг авбал миний амь нь надад юу болох вэ? гэж өгүүлэв.

Хорин наймдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Ишаг нь Яахобыг дуудаж, адистидлаад, түүнд захиж өгүүлэв; Чи

Ханаваны охидоос гэргий бүү ав! 2 Чи босоод Падан Арамд чиний эхийн Битү Ил эцгийн гэрт очоод, тэнд чиний эхийн ах Лабаны охидоос гэргийг ав! 3 Аугаа хүчит бурхан нь чамайг адистидлан, чамайг үрстэй болгон, үржүүлээд улсын чуулган болгох болтугай! 4 Бас тэр нь Абрахамын адисыг чамд болон чиний үрсэд ч өгч Абрахамд өгсөн чиний оролт болж, суусан газрыг чамд өгөх болтугай! 5 гэж өгүүлсэнд Ишаг нь Яахобыг илгээв. Тэр ч Падан Арамд Сариягийн Битү Илийн Лабан хөвгүүн болсон Ишау болон Яахобын Рибика эхийн ахад очив. 6 Тийм бөгөөд Ишау нь Ишагийн Яахобыг адистидлан, Падан Арамаас биедээ гэргийг авахын тулд тийш илгээсэн бөгөөд түүнийг адистидлан, байхад Ханаваны охидоос гэргийг бүү ав гэж захисан ба 7 Яахобын эцэг эхээ сонсож, Падан Арамд очсоныг үзээд 8 Ишау нь түүний эцэгт Ханаваны охидын тааламжгүй байхыг үзээд 9 Ишмайлд очоод, өөрийн гэргийдийн дээр Абрахамын Ишмайлын хөвгүүний Махалад охиныг гэргий болгон авав. Тэр охин нь Нибаяадын дүү билээ. 10 Тийм бөгөөд Яахоб нь Биришбагаас гараад, Харанд зорчин, байтал 11 нэгэн газарт хүрээд нар жаргасан тул тэнд хонохоор болоод тэр газрын чулуунаас аваад, толгойдоо дэр болгон тавиад тэр газарт хэвтэв. 12 Тийм бөгөөд тэр нь зүүдэндээ Нэгэн шат нь газар байсан бөгөөд түүний орой нь огторгуй хүрэв. Бас түүгээр бурхны элчүүд нь дээш болж, доош бууж, байсныг үзэв. 13 Жич, Жахуа нь түүний дээр байж, зарлиг болруун; Би чиний эцэг Абрахамын Жахуа бурхан мөн бөгөөд Ишагийн бурхан буй. Чиний хэвтсэн газар бүрийг чамд болон чиний үрсэд өгөх буй. 14 Чиний үрс нь газрын тоос мэт болох бөгөөд чи баруун болон зүүн ба хойт болон өмнө зүгүүдэд дэлгэрэх билээ. Бас чамаар болон чиний үрсээр ертөнцийн хамаг улс адистидлагдах буй. 15 Би чамтай байгаа бөгөөд чамайг явах бүрд чамайг сахих ба энэ газарт чамайг буцааж, миний чамд зарлиг болгосныг бүттэл, чамайг үл орхих буй гэж зарлиг болгов. 16 Тийнхүү Яахоб нь сэрээд, өгүүлэв; Үнэхээр Жахуа нь энэ газарт байна. Харин би эс мэдэв. 17 Бас тэр нь айж өгүүлэв; Энэ ямар аймшигтай газар вэ? Энэ нь бурхны гэрээс өөр биш. Энэ нь огторгуйн үүд мөн гэж өгүүлэв. 18 Тийм бөгөөд Яахоб нь өглөө эрт босоод, тэнд дэр болгон тавьсан чулууныг аваад, тахил болгон тавиад оройд нь тос асгав. 19 Тийнхүү тэр нь тэр газрыг Битил гэж нэрлэв. Эхлээд тэр нь балгасны нэр нь Лүз билээ. 20 Тийм бөгөөд Яахоб нь тангараглан өгүүлэв; Хэрэв бурхан нь надтай байх бөгөөд энэ миний явах замаар намайг сахих бөгөөд надад идэх идээ болно өмсөх хувцсыг өгөх бөгөөд 21 миний эцгийн гэрт намайг амархан буцаавал, Жахуа нь миний бурхан болох буй. 22 Жич, энэ миний тахил болгон тавьсан чулуу нь бурхны гэр болох бөгөөд чиний надад өгөх бүхнээс би арав дахь говийг чамд өгөх буй гэж өгүүлэв.

Хорин есдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд Яахоб нь босоод, зүүн улсын зүг явав. 2 Тийм бөгөөд тэр нь тариалангийн дотор нэг худаг болон түүний дэргэд хоньдын гурван сүрэг хэвтсэнийг харав. Яагаад гэвэл, малчид нь худгаас сүргээ усалдаг билээ. Жич, худгийн аман дээр нэг том чулуу байгаа билээ. 3 Тэнд хамаг сүргүүд цуглахад, малчид нь тэр чулууг худгийн аман дээрээс муруйлгаад, хоньдыг усалсны дараа

чулууг өөрийн оронд худгийн аман дээр тавьдаг билээ. 4 Тийм бөгөөд Яахоб нь тэдэнд өгүүлэв; Миний ах дүү нар аа! Та нар хаанаас ирсэн бэ? гэж өгүүлсэнд тэд нь бид Харанаас ирэв гэж өгүүлэв. 5 Тэр нь тэдэнд Та нар Нахурын Лабан ачийг таних уу? гэж өгүүлсэнд тэд нь; Бид танина гэж өгүүлэв. 6 Бас тэр нь тэдэнд өгүүлэв; Тэр амархан уу? гэсэнд тэд Тэр нь амархан буй. Бас түүний охин Рахил нь хоньдтой ирнэ гэж өгүүлэв. 7 Бас тэр нь өгүүлэв; Одоо эрт байгаа тул малыг цуглуулах болоогүй. Хоньдыг услаад, сахихаар явагтун! 8 гэж өгүүлсэнд тэд нь өгүүлэв; Сүргүүдийг услахын тулд бүх малчид нь цуглаж, чулууг худгийн аман дээрээс муруйлгахаас өмнө бид үүнийг үйлдэж үл чадна. гэж өгүүлэв. 9 Тийм бөгөөд түүнийг тэдэнтэй ярилцаж байтал Рахил нь өөрийн эцгийн хоньдтой ирэв. Тэр нь тэднийг сахьдаг билээ. 10 Тийм бөгөөд Яахоб нь өөрийн эхийн ах Лабаний охиныг болон өөрийн эхийн ах Лабаний хоньдыг хараад, ойртож худгийн аман дээрээс чулууг муруйлган, өөрийн эхийн ах Лабаний хоньдыг услав. 11 Жич, Яахоб нь Рахилийг үнсээд, уйлав. 12 Тийм бөгөөд Яахоб нь; Би чиний эцгийн ах дүү болон Рибикагийн хүү буй гэж Рибикад мэдүүлсэнд тэр нь гүйж эцэгтээ ийн өгүүлэв; 13 Тийм бөгөөд Лабан нь өөрийн дүүгийн хүү Яахобын тухай мэдээг сонсоод, түүнийг угтаж, үнсээд түүнийг гэртээ оруулав. Яахоб нь Лабанд хамаг болсон явдлаа мэдүүлэв. 14 Тийнхүү Лабан нь түүнд өгүүлэв; Чи миний яс болон мах мөн гэж өгүүлсэнд тэр нь түүнтэй нэг сар суув. 15 Тийм бөгөөд Лабан нь Яахобт өгүүлэв; Чи миний ах дүү мөн тул надад сулаар зарагдах ёстой буй. Чи ямар хөлс авахаа надад хэл! гэж өгүүлэв. 16 Лабанд хоёр охин байгаа билээ. Том охины нэр Ли Э болон бага охины нэр нь Рахил билээ. 17 Ли Э нь нүд муутай байв. Харин Рахил нь үзэсгэлэнт байдалтай ба сайхан царайтай билээ. 18 Яахоб нь Рахилийг бодож өгүүлэв; Би чиний бага охин Рахилийн төлөө чамд долоон жил зарагдана 19 гэж өгүүлсэнд Лабан нь; Түүнийг өөр хүнд өгөхөөс чамд өгсөн нь сайн буй. Чи надтай суу гэж өгүүлэв. 20 Тийнхүү Яахоб нь Рахилийн төлөө долоон жил зарагдсан боловч түүнийг бодсон тул энэ өдрүүд нь өчүүхэн өдрүүд мэт түүнд үзэгдэв. 21 Тийм бөгөөд Яахоб нь Лабанд; Миний ажлын өдрүүд дууссан тул миний гэргийг өгөн үйлд! Тийнхүү би түүнтэй нөгцөх буй 22 гэж өгүүлсэнд Лабан нь тэр газрын хүн бүгдийг цуглуулаад, хурим хийв. 23 Тийнхүү үдэш болоход тэр нь өөрийн охин Ли Эг авч Яахобт өгөв. Тэр ч түүнтэй нөгцөв. 24 Жич, Лабан нь өөрийн шивэгчин Жилфаг өөрийн охин Ли Эд шивэгчин болгон өгөв. 25 Тийм бөгөөд өглөө болоход тэр нь энэ Ли Э буй гэж мэдээд Лабанд өгүүлэв; Чиний надад үйлдсэн нь юу вэ? Би чамд Рахилийн төлөө зарагдсан биш үү? Чи намайг яагаад мэхлэв? 26 гэж өгүүлсэнд Лабан нь; Том охиноос өмнө бага охиныг хүнд өгөх нь манай оронд үл зохино. 27 Түүний долоон жилийг төгсгө! Тийм бөгөөд надад дахин долоон жил зарагдан, хөдөлмөрлөвөл, тэр нь чамд өгөгдөх буй 28 гэж өгүүлсэнд Яахоб нь тэр мэтийг үйлдэж, түүний долоон жилийг төгсгөв. Тийнхүү тэр нь өөрийн охин Рахилийг түүнд гэргий болгон өгөв. 29 Жич, Лабан нь өөрийн шивэгчин Билхаг Рахилийн шивэгчин болгон өгөв. 30 Тийнхүү Яахоб нь Рахилтэй нөгцөж, Рахилийг Ли Эгээс үлэмж энхрийлж, өөр долоон жил түүний төлөө зарагдав. 31 Тийм бөгөөд Жахуа нь Ли Эгийн өшөөлөгдсөнийг үзээд, түүнийг үрстэй болгов. Рахил нь хүүсэр билээ. 32 Тийм бөгөөд жирэмсэн болоод, нэг

хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Рүбин гэж нэрлэв. Яагаад гэвэл, Жахуа нь миний зовлонг үзэв. Одоо миний эр нь намайг энхрийлэх буй гэж өгүүлэв. 33 Бас тэр нь дахин жирэмсэн болоод, хөвгүүнийг төрүүлээд, өгүүлэв; Жахуа нь миний өшөөлөгдсөнийг сонсоод, үүнийг ч надад өгөв. гэж өгүүлээд, түүнийг Симира гэж нэрлэв. 34 Бас тэр нь жирэмсэн болоод, хөвгүүнийг төрүүлээд, ийн өгүүлэв; Одоо би эрдээ гурван хөвгүүнийг төрүүлсэн тул тэр нь энэ цагт надтай нөгцөх буй. гэж өгүүлэв. Тийм учраас тэр нь түүнийг Ливи гэж нэрлэв. 35 Бас тэр нь жирэмсэн болоод, нэг хөвгүүнийг төрүүлж, өгүүлэв; Энэ цагт би Жахуаг магтана. гэж өгүүлэв. Тийм учраас тэр нь түүнийг Иудей гэж нэрлэв. Тийм бөгөөд тэр нь дахин үл төрөв.

Гучдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Рахил нь Яахобт хүүхэд эс төрүүлснээ үзээд, өөрийн эгч Ли Эд атаархаж, Яахобт Надад хүүхэд өгч үйлд! Тийм биш бол би үхэх бий. 2 гэж өгүүлсэнд Яахоб нь Рихалд хилэгнээд; Би чамд умайн үрийг эс хайрласан бурхны оронд буюу? 3 гэж өгүүлсэнд тэр нь өгүүлрүүн; Энэ миний шивэгчин Билха байна. Түүнтэй нөгц! Тийм бөгөөд тэр нь миний өвдөгт хүүхдийг төрүүлэх буй. Тэгээд би түүнээс өдөөгдөх буй 4 гэж өгүүлээд өөрийн шивэгчин Билхаг Яахобт гэргий болгон өгсөнд тэр нь түүнтэй нөгцөв. 5 Тийм бөгөөд Билха нь жирэмсэн болоод, Яахобт нэг хөвгүүнийг төрүүлэв. 6 Тийнхүү Рахил нь; Бурхан намайг шүүгээд, миний дууг сонсоод, надад нэг хөвгүүнийг өгөв. Тийм учраас түүнийг Дэн гэж нэрлэв. 7 Жич, Рахилийн шивэгчин Билха нь дахин жирэмсэн болоод, Яахобт хоёр дахь хөвгүүнийг төрүүлэв. 8 Тийм бөгөөд Рахил нь; Би маш их барилдаанаар өөрийн эгчтэй барилдаад дийлэв. гэж өгүүлэв. Тийм учраас тэр нь түүнийг Напаталь гэж нэрлэв. 9 Тийм бөгөөд Ли Э нь төрөхөө больсноо үзээд, өөрийн шивэгчин Жилпаг аваад, Яахобт гэргий болгон өгөв. 10 Ли Эгийн шивэгчин Жилпа нь Яахобт нэг хөвгүүнийг төрүүлэв. 11 Тийнхүү Ли Э нь Нэг чуулган ирнэ гэж өгүүлсэн тул түүнийг Кад гэж нэрлэв. 12 Бас Ли Эгийн шивэгчин Жилпа нь Яахобт хоёр дахь хөвгүүнийг төрүүлэв. 13 Тийнхүү Ли Э нь; Би амгалантай буй. Яагаад гэвэл, эхнэрүүд нь намайг амгалантай буй гэж нэрлэдэг гэж өгүүлээд, түүнийг Ашир гэж нэрлэв. 14 Тийм бөгөөд Рүбин нь тариаг хадах цагт явж, байхдаа үнэртэй жимсийг олоод, өөрийн эх Ли Эд авч ирэв. Тийм бөгөөд Рахил нь Ли Эд; Чиний хөвгүүний үнэртэй жимснээс надад өгч хайрла 15 гэж өгүүлсэнд Ли Э нь; Миний эрийг авсан нь чамд бага буй уу? Бас чи миний хөвгүүний үнэртэй жимсийг ч авах буй уу? гэж өгүүлсэнд Рахил нь; Тийнхүү тэр нь чиний хөвгүүний жимсний төлөө энэ шөнө чамтай хэвтэнэ гэж өгүүлэв. 16 Тийм бөгөөд Яахобт хээрээс ирэхэд Ли Э нь түүнийг угтахаар гараад, ийн өгүүлэв; Чи надад ир! Яагаад гэвэл, би өөрийн хөвгүүний жимсний хөлсөөр чамайг хөлсөлж авав гэж өгүүлсэнд тэр нь түүнтэй тэр шөнө хэвтэв. 17 Тийм бөгөөд бурхны Ли Эг сонссоноор тэр нь жирэмсэн болоод, Яахобт тав дахь хөвгүүнийг төрүүлэв. 18 Тийм бөгөөд Ли Э нь өгүүлэв; Намайг өөрийн шивэгчнээ эрдээ өгсний төлөө бурхан нь надад шагналыг өгөв гэж өгүүлээд түүнийг Ишмахар гэж нэрлэв. 19 Бас Ли Э нь жирэмсэн болоод Яахобт зургаа дахь хөвгүүнийг төрүүлээд, өгүүлэв; Бурхан нь надад сайн өглөгийг хайрласан тул одоо миний эр нь надтай нөгцөх буй. 20 Яагаад гэвэл, би түүнд

зургаан хөвгүүдийг төрүүлэв. Тийм учраас тэр нь түүнийг Сабулун гэж нэрлэв. 21 Үүнээс хойш тэр нь нэг охиныг төрүүлээд, түүнийг Динна гэж нэрлэв. 22 Тийм бөгөөд бурхан нь Рахилийг санаж, сонсоод түүнийг үртэй болгов. 23 Тийм бөгөөд тэр нь жирэмсэн болж, нэг хөвгүүнийг төрүүлээд, өгүүлэв; Бурхан нь миний ичгүүрийг надаас авав 24 гээд түүнийг Иосиб гэж нэрлээд, бас өгүүлэв; Жахуа нь надад нэг өөр хөвгүүнийг нэмэх болтугай! гэж өгүүлэв. 25 Тийм бөгөөд Рахилийн Иосибийг төрсөн үед Яахоб нь Лабанд өгүүлэв. Намайг орон болон зүгтээ очихын тулд намайг тавь! 26 Миний чамд хөдөлсний хөлс болсон миний гэргийд болоод хүүхдүүдийг надад өгөөд тавь! Яагаад гэвэл, чи миний чамд үйлдсэн хөдөлмөрийг мэднэ 27 гэж өгүүлсэнд Лабан нь; Чи чиний өмнө хайрыг олсугай гэвэл, чиний төлөө Жахуа намайг адистидласныг би мэднэ. 28 Чи хөлсөө надад мэдүүл! Тийм бөгөөд би өгөх буй 29 гэж өгүүлсэнд тэр нь түүнд өгүүлэв; Миний чамд яаж хөдөлснийг болон чиний мал надтай яаж байсныг би мэднэ. 30 Яагаад гэвэл, надаас өмнө чамд байсан нь бага боловч тэр нь нэмэгдэж, их болов. Намайг ирсэн цагаас бурхан нь чамайг адистидласан буй. Одоо би өөрийн гэрийн төлөө хэзээ хөдлөх вэ? 31 гэж өгүүлсэнд тэр нь; Би чамд юуг өгөх вэ? гэж өгүүлсэнд Яахоб нь; Чи надад юуг ч бүү өг! Хэрэв чи надад энэ мэтийг үйлдвэл, би дахин чиний хоньдыг идүүлж, сахих буй гэвэл, 32 Би энэ өдөр чиний бүх хоньдын дунд алсдан, тэндээс хоньдын хамаг цоохор болон алаг ба улаавтар болон ямаадын алаг болон цоохруудыг салгасугай! Тийнхүү үүнээс хойш тэр мэтэс нь миний хөлс болох болтугай! 33 Тийнхүү чи хойт цагтаа миний хөлсийг үзэхийн төлөө ирвэл, миний зөв нь миний төлөө чиний өмнө гэрчлэх буй. Бас ямаанаас ямар ч цоохор болон алаг бус бөгөөд хоньдоос ямар нь ч улаавтар бус тэд нь миний хулгайлсан мэт болох болтугай! 34 гэж өгүүлсэнд Лабан нь; Чиний өгүүлснээр болох болтугай! 35 гэж тэр өдөр хамаг алаг тэх болон цоохор ба алаг ямаад ба хамаг цагаан толботой болон улаавтар хоньдыг салгаад, өөрийн хөвгүүдийн гарт өгөв. 36 Бас тэр нь өөрийн болон Яахобын хооронд гурван өдрийг явах газрыг тавив. Яахоб нь Лабаний өөр хоньдыг сахисан билээ. 37 Тийм бөгөөд Яахоб нь Шинэ үйлс болон Шид ба өөр модны гишүүдийг аваад тэдний зоргодсыг өвчиж, цагаан Журом Журмаар болгоод, үүгээр гишүүдийн дээр байгч цагааныг нүцгэн болгов. 38 Тийм бөгөөд тэр нь өөрийн өвчсөн гишүүдийг сувгийн дотор байгч ховоонд тавив. Яагаад гэвэл, хоньд нь ус уухын тулд ирэхдээ ууж, байхдаа хээлтэй болохын төлөө билээ. 39 Тийм бөгөөд хоньд нь гишүүдийн өмнө хээлтэй болоод, эрээн болон цоохор ба алаг хориодыг төрүүлэв. 40 Тийм бөгөөд Яахоб нь хориодыг ялгаж, хамаг хоньдын нүүрийг Лабаний сүргийн дотор байгч эрээн болон улаавтар бүгдэд харуулав. Бас тэр нь өөрийн хоньдыг тусад нь тавиад, Лабаний хоньдтой эс тавив. 41 Тийм бөгөөд хүчтэй малын хээлтэй болох цагт тэдний гишүүдийн дунд хээлтэй болохын тулд Яахоб нь малын сувагт гишүүдийг тавив. 42 Зүгээр, мал нь хүчгүй бол тэр нь гишүүдийг эс тавив. Энэ мэтээр хүчгүй мал нь Лабанийх болов. Харин хүчтэйчүүд нь Яахобынх болов. 43 Жич, тэр хүн нь маш их болж, бүрэн түүнд олон хоньд болон шивэгчид ба боолууд болон тэмээд ба илжигнүүд билээ.

Гучин нэгдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд Яахоб нь бидний эцэгт байсан бүгдийг аваад, бидний эцэгт байснаас тийм хөрөнгөтэй болов. гэж Лабаний хөвгүүдийн өгүүлснийг Яахоб сонсов. 2 Бас Яахоб нь Лабаний нүүр өмнөхөөс өөр болсныг үзэв. 3 Тийм бөгөөд Жахуа нь Яахобт зарлиг болруун; Чи өөрийн эцэг нарын газар болон өөрийн төрөлд харь! Би чамтай байна гэж зарлиг болов. 4 Тийм бөгөөд Яахоб нь илгээж, хээр байсан малынхаа дэргэд Рахил болон Ли Эцг дуудан тэдэнд; 5 Таны эцгийн нүүрийг өмнөхөөс өөр байхыг би үзнэ. Зүгээр, миний эцгийн бурхан нь надтай байсан буй. 6 Миний хамаг чадлаараа таны эцэгт зарагдсаныг та мэднэ. 7 Жич, таны эцэг намайг мэхэлж, миний хөлсийг арав дахин хувилгав. Тийм боловч бурхан нь надад мууг үйлдэхийг түүнд эс өгөв. 8 Хэрэв тэр нь; Цоохрууд нь чиний хөлс болно гэж өгүүлбэл хамаг хоньд нь цоохруудыг төрүүлсэн билээ. Хэрэв тэр нь; Эрээнүүд нь чиний хөлс болно гэж өгүүлбэл, хамаг хоньд нь эрээнүүдийг төрүүлсэн билээ. 9 Энэ мэтээр бурхан нь таны эцгийн малыг аваад, надад өгсөн буй. 10 Тийм бөгөөд хоньдын хээлтэх цагт би зүүдэндээ үзэв. Хоньдын дээр дэвхрэгч хуцнууд нь эрээн болон цоохор ба цагаан толботой билээ. 11 Тийм бөгөөд бурхны элч нь зүүдэнд надад зарлиг болруун; Яахоб аа! гэж зарлиг болсонд Би энд байна. гэж айлтгав. 12 Тэр нь; Чи ширтэж, хоньдын дээр дэвхрэгч хуцнуудын эрээн болон цоохор ба цагаан толботой байхыг үз! Яагаад гэвэл, би Лабаний чамд үйлдсэн бүхнийг үзэв. 13 Би бол Битилийн бурхан буй. Чи тэнд нэг овоог тослоод, тэнд нэг бат үгийг надад айлтгасан буй. Одоо босоод, энэ газраас гарч, өөрийн төрлийн газарт харь! гэж зарлиг болгов 14 гэсэнд Рахил болон Ли Эцнь түүнд хариу өгүүлэв; Бидний эцгийн гэрт бидэнд хувь эсвэл өмч байгаа юу? 15 Бид түүнд оролт мэт тоогдсон биш үү? Яагаад гэвэл, тэр нь биднийг худалдаад, бидний мөнгийг ч идэж орхив. 16 Жич, бидний эцгээс бурхны авсан аливаа баяжил нь биднийх болон бидний хөвгүүдийнх билээ. Одоо чамд бурхны зарлиг болгосноор үйлд! гэж өгүүлэв. 17 Тийм бөгөөд Яахоб нь босоод, өөрийн эцэг Ишаг Эцигт Ханаван газарт очихын тулд хөвгүүд болон гэргийдээ тэмээдийн дээр суулгаад 18 Падан Арамд хураас бүгд мал болон хураасан эд таваараа авч явав. 19 Лабан нь өөрийн эцгийн хөргүүдийг хулгайлж, авав. 20 Тийнхүү Яахоб нь өөрийн явах тухай Сарагийн Лабанд үзүүлэлгүй нууцаар одов. 21 Энэ мэтээр тэр болон түүнд байсан нь зайлж, босоод голыг гаталсны дараа Киянд уулны зүгт зорчив. 22 Тийм бөгөөд гурав дахь өдрөө Яахоб нь Зайлав гэж Лабанд өгүүлсэнд 23 тэр нь өөрийн ах дүү нарыг дагуулан, Яахобын хойноос долоон хоногийн замаар нэхээд, Хилиант ууланд гүйцэв. 24 Зүгээр, бурхан нь Сарагийн Лабанд шөнөөр зүүдэнд нь ирээд; Чи Яахобтай сайныг ч мууг ч өгүүлэхээс цээрлэ! гэж зарлиг болсон билээ. 25 Тийм бөгөөд Лабан Яахобыг гүйцэхэд, Яахоб нь өөрийн майхныг ууланд барьсан бөгөөд Лабан нь өөрийн майхныг Хилиант ууланд барив. 26 Тийм бөгөөд Лабан нь Яахобт; Чи надаас нууцаар зайлаад, манай охидыг илтээр авсан олзлогдогсод мэт аваачиж, юуг үйлдэв? 27 Бас чи далдаар зайлж, надаас нууж, надад яагаад ул эс үзүүлвэл, би баяр болон дуу ба хэнгэрэг болон ятгаар чамайг явуулах билээ. 28 Харин чи манай хөвгүүд болон охидыг үнсээгүй надад эс өгснөөр одоо мунхагаар үйлдэв. 29 Миний гар танд мууг үйлдэх чадалтай боловч харин таны эцгийн бурхан нь өнгөрсөн шөнө надад Чи Яахобтай

сайныг ч мууг ч үйлдэхээс цээрлэ! гэж зарлиг болов. 30 Одоо чи өөрийн эцгийн гэрт машид дурласны төлөө явахдаа миний бурхдыг яагаад хулгайлж авав. 31 гэж өгүүлсэнд Яахоб нь Лабанд хариу; Би айж, чамайг өөрийн охидыг надаас хүчээр авах болжээ гэж өгүүлэв. 32 Чи хэнд өөрийн бурхдыг олбол, тэр нь амьдаар үл байх болтугай! Чи надад байгч өөрийн буйыг бидний ах дүү нарын өмнө танивал, түүнийг өг! Яагаад гэвэл, Яахоб нь Рахилийн тэднийг хулгайлж авсныг эс мэдэв. 33 Тийм бөгөөд Лабан нь Яахобын майхан болон Ли Эгийн майхан ба хоёр шивэгчдийн майхнуудад орж эс олоод, Ли Эцгийн майхнаас гараад, Рахилийн майханд оров. 34 Зүгээр, Рахил нь тэр хөргүүдийг авч, тэмээний ачаанд нуугаад, тэдний дээр суусан билээ. Тийнхүү Лабан нь тэднийг бүхэл майхнаар эрээр эс олов. 35 Тийм бөгөөд Рахил нь эцэгтээ; Эхнэрийн бэлэг надад байгаа бөгөөд намайг босож, чадахгүй тэдний тухай миний ноён нь үл хилэгнэх болтугай! гэж өгүүлсэнд тэр нь хайвч хөргүүдийг эс олов. 36 Тийм бөгөөд Яахобын хилэн төрөөд, Лабантэй хэрэлдэж, Лабанд хариу; Чиний намайг яарч, нэхсэний төлөө миний буруу юу вэ? Миний хилэнц нь юу вэ? 37 Чи миний эд таваар бүхнийг үзээд, өөрийн гэрийн аливаа эд таваараас юуг олов? Миний ах дүү нар болон чиний ах дүү нарын өмнө тавь! Тэд нь бид хоёрын хооронд шүүх болтугай! 38 Би чамтай эдгээр хорин жилийн турш буй бөгөөд чиний хоньд болон ямаад нь зулзагаа эс орхисон бөгөөд чиний хуцнуудыг би эс идэв. 39 Би таслагдсан хоньдыг чамд эс авчран, өөрөө дагасан буй. Чи өдрөөр хулгайлагдсан болон шөнөөр хулгайлагдсануудыг миний гараас хэрэглэсэн билээ. 40 Намайг энэ мэтээр байж, байхад өдрөөр халуун болон шөнөөр хүйтэн нь намайг хатаадаг нойр нь миний нүднээс хагацав. 41 Би чиний гэрт хорин жил сууж байхдаа чиний хоёр охидын төлөө арван дөрвөн жил болон малын төлөө зургаан жил чамд зарагдав. Бас чи миний хөлсийг арав дахин хувилгасан буй. 42 Хэрэв миний эцгийн бурхан бол Абрахамын бурхан Ишагийн айдас нь надтай эс байсан бол одоо чи намайг лавтайяа хоосон илгээх билээ. Бурхан нь миний зовнил болон миний гарын үйлийг үзээд, чамайг өнгөрсөн шөнө хорив гэж өгүүлэв. 43 Тийм бөгөөд Лабан нь Яахобт хариу; Эдгээр охид нь миний охид бөгөөд эдгээр хөвгүүд ч миний хөвгүүд буй. Энэ мал нь миний мал бөгөөд чиний аливаа үзсэн нь минийх буй. Би миний охид болон тэдний төрсөн хөвгүүдэд юуг үйлдэх вэ? 44 Тийм учраас одоо би нэг хоёр тогтоолыг тогтооё! Тэр нь бид хоёрын хооронд гэрч болох болтугай! 45 гэж өгүүлсэнд Яахоб нь нэг чулууг авч овоо болгон тавиад, 46 чулуунуудыг цуглуулагтун! гэж ах дүү нартаа өгүүлэв. Тэд ч чулууг авч, нэг овоо бий болгов. Тийнхүү тэд нь овооны дээр итгэлцэв. 47 Тэгээд Лабан нь түүнийг Жигар, Сака Дүта гэж нэрлэв. Харин Зэкүд нь түүнийг Галита гэж нэрлэв. 48 Тийм бөгөөд Лабан нь; Энэ овоо нь энэ өдрөө бид хоёрын хооронд гэрч буй. Тийм учраас тэр нь Галит гэж нэрлэгдэв. 49 Бас Миспа гэж нэрлэгдэв. Яагаад гэвэл, тэр нь өгүүлрүүн; Биднийг өөрсдөөсөө салцгаасны дараа Жахуа нь бид хоёрын хооронд сахих болтугай! 50 Хэрэв чи миний охидыг зовоох, эсвэл миний охидоос өөр гэргийдийг авбал, бидэнтэй хүнгүй боловч бурхан нь бид хоёрын хооронд гэрч болох болтугай! 51 Бас Лабан нь Яахобт өгүүлэв; Бид хоёрын хооронд миний тавьсан энэ овоо болон босголыг үз! 52 Би чамд мууг үйлдэхийн тулд энэ овоог үл

өнгөрөх бөгөөд чи надад мууг үйлдэхийн тул энэ овоо болон босголыг үл өнгөрнө гэж энэ овоо болон босгол нь гэрч болох болтугай! 53 Абрахамын бурхан болон Нахурын бурхан бол тэдний эцгийн бурхан бидний хооронд шүүх болтугай! гэж өгүүлэв. Яахоб ч өөрийн эцэг Ишагийн аялгаар тангараглав. 54 Тийм бөгөөд Яахоб нь уулан дээр малыг алж, ах дүү нартаа идээг идүүлэхээр дуудсанд тэд нь идээг идээд, шөнө дуустал уулан дээр байв. 55 Тийм бөгөөд Лабан нь маргааш нь эрт босоод, өөрийн хөвгүүд болон охидыг үнсэж, адистидлаад, өөрийн газартаа буцаж ирэв.

Гучин хоёрдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Яахобыг явж байхад бурхны элчүүд нь түүнтэй тааралдав. 2 Яахоб нь тэднийг үзээд; Энэ нь бурхны чуулган буй гэж өгүүлсэн тул тэр газрыг Маханайм гэж нэрлэв. 3 Тийм бөгөөд Яахоб нь Идум орны Сийр газарт байгч өөрийн ах Ишауд элч нарыг илгээж, тэдэнд захиж; 4 Та миний Ишау ноёнд өгүүлэгтүн! Чиний боол Яахоб нь өгүүлэх нь; Би Лабантэй сууж, одоо болтол удав. 5 Бас надад үхрүүд болон илжигнүүд ба хоньд болон боолууд ба шивэгчид байгаа бөгөөд би чиний өмнө хайрыг олохын тулд миний ноёдод мэдүүлж илгээв. гэж захив. 6 Тийм бөгөөд элч нар нь Яахобт буцаж; Бид чиний ах Ишауд хүрэв. Бас тэр нь чамтай уулзахын тулд өөртэйгээ дөрвөн зуун хүмүүсийг дагуулна 7 гэж өгүүлсэнд Яахоб нь ихэд айж, сэтгэлээр зовоод, өөртөө байсан улс ба хоньд ба үхрүүд болон тэмээдийг хоёр хэсэг болгон хуваав. 8 Бас тэр нь; Хэрэв Ишау нь нэг хэсэгт ирээд, түүнийг цохивол, үлдсэн хэсэг нь тонилох буй гэж өгүүлэв. 9 Тийм бөгөөд Яахоб нь бас; Аяа, миний Абрахам эцгийн бурхан болон миний Ишаг эцгийн бурхан аа! Намайг өөрийн газар болон өөрийн төрөлд харьж од! Би чамд сайныг үйлдэнэ гэж зарлиг болгосон Жахуа аа! 10 Би чиний боолдоо үзүүлсэн хайр болон чиний үзүүлсэн хамаг үнэнээс бага буй гэвэл, би өөрийн таягаар энэ Иорданыг гатлаад, одоо хоёр хэсэг болсон буй. 11 Миний ах Ишаугийн гараас намайг тонилгон соёрх! Тэр нь ирээд, намайг ба эхчүүдийг хүүхэдтэй цохих байх гэж айна. 12 Бас чи Би чамд үнэхээр сайныг үйлдээд, чиний үрсийг далайн тоолшгүй элс мэт олон болгох буй гэж зарлиг болгов гэлээ. 13 Тийм бөгөөд тэр шөнө тэндээ хоноод, өөрийн гарт байсан бүхнээсээ өөрийн ах Ишауд өгөхийг авав. Үүнд; 14 хоёр ямаа болон хорин тэх ба хоёр зуун хоньд ба хорин хуц ба 15 гучин ботготой тэмээ болон дөчин үнээ ба арван бух болон хорин гүү илжиг ба арван унагуудыг авч 16 өөрийн боолуудын гарт сүрэг сүргээр өгч тэдэнд өгүүлэв; Миний ах Ишаугийн сүргийн хооронд завсар болгогтун! 17 Бас тэр нь эхний хүнд захиж; Миний ах Ишау чамтай уулзаад, чамаас Чи хэн бэ? Хаашаа явна вэ? Чамтай байгчид нь хэн бэ? гэж асуухад нь 18 чи Эдгээр нь чиний боол Яахобынх бөгөөд миний ноён Ишауд бэлэг болгон илгээгдсэн буй. Бас тэр нь бидний хойно байгаа гэж өгүүлэн үйлд. гэв. 19 Бас тэр нь энэ мэтээр хоёр дахь ба гурав дахь ба сүргүүдийг дагагчдад захиж Та нар Ишаутай уулзахдаа эдгээр үгсийг өгүүлэгтүн! 20 гэж өгүүлээд, бас Чиний боол Яахоб нь бидний хойно буйг өгүүлэгтүн! гэж захив. Яагаад гэвэл, тэр нь өгүүлэв; Би өөрийнхөө өмнө явж, буй бэлгээр түүнийг хангасны дараа түүнтэй уулзах буй. Тэр нь намайг таалах буй гэж өгүүлэв. 21

Тийм бөгөөд тэр бэлэг нь түүний өмнө явж тэр шөнөө чуулганы дотор хонов. 22 Жич, тэр нь тэр шөнөө босож, өөрийн хоёр гэргийд болон хоёр шивэгчид ба арван нэгэн хөвгүүдээ аваад, Яабабуг гэдэг олмоор гатлав. 23 тэр нь тэднийг авч, горхийг гатлаад, өөртөө байсан бүхнээ гатлав. 24 Тийм бөгөөд Яахоб ганцаар үлдсэнд, нэг хүн үүр цайтал түүнтэй барилдав. 25 Тэр нь түүнийг эс дийлсэн тул түүний гуяны хонхорхойд гараа хүргэсэнд Яахобыг барилдаж байхад түүний гуяны хонхорхой нь булгарав. 26 Тийм бөгөөд тэр нь; Үүр цайж байгаа тул намайг тавь! гэсэнд тэр нь Хэрэв чи намайг үл адистидлавал, би чамайг үл тавина 27 гэж хэлсэнд тэр нь түүнд; Чиний нэр хэн бэ? гэсэнд тэр нь Яахоб гэж өгүүлэв. 28 Тэр нь; Чи үүнээс хойш Яахоб гэж үл нэрлэгдэн, Израйл гэж нэрлэгдэх буй. Яагаад гэвэл, чи нэг ноён мэт бурхантай хүчит хүнийг ч дийлэх буй гэж зарлиг болгов. 29 Яахоб нь; Чиний нэр хэн бэ? надад хэлж соёрх! гэж түүнээс асуухад тэр нь Чи миний нэрийг яагаад асууна вэ? гэсэнд түүнийг тэнд адистидлав. 30 Тийм бөгөөд Яахоб нь тэр газрыг Пинияал гэж нэрлэв. Яагаад гэвэл, Бурхныг нүүр нүүрээрээ харавч, миний амь нь тонилов. гэж өгүүлэв. 31 Тийм бөгөөд Пинияалийг алсдахад, нар нь түүний дээр гарав. Тэр нь гуяараа доголож явав. 32 Тийм учраас Израйлийн хөвгүүд нь гуяны хонхорхой дээр татсан шөрмөснөөс одоо болтол үл иднэ. Яагаад гэвэл, Яахобын гуяны татсан шөрмөсэнд түүнийг гараа хүргэсэн тул билээ.

Гучин гуравдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Яахоб нь нүдээрээ ширтэж, Ишау болон түүнтэй дөрвөн зуун хүн ирж байхыг харав. Тийм бөгөөд тэр хүүхдүүдийг Ли Э болон Рахил ба хоёр шивэгчдэд хуваан өгөв. 2 Жич, тэр нь шивэгчид болон тэдний хүүхдийг өмнө зэрэгцүүлэн, тэдний дараа Ли Э болон түүний хүүхдүүдийг зэрэгцүүлэн, тэдний хойно Рахил болон Иосибыг зэрэгцүүлэн зогсоов. 3 Тийнхүү тэр нь тэдний өмнө өнгөрөн өөрийн ахыг ойр иртэл долоо дахин хөсөр мөргөв. 4 Тийнхүү Ишау нь түүнийг угтахын тулд гүйн түүнийг тэврээд, түүний хүзүүнд оноод, түүнийг үнсэв. Жич, тэр хоёр хоёулаа уйлав. 5 Тийм бөгөөд тэр нь нүдээрээ ширтэж, гэргийд болон хүүхдүүдийг үзээд өгүүлэв; Чамтай байгч эдгээр нь хэн хэн бэ? гэж өгүүлсэнд тэр нь; Бурхны чиний боолд хайрласан хүүхдүүд буй гэж өгүүлэв. 6 Тийм бөгөөд шивэгчид нь хүүхдүүдтэйгээ ойртоод, мөргөв. 7 Ли Э нь хүүхдүүдтэйгээ ойртоод мөргөв. Түүний дараа Иосиб болон Рахил нь ойртоод, мөргөв. 8 Тийм бөгөөд тэр нь өгүүлэв; Миний уулзсан чиний сүргүүд нь юу вэ? гэж өгүүлсэнд тэр нь; Миний ноёны өмнө хайрыг олохын тулд буй 9 гэж өгүүлсэнд Ишау нь өгүүлэв; Миний дүү! Надад олон байгаа. Чамд юу байна тэд нь чамд байх болтугай! 10 гэж өгүүлсэнд Яахоб нь ; Тийм бус болгож хайрла! Хэрэв би чиний өмнө хайрыг олсон бол миний гараас миний бэлгийг авч хайрла! Яагаад гэвэл, би бурхны нүүрийг үзсэн мэт чиний нүүрийг үзсэн бөгөөд чи намайг таалсан буй. 11 Миний чамд барьсан бэлгийг авч хайрла! Яагаад гэвэл, бурхны надад хайрласнаар надад олон буй гэж ихэд гуйснаар тэр нь аваад өгүүлэв; 12 Бид явж аялая! Би чиний өмнө явна 13 гэж өгүүлсэнд тэр нь түүнд; Хүүхдүүд болон надтай хургатай хоньд болон тугалтай үхрүүд байгаа бөгөөд хэрэв, нэг өдөр тэднийг

яаруулан, явуулбал сүрэг бүхэн үхэх буй гэж миний ноён мэднэ. 14 Миний ноён өөрийн боолын өмнө явтугай! гэж өгүүлэв. 15 Тийнхүү Ишау нь өгүүлэв; Би өөрийн улсаас заримыг нь чамтай орхисугай! гэж өгүүлсэнд тэр нь; Яагаад вэ? Би өөрийн ноёны өмнө хайрыг олох болтугай! гэж гуйна. Би мал болон хүүхдүүдийн чадлаар тэднийг хөтөлж, миний ноёны Сайрт ирнэ гэж өгүүлэв. 16 Тийнхүү Ишау нь тэр өдрөө өөрийн замаар Сайрт харив. 17 Яахоб нь Сүкүд хүртэл яваад, гэр бариад, малд дэл хашаануудыг барив. Тийм учраас тэр газар нь Сүкүд гэж нэрлэгдэв. 18 Тийм бөгөөд Яахоб нь Падан Арамаас ирэхэд Ханаванд байгч Шихимийн Шалим балгасдад ирээд, өөрийн гэрийг тэр балгасадын өмнө барив. 19 Жич, тэр нь өөрийн гэрийг барьсан газрын нэг хувийг Шихимийн Хамур гэгч эцгийн хөвгүүдээс зуун хориодоор худалдаж авав. 20 Бас тэр нь тэнд нэг тахилын ширээг өрөөд, түүнийг Ил Илухи Израйл гэж нэрлэв.

Гучин дөрөвдүгээр бүлэг

1 Тэндээс Ли Эгийн Яахобт төрүүлсэн охин Динна нь тэр газрын охидыг үзэхээр гарав. 2 Тийнхүү тэр орны Хивигийн Хамур ноёны хөвгүүн Шихим нь түүнийг үзэж, аваад түүнтэй хэвтээд бузарлав. 3 Жич, тэр Яахобын охин Диннад их дуртай болоод, тэр охиныг энхрийлж, сайн үгсээр хэлэлцэв. 4 Бас Шихим нь Хамур эцэгтээ; Энэ охиныг миний гэргий болгон автугай! гэж өгүүлэв. 5 Тийнхүү Яахоб нь өөрийн охин Диннаг бузарлагдсан тухай сонссон боловч харин түүний хөвгүүдийн малтай хээр байсан тул тэднийг харин иртэл Яахоб нь юуг ч эс өгүүлэв. 6 Тийм бөгөөд Шихимийн Хамур эцэг нь Яахобтай хэлэлцэхийн тулд явав. 7 Харин Яахобын хөвгүүд нь үүнийг сонсоод, хээрээс ирэв. Тэдгээр хүмүүс нь гашуудан, ихэд уурлав. Яагаад гэвэл, тэр нь Яахобын охинтой хэвтсэнээр, Израйлийн дотор нүглийг үйлдэв. Энэ мэтийг үйлдэх нь зөв бус билээ. 8 Тийнхүү Хамур нь тэдэнтэй хэлэлцэж өгүүлэв; Миний хөвгүүний сэтгэл нь таны охинд их дуртай байгаа тул түүнийг гэргий болгон өгч хайрла! 9 Жич, бидэнтэй ураг болон өөрийн охидыг бидэнд өгч, бидний охидыг биедээ ав! 10 Тийм болбол, таныг бидэнтэй суухад энэ орон нь таных болох буй. Та түүний дотор сууж, худалдаа хийж, өөрийн өмчөө болгон үйлд! гэж өгүүлэв. 11 Бас Шихим нь Диннагийн эцэг болон ах дүү нарт; Би таны өмнө хайрыг олох болтугай! Таны надад юу өгүүлэхийг би өгөх буй. 12 Та надаас их үнэ болон их бэлгийг хүсвэл, би өгөх буй. Энэ охиныг миний гэргий болгон өгтүгэй! 13 гэж өгүүлсэнд Яахобын хөвгүүд нь Шихим болон түүний эцэг Хамурт мэхээр хариу өгүүлэв; Яагаад гэвэл, тэр тэдний дүү Даннаг бузарласан билээ. 14 Тийнхүү тэд нь тэдэнд өгүүлэв; Бид үүнийг үйлдэнэ гэвэл, өөрийн дүүг эс хэрчигдсэн хүнд өгч эс чадна. Энэ бидэнд ичгүүртэй байна. 15 Харин танаас эр бүр нь бид мэт хэрчигдвэл, түүнээр бид танд зөвшөөрөх билээ. 16 Тийм болбол, бид өөрийн охидыг танд өгч, таны охидыг өөртөө авч тантай сууж, ганц улс мэт болох болтугай! 17 Хэрэв та хэрчихийн тухай биднийг эс сонсвол, бид дүүгээ аваад явах болно. 18 гэж өгүүлсэнд тэдний үгс нь Хамур болон Хамурын хүү Шихимд тааламжтай болов. 19 Жич, тэр залуу нь Яахобын охинд их дуртай болсон тул энэ зүйлийг удалгүй үйлдэв. Бас тэр нь өөрийн эцгийн гэрт байгч бүхнээс хүндтэй билээ. 20 Тийм бөгөөд Хамур болон түүний хүү Шихим нь өөрийн

балгасны хаалганы өмнө ирээд, өөрийн балгасны хүмүүстэй хэлэлцэж өгүүлэв; 21 Эдгээр хүмүүс нь бидэнтэй номхон буй. Энэ газар нь тэдний өмнө их уужим буй. Бид тэдний охидыг гэргийдээ болгон өөртөө авч, өөрийн охидыг тэдэнд өгөх болтугай! 22 Харин тэдгээр хүмүүс нь бидэнтэй сууж, бидэнтэй ганц улс болохыг ямагт үүнээр зөвшөөрнө гэвэл, хэрэв бидний эр бүр нь тэдний хэрчигдсэн ёсоор хэрчигдвэл, тэд нь зөвшөөрөх буй. 23 Тэдний эд таваар ба мал адгуус нь бүгд биднийх болох биш үү? Бид тэдэнд зөвшөөрье! Тэгвэл тэд нь бидэнтэй суух буй 24 гэж өгүүлсэнд өөрийн балгасны хаалгаар гарагч хүн бүр Хамур болон түүний хөвгүүн Шихимийн хэлэхийг сонсоод, өөрийн балгасаар гарагч эр бүр хэрчигдэв. 25 Тийм бөгөөд гурав дахь өдөр тэднийг өвчтэй байхад нь Яахобын хөвгүүн ба Даннагийн ах Симион болон Ливи ах нар нь хоёулаа илдээ аваад, тэр балгасанд аюулгүйгээр ирээд, хамаг эрсийг алав. 26 Тэд нь Хамур болон Шихимийг илдээр алаад, Шихимийн гараас өөрийн дүү Динагаг аваад гарав. 27 Жич, Яахобын хөвгүүд нь алагдагсдад ирээд, тэдний балгасыг тонов. Яагаад гэвэл, тэдний дүүг бузарласны төлөө билээ. 28 Бас тэд нь тэдгээрийн хоньд болон үхрүүд ба илжигнүүдийг авч балгасны дотор байсан ба гадаа хээрт байсан бүгдийг авав. 29 Жич, тэдний эд таваар болон хүүхэд ба гэргийд болон гэрийн дотор байсан бүхнийг тоноод нүүлгэв. 30 Тийм бөгөөд Яахоб нь Симион болон Ливид өгүүлэв.; Та нар энэ газарт суугч Ханаваны болон Парижийн улсын дунд намайг муу үнэртэй болгож зовоов. Миний өчүүхэн тоотой байсан тул тэд нь миний тус цуглаад, намайг алж, намайг болон миний гэрийг хоосруулах буй 31 гэж өгүүлсэнд тэд нь; Бидний дүүтэй садар эмийн ёсоор үйлдэх нь зөв буй уу? гэж асуув.

Гучин тавдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Бурхан нь Яахобт зарлиг болруун; Чи босож, Битилд очоод тэнд суу! Бас чиний Ишау ахыгаа өмнөөс зайлах цагт чамд үзэгдсэн бурханд нэг тахилын ширээг өр! 2 гэж зарлиг болсонд Яахоб нь өөрийн гэрийн улс болон өөртэйгээ хамт байгчдад; Таны дотор байгч бурхдыг биеэсээ салгаж, биеэ ариун болгоод, өөр хувцсыг өмсөгтүн! 3 Бас бид босоод, Битилд очье! Миний зовлонгийн цагт хариу зарлиг болсон хийгээд миний явсан замаар надтай байсан бурханд би тэнд тахилын ширээг үйлдэнэ 4 гэж өгүүлсэнд тэд нь өөрийн гарт байгч өөр бурхад болон өөрийн чихэнд байсан сүйхүүдийг Яахобт өгөв. Яахоб нь тэднийг Шихимийн өмнө байгч нэг Тирибинта модны доор нуув. 5 Тийм бөгөөд тэднийг явж байтал, тэдний тойронд байгч балгадын улсын дээр бурхны аюул байсан билээ. Тэд ч Яахобын хөвгүүдийг эс нэхэв. 6 Тийн Яахоб болон түүнтэй байгч хамаг улс Лүзэд ирэв. Тэр нь Ханаваны дотор байгч Битил буй. 7 Тэнд тэр нь нэг тахилын ширээг өрөөд, тэр газрыг Ил Битил гэж нэрлэв. Яагаад гэвэл, түүний ахын өмнөөс зайлахад бурхан түүнд тэнд үзэгдсэн билээ. 8 Тийнхүү Рибикагийн Дибура нэртэй хөхүүлсэн эм нь үхээд, Битилийн доор байгч Тирибинта модны доор булагдав. Тийм учраас тэр газар нь Аллун Бэкүд гэж нэрлэгдэв. 9 Тийм бөгөөд Яахобыг Падан Арамаас ирэхэд бурхан нь түүнд дахин үзэгдээд, түүнийг адистидлав. 10 Жич, бурхан нь түүнд; Чиний нэр нь Яахоб мөн билээ. Чи үүнээс хойш Яахоб гэж үл нэрлэгдэнэ. Чиний нэр нь Израйль болно. гэж зарлиг болгон түүнийг Израйль

гэж нэрлэв. 11 Жич, бурхан нь түүнд; Би аугаа хүчтэй бурхан буй. Чи үрстэй болж үржтүгэй! Чамаас улс болон улсын чуулган нь гарах бөгөөд чиний бэлхүүснээс хаад гарах буй. 12 Жич, Абрахам болон Исагт миний өгсөн газар гэвэл, тэр газрыг би чамд болон чиний дараа чиний үрсэд өгсүгэй! 13 гэж зарлиг болоод, бурхан нь түүнтэй зарлигласан газраасаа өөд болов. 14 Тийм бөгөөд Яахоб нь түүний өөртөө зарлиг болсон газраа нэг чулуун босголыг босгоод, түүний дээр нэг ундааны өргөлийг асгаад, бас тосыг асгав. 15 Тийм бөгөөд Яахоб нь өөртөө бурхны зарлиг болсон газрыг Битил гэж нэрлэв. 16 Тийм бөгөөд тэднийг Битилээс явж байтал Ипарадын ойр ирсэнд Рахил нь төрөв. Төрөхдөө машид зовов. 17 Тийм бөгөөд түүний төрөхдөө зовоход туслагч эхнэр нь түүнд; Чи бүү айтугай! Яагаад гэвэл, чамд энэ нь хөвгүүн болох буй гэж өгүүлэв. 18 Харин тэр нь нөгчин байтал, амийг гаргах цагт түүнийгээ Они гэж нэрлэв. Түүний эцэг нь түүнийг Бинзамин гэж нэрлэв. 19 Энэ мэтээр Рахил нь нөгчиж, Ипарадад явах замд булагдав. Ипарадад гэдэг нь Бэтлэхим буй. 20 Тийнхүү Яахоб нь Рахилийн хүүрийн булшин дээр нэг суварганыг босгов. Одоо болтол Рахилийн булшны дээр тэр суварган нь байгаа. 21 Тийнхүү Израйль нь явж, өөрийн гэрийг Хидарын асрын цаана барив. 22 Тийм бөгөөд Израйлийг тэр газраа сууж байхад Рүбин нь өөрийн эцгийн бага гэргий Билхад очоод, түүнтэй хэвтэв. Бас Израйль нь үүнийг сонсов. 23 Израйлийн хөвгүүд нь арван хоёр билээ. Ли Эцгийн хөвгүүд гэвэл, Израйлийн том хөвгүүн Рүбин болон Симион ба Ливи болон Иудей ба Иссахар болон Сабулун 24 Рахилийн хөвгүүд, Иосиб болон Бинзамин 25 Рахилийн шивэгчин Билхагийн хөвгүүд, Дэн болон Набатали. 26 Ли Эгийн шивэгчин Жилнагийн хөвгүүд, Гад болон Ашур билээ. Эдгээр нь Падан Арам газар Яахобт төрөгдсөн хөвгүүд билээ. 27 Тийм бөгөөд Яахоб нь өөрийн Ишаг эцэгт Мамрын Арба балгасанд ирэв. Мамри нь Абрахам болон Ишагийн нутагласан Хибрун газар мөн билээ. 28 Ишаг нь зуун ная насласан билээ. 29 Тийм бөгөөд Ишаг нь хөгшин болон насаар дүүрэн болоод, амийг гаргаж, нөгчөөд, өөрийн улсад хоригдов. Тийнхүү түүний хүү Ишау болон Яахоб нь булав.

Гучин зургадугаар бүлэг

1 Идум гэгдсэн Ишаугийн үрс; 2 Ишау Ханаваны улсын охидоос Хитийн Илуны охин Э Дэ ба Хивийн Жибуяунын ач Э Нэгийн охин Ахулибама ба 3 Нибаяудын дүү Исмайлын охин Башимад нарыг гэргийд болгон авав. 4 Э Дэ нь Ишауд Илипажийг төрүүлэв. Башимад нь Ригулыг төрүүлэв. 5 Ахулибама нь Жиүс болон Алам ба Күрэг төрүүлэв. Эдгээр нь Ханаван газарт төрсөн Ишаугийн хөвгүүд буй. 6 Ишау нь өөрийн гэргийд болон хөвгүүд ба охид болон гэрийн хамаг улс ба мал адгуусад болон Ханаван газарт хураагдсан эд таваар бүхнийг аваад өөрийн дүү Яахобын өмнөөс өөр газарт очив. 7 Яагаад гэвэл, тэдний зоорийг нь их болсон тул хамт сууж, үл болох билээ. Тэдний малын тухай тэдний нутагласан газар нь тэднийг багтааж үл чадах билээ. 8 Энэ мэтээр Ишау нь Сийр ууланд суужээ. Ишау гэдэг нь Идум буй. 9 Сийр ууланд байгч Идум улсын эцэг Ишаугийн үрс нь; 10 Ишаугийн хөвгүүдийн нэрс нь; Илибаз Ишаугийн гэргий Башимадын хөвгүүн билээ. 11 Тиман болон Умар ба Жипу болон Китама ба Киназ нар нь Илипажагийн

хөвгүүд билээ. 12 Тимна нь Ишаугийн хөвгүүн Илипажагийн бага гэргий болоод, Илипажад Амалийг төрүүлэв. Эдгээр нь Ишаугийн гэргий Э Дэгийн үрс билээ. 13 Нахад болон Жира ба Шамма болон Мижа нар нь Риү Илийн хөвгүүд буй. Эдгээр нь Ишаугийн гэргий Башимадын хөвгүүд билээ. 14 Жибуяун ач Э Нэгийн охин болон Ишаугийн гэргий Ахулибамагийн хөвгүүд нь; Тэр нь Ишауд Жиүс болон Жис Алам ба Күрэг төрүүлэв. 15 Ишаугийн хөвгүүдээс гарсан ахлагчид гэвэл, Ишаугийн том хөвгүүн Илипажагийн хөвгүүд нь Тиман ахлагч, Умар ахлагч, Жипу ахлагч, Киназ ахлагч, 16 Кидам ахлагч, Амалих ахлагч билээ. Эдгээр нь Идум газарт Илипажагаас гарсан ахлагчид билээ. Тэд нь Э Дэгийн үрс билээ. 17 Ишаугийн хөвгүүн Риү Илийн хөвгүүд нь; Надад ахлагч, Жира ахлагч, Шимма ахлагч, Шамма ахлагч Мица ахлагч буй. Эдгээр нь Идум газарт Риү Илээс гарсан ахлагчид буй. Тэд нь Ишаугийн гэргий Башимадын үрс билээ. 18 Ишаугийн гэргий Ахулибамагийн хөвгүүд нь; Жиүс ахлагч, Жия Алам ахлагч, Күрэ ахлагч. Эдгээр нь Э Нэгийн охин болон Ишаугийн гэргий Ахулибамагаас гарсан ахлагчид билээ. 19 Эдгээр нь Идум гэгч Ишаугийн хөвгүүд бөгөөд эдгээр нь тэдний ахлагч нар билээ. 20 Тэр газарт урьд суусан Хуригийн Сийрын хөвгүүд нь; Лутан болон Шубал ба Жибияд болон Э Нэ ба 21 Дишун болон Ижир ба Диман билээ. Эдгээр нь Хуритны ахлагчид болон Идум газарт Сийрын хөвгүүд билээ. 22 Хури болон Хишам нь Лутаны хөвгүүд билээ. Тимна нь Лутаны охин дүү билээ. 23 Алван болон Манахад ба Ибэл болон Шипү ба Унам нар нь Шубалын хөвгүүд билээ. 24 Э, И болон Э Нэ нар нь Жибияны хөвгүүд билээ. Э Нэ нь өөрийн эцэг Жибиядын илжгүүдийг сахиж байхдаа луусуудыг говьд олсон буй. 25 Дишун болон охин Ахулибама нар нь Э Нэцгийн хүүхэд буй. 26 Химдан болон Ишбан ба Итран болон Хирэн нар нь Дишуны хүүхдүүд билээ. 27 Билхан болон Захаван ба Акан нар нь Ижирын хөвгүүд билээ. 28 Үжэ болон Аран нар нь Дишаны хөвгүүд билээ. 29 Хуритны ахлагчид гэвэл, Лутан ахлагч болон Шубал ахлагч ба Жибияд ахлагч болон Э Нэ ахлагч ба 30 Дишун ахлагч ба Ижир ахлагч, Дишан ахлагч. Эдгээр нь өөрийн Сийр газрын ахлагч нарын хооронд Хуританы ахлагч нар билээ. 31 Израйлийн хөвгүүдийн эзлэх хаан болохоос урьд Идум газарт эзэлсэн хаад гэвэл, 32 Биурын хөвгүүн Билэ нь Идум газарт эзлэв. Түүний хотын нэр нь Динаба билээ. 33 Билэг нөгчсөнд Бужрагаас Цирагийн хөвгүүн Зүбүн нь түүнийг эзлэв. 34 Зүбүнийг нөгчсөнд Тиманы газрын Хүшам нь түүний оронд эзлэв. 35 Хүшамыг нөгчсөнд түүний оронд Бидадын хөвгүүн Хадад нь эзлэв. Тэр нь Муаб газарт Мидияаныг таслав. Түүний хотын нэр нь Шавид билээ. 36 Хаддын нөгчсөнд Масрикагаас Самла нь түүний оронд эзлэв. 37 Самлаг нөгчсөнд Савул нь Рихубудаас гол хүртэл түүний оронд эзлэв. 38 Савул нөгчсөнд Ахбур Ба Ал Ханан хөвгүүн түүний оронд эзлэв. 39 Ахбурын Ба Ал Ханан хөвгүүнийг нөгчсөнд түүний оронд Хадар эзлэв. Түүний хотын нэр нь Пау бөгөөд түүний гэргийн нэр нь Мажахуны охин Матидын Михитабил билээ. 40 Ишаугийн ахлагчид өөрийн төрлийн ёсоор болон өөрийн орны ёсоор, ба өөрийн нэрсийн ёсоор гэвэл, Тимна ахлагч, Алва ахлагч, Житиун ахлагч, 41 Ахулибима ахлагч, Ий Ла ахлагч, Пинун ахлагч, 42 Киназ ахлагч, Таман ахлагч, 43 Мибжар ахлагч, Микдияал ахлагч, Ирам ахлагч. Эдгээр нь өөрийн өмчийн газарт нутгийн ёсоор Идумын ёсоор ахлагчид буй. Идум улсын эцэг нь

Ишау билээ.

Гучин долдугаар бүлэг

1 Яахоб нь өөрийн эцгийн оролт болон нутагласан газар гэвэл, Хагаван газарт суув. 2 Яахобтай тохиолдогсод нь; Иосиб нь арван долоон настай болоод, өөрийн ах нартай хонийг сахив. Тийнхүү тэр залуу нь өөрийн эцгийн Билха болон Жилпа гэргийдийн хөвгүүдтэй байж, байхдаа тэдний муу үйлсийн учрыг эцэгтээ мэдүүлэв. 3 Израйль нь Иосибийн өөрийн хамаг хөвгүүдээс үлэмж энхрийлэв. Яагаад гэвэл, өөрийг нь хөгширсөн хойно төрсөн тул билээ. Бас тэр нь түүнд нэгэн олон өнгөт дээлийг үйлдэв. 4 Тийм бөгөөд түүний ах нар нь өөрийн эцгийг түүний хамаг ах нараас үлэмж үнэлснийг үзээд, түүнийг өшөөлж, түүнтэй угтайгаар хэлэлцэж эс чадав. 5 Бас Иосибийн зүүдийг зүүдлээд, ах нартаа үзүүлснээр тэд нь урьдаас түүнийг үлэмж өшөөлөв. 6 Тийнхүү тэр нь тэдэнд Миний энэ зүүдийг сонсогтун! 7 Бидний тариаланд тарианы боолтуудыг уяж байна. Миний боолтыг босоод байхад таны боолт нь миний боолтыг хүрээлэн түүнд хөсөр мөргөв 8 гэж өгүүлсэнд түүний ах нар нь түүнд; Чи бидний дээр эзлэх буй уу? Эсвэл чи бидний ахлагч болох буй уу? гээд зүүд болон үгсийн төлөө түүнийг үлэмж өшөөлөв. 9 Тэр нь бас нэг зүүдийг зүүдлээд, өөрийн эцэг болон ах нартаа; Би өөр нэг зүүдийг зүүдлэв. Нар болон сар ба арван нэгэн од нь надад хөсөр мөргөв 10 гэж эцэг болон ах нартаа өгүүлэхэд түүний эцэг нь түүнийг зэмлэж; Чиний зүүдэлсэн зүүд нь юу вэ? Харин би болон чиний эх ба ах дүү нар нь чамд хөсөр мөргөхөөр ирэх биш үү? гэж өгүүлэв. 11 Тийнхүү түний ах нар нь түүнд атаархав. Зүгээр, түүний эцэг нь тэр үгсийг ажиглав. 12 Тийм бөгөөд түүний ах нар нь өөрийн эцгийн хоньдыг сахихын тулд Шихимд очсон билээ. 13 Тийнхүү Израйль нь Иүшүигт; Чиний ах нар нь Шихимд мал сахидаг биш үү? Чи ир! Би чамайг тэдэнд илгээнэгэж өгүүлсэнд тэр нь; Би энд байна гэж түүнд өгүүлэв. 14 Тэр нь түүнд; Чи очоод ах нар мэнгэтэй юу? Бас хоньд мэнгэтэй юу? гэж үзээд надад мэдүүл гэж өгүүлээд, түүнийг Хибаруны бэлээс илгээв. Тэр ч Шихимд ирэв. 15 Тийм бөгөөд түүний хээрт төөрөн байхад нэг хүн нь түүнийг олоод, түүнээс; Чи юуг хайна вэ? 16 гэсэнд тэр нь; Би өөрийн ах нарыг хайж байна. Тэдний хаана сахин байгааг надад өгүүлж хайрла! 17 гэж өгүүлсэнд тэр хүн нь; Тэд нь надаас явав. Яагаад гэвэл, бид Дутанд очъё! гэж тэдний өгүүлснийг сонсов гэж өгүүлсэнд Иосиб нь өөрийн ах нарыг даган, Дутанд олов. 18 Тэд нь түүнийг холоос харахад, түүнийг ойр ирэхээс өмнө түүнийг алахаар арга олов. 19 Тийнхүү тэд нь өөр зуураа өгүүлэлдэв; Энэ хэтэрхий зүүдлэгч ирж байна. 20 Одоо ирэгтүн! Бид түүнийг алж, нэг худагт хаяад, ан нь түүнийг идэв гэж өгүүлъя! Тийнхүү түүний зүүдний юу болохыг үзье! гэж өгүүлэлдэв. 21 Зүгээр, Рүбин нь үүнийг сонсоод, түүнийг тэдний гараас тонилгож өгүүлэв; Түүний амийг бүү тасалъя! 22 Бас Рүбин нь тэдэнд өгүүлэв; Цусыг бүү асгагтун! Энд говьд нэг худгийн дотор түүнийг хаягтун! Харин түүний дээр гараа бүү өргөгтүн! гэж өгүүлэв. Түүний өгүүлсний шалтгаан гэвэл, түүнийг тэдний гараас тонилгоод, өөрийн эцэгт хариулахын төлөө билээ. 23 Тийм бөгөөд Иосибийн ах нартаа ирсэнд тэд нь Иосибийн дээр байгч олон өнгөтэй дээлийг тайлаад, 24 түүнийг аваад нэг худагт хаяв. Тэр худаг нь усгүй хоосон билээ. 25

Тийм бөгөөд тэд нь идээг идэхийн тулд суун, нүдээрээ дээшээ ширтээд, Килиядаас ирээд, сайхан үнэртэн болон Балсам ба Мийрануудаар ачигдсан тэмээдтэй Египетэд очих Ишмайлтаны нэг аялагч чуулганыг үзэв. 26 Тийм бөгөөд Иудей нь ах дүү нартаа; Хэрэв бид өөрийн дүүг алж, түүний цусыг нуувал, ямар тус болох вэ? 27 Явъя! Түүнийг Ишмайлтанд худалдъя! Зүгээр, бидний гар нь түүний дээр үл болох болтугай! Яагаад гэвэл, тэр нь бидний дүү болон бидний мах мөн гэж өгүүлсэнд түүний ах дүү нар нь түүнийг сонсов. 28 Тийм бөгөөд Мидиянтаны худалдагчдын тэнд алсдахад, тэд нь Иосиб худгаас татаж, өргөөд Иосибийн Шимайлтанд хорин цэн мөнгөөр худалдав. Тэд нь Иосиб Египетэд аваачив. 29 Рүбин нь тэр худагт очиж, Иосиб тэр худагт үгүй байсныг үзээд, хувцсаа цуулав. 30 Тэр нь өөрийн дүү нарт өгүүлэв; Тэр хөвгүүн нь үгүй болов. Би хаана очих вэ? гэж өгүүлэв. 31 Тийм бөгөөд тэд нь Иосибийн дээлийг авч нэг ямааны ишгийг алаад, тэр дээлийг цусанд норгов. 32 Тийнхүү тэд нь тэр олон өнгөт дээлийг илгээж, өөрийн эцэгт авч ирүүлээд; Бид үүнийг олов. Энэ нь чиний хөвгүүний дээл мөн үү? Биш үү? гэж мэдтүгэй! гэж захив. 33 Тийнхүү тэр нь түүнийг таниад; Энэ нь миний хөвгүүний дээл мөн байна. Нэг муу ан нь түүнийг идэв. Иосиб нь үнэхээр таслагдав 34 гэж Яахоб нь хувцсаа цуулаад, зүдгүүрт хувцсыг бэлхүүсэндээ өмсөөд, хөвгүүний тухай гашуудав. 35 Тийм бөгөөд түүний хөвгүүд болон охид нь түүнийг амруулахаар босовч тэр нь амрахыг үл хүсэн өгүүлэв; Би өөрийн хөвгүүнд хүүрийн булш хүртэл гашуудаж явна. гэж өгүүлэв. Энэ мэтээр түүний эцэг нь түүний төлөө уйлав. 36 Тэд нь Митиятан нь түүнийг Египетэд Вораугийн биеийг сахигч түшмэдээс нэг Путивур ахлагчид худалдсан билээ.

Гучин наймдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Иудей өөрийн ах дүү нараас яваад, Адүлэмтанаас нэг Хүрэ нэртэй хүний ойр буув. 2 Иудей нь тэнд Ханаванаас нэг Шүвэ нэртэй хүний охиныг үзээд, түүнийг авч түүнтэй нөгцөв. 3 Тийнхүү тэр нь жирэмсэн болоод, нэг хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Ир гэж нэрлэв. 4 Жич, тэр нь дахин жирэмсэн болоод, нэг хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Унан гэж нэрлэв. 5 Бас тэр нь дахин жирэмсэн болоод нэг хөвгүүнийг төрүүлээд, түүнийг Шила гэж нэрлэв. Түүнийг төрөхөд Иудей нь Кизибнэд байлаа. 6 Тийм бөгөөд Иудей нь өөрийн том хөвгүүн Ирд нэг гэргий авав. Түүний нэр нь Тамар гэдэг билээ. 7 Харин Ир нь Жахуагийн өмнө муу болов. Тийнхүү Жахуа нь түүнийг өгүүлэв. 8 Тийн Иудей нь Унанд; Чи өөрийн ахын гэргийг авч түүнтэй нөгцөн, ахдаа үрийг босгон үйлд! гэж өгүүлэв. 9 Унан нь тэр үр нь өөрийн үл болно гэж мэдээд, ахынхаа гэргийтэй нөгцөж, ахдаа үрийг үл өгөхийн тулд газар асгав. 10 Тийм бөгөөд түүний үйлдсэнийг Жахуагийн өмнө мууг болсны тул тэр нь түүнийг ч үхүүлэв. 11 Тийм бөгөөд Иудей нь өөрийн бэр Тамарт; Миний хөвгүүн Шилаг том болтол чи өөрийн эцгийн гэрт бэлбэснээр суу! Яагаад гэвэл, түүний ах нар мэт үл үхэхийн тулд билээ гэж өгүүлсэнд Тамар нь яваад, өөрийн эцгийн гэрт суув. 12 Тийм бөгөөд удаан байсны дараа Шүвагийн охин байсан Иудейгийн гэргий нөгчив. Тийнхүү Иудейг амарсны дараа тэр болон Адүламтанаас түүнийг Хирэ нөхөр нь Тимнадад байгч түүний хоньдыг Хаячилнанд явав. 13

Тийнхүү чиний хадам эцэг нь хоньдоо Хаячилнаны төлөө Тимнадад очно гэж Тамарт өгүүлэгдсэнд 14 тэр нь бэлбэсний хувцсаа биеэсээ тайлан аваад, хөшгийг өмсөөд, өөрөө хучаад, Тимнадад очих замаар Инаймын илэрхий газарт суув. Яагаад гэвэл, Шила нь том болсон боловч тэр нь түүнд гэргий болж эс өгөгдсөнөө үзсэн билээ. 15 Тийм бөгөөд Иудей нь түүнийг үзээд, садар эм байна гэж санав. Яагаад гэвэл, тэр нь нүүрээ бүрхсэн билээ. 16 Тийм бөгөөд тэр нь замаас түүнд гараад, өөрийн бэр мөн гэж эс мэдэж түүнд; Намайг биедээ оруулж, хайрла! гэж өгүүлсэнд тэр нь Чи надад орохын тулд юу өгөх вэ? 17 гэж өгүүлсэнд тэр нь; Би сүргээсээ нэг мянган ишгийг илгээнэ гэж өгүүлсэнд тэр нь; Чи үүнийг илгээтэл, нэг барьцааг өгнө үү? 18 гэж өгүүлсэнд тэр нь; Би ямар барьцааг чамд өгөх вэ? гэсэнд тэр нь; Тамга болон бугуйвч ба гартаа байгч таягаа өгөн үйлд! гэж өгүүлсэнд тэр нь түүнд тэднийг өгөөд, түүнд оров. Тийнхүү тэр нь түүнээс жирэмсэн болов. 19 Тийм бөгөөд тэр нь тэндээс яваад, хөшгөө биеэсээ аваад, бэлбэсний хувцсаа өмсөв. 20 Тийм бөгөөд Иудей нь тэр гэргийн гараас өөрийн барьцааг авахын тулд өөрийн Адүламын нөхрөөр ишгийг илгээвч, тэр нь түүнийг эс олоод, 21 тэндэх газрын хүмүүсээс асуухад; Энэ эм эс байсан буй гэж өгүүлэв. 22 Тийм бөгөөд тэр нь буцаж, очоод, Иудейд; Би түүнийг эс олов. Тэр газрын хүмүүс нь энд садар эм эс байсан гэж өгүүлэв гэв. 23 Тийнхүү Иудей нь; Бидний үл ичихийн тулд тэр нь тэднийг автугай! Би энэ ишгийг илгээвч, чи түүнийг эс олов гэж өгүүлэв. 24 Тийм бөгөөд гурван сар болсны дараа Чиний бэр Тамар нь тачъяалдаад, тачъяангуйгаар жирэмсэн болов гэж Иудейд мэдэгдсэнд Иудей нь; Түүний гаргагтун! Тэр нь түлэгдэх болтугай! гэж өгүүлэв. 25 Тийнхүү түүнийг гарахад, тэр нь өөрийн хадам эцэгт; Эдний эзнээс би жирэмсэн болов. Чи энэ тамга болон бугуйвч ба таягийг хэнийх болохыг ялган мэдтүгэй! 26 гэж өгүүлсэнд Иудей нь тэднийг таньж; Тэр нь надаас зөв буй. Яагаад гэвэл, би түүнийг өөрийн хөвгүүн Шилад эс өгсөн тул билээ. Тэр нь түүнийг дахин эс мэдэв. 27 Тийм бөгөөд түүний төрөх үед түүний умайн дотор ихэр хүүхэд байлаа. 28 Тийм бөгөөд төрөхөд, нэгнийг нь гараа гаргахад, таалагч эм нь нэг улаан утас авч, түүний гаранд уяад; Энэ нь түрүүлэн гарав. 29 Харин түүнийг гараа гэдэргээ татсанд түүний дүү нь гарав. Тийм бөгөөд тэр нь; Чи яаж эвдэж гарав. Энэ эвдрэл нь гамтай болох болтугай! гэж өгүүлсэнд тэр нь Париж гэж нэрлэгдэв. 30 Бас гартаа улаан утастай дүү нь гарав. Тэр нь Жара гэж нэрлэгдэв.

Гучин есдүгээр бүлэг

1 Иосибийн Египетэд ирсэн Вораугийн бие хамгаалагч түшмэдийн ахлагч Путивор түүнийг авчирсан Ишмайлтны гараас худалдаж авав. Яагаад гэвэл, Египетийн хүн билээ. 2 Жахуа нь Иосибийн хамт байсан бөгөөд тэр бүтэмжит хүн болоод өөрийн эзэн болсон Египетчүүдийн гэрт байлаа. 3 Түүний эзэн нь Жахуаг түүнтэй байсан бөгөөд түүний хамаг үйлдлийг Жахуа бүтэмжтэй болгосныг үзэв. 4 Тийм учраас Иосиб түүний өмнө хайрыг олж, түүнд үйлчилдэг билээ. Бас тэр түүнийг өөрийн гарт өгөв. 5 Тэгээд түүний гэр болон байгаа бүхэндээ түүнийг сахигч болгон авсан цагаас эхлэн Жахуа нь Иосибийн төлөө Египетчүүдийн хүний гэрийг адистидлав. Бас түүнд гэртээ болон хээр байгаа бүхний дээр Жахуагийн адис байлаа. 6 Бас

тэр байгаа бүхнээ Иосибийн гарт байлган, өөрийн идэх идээнээ өөр байгаа бүхнээ эс мэддэг билээ. Иосиб нь сайхан биетэй болон сайхан царайтай билээ. 7 Энэ мэт болсны дараа түүний эзний хатан нь Ишиүгийг нүдээрээ ширтэж надтай хэвт гэж өгүүлэв. 8 Харин тэр нь эс зөвшөөрч өөрийн эзний хатандаа өгүүлрүүн; Миний эзэн нь надтай гэрийн дотор юу ахуйг эс мэднэ. Хамаг байгаануудаа миний гар дээр өгөв. 9 Энэ гэрийн дотор надаас их үгүй бөгөөд чамаас бус надад харагдсан буй үгүй буй. Яагаад гэвэл, чи түүний гэргий буй. Тиймийн тул би яахин энэ нүглийг хийж бурхны тус хилэнцийг үйлдэж чадна. хэмээн өгүүлэв. 10 Тийн бөгөөд тэр нь өдөр бүр Иосиб өгүүлэвч тэр нь түүнтэй хэвтэх эсвээс түүнтэй байхаа эс зөвшөөрөв. 11 Тэгээд нэг өдөр Иосиб нь өөрийн үйлийг үйлдэхийн тул гэрт орсон бөгөөд гэрийн дотор гэрийн хүмүүсээс нэг ч үгүй байхад 12 тэр нь түүний хувцсаас барьж надтай хэвт хэмээн өгүүлсэнд тэр нь хувцсаа түүний гарт орхиод зайлж гарав. 13 Тийн бөгөөд тэр хатан нь түүний хувцасдаа орхиод зайлж гарсныг үзээд 14 өөрийн гэрийн хүмүүсийг дуудаж тэдэнд; Тэр нь энэ Еврей хүнийг биднийг элгэлэхийн тул бидэнд ирүүлэв хэмээн үзэгтүн!, хэмээвээс тэр нь надтай хэвтэхийн тул надад ирэв. Харин миний их дуу гарав. 15 Тэгээд тэр нь миний дуу гарч дуудсаныг сонсоод хувцасдаа надтай орхиод зайлж гадагш гарав. хэмээн өгүүлэв. 16 Тэр нь түүний эзний иртэл түүний хувцсыг ойроо тавиад 17 түүнд энэ мэт үгсээ өгүүлрүүн; Чиний бидэнд авчирсан Еврей боол нь намайг элгэлэхийн тул надад ирэв. 18 Харин миний их дуу гарч дуудахад тэр нь хувцсаа надад орхиод гадагш зайлав. хэмээн өгүүлэв. 19 Түүний эзэн нь чиний боол надад энэ мэтээр үйлдсэн хэмээн өөрийн гэргийгийн өгүүлсэн үгсийг сонсоод хилэгнэв. 20 Бас Иосибийн эзэн нь түүнийг аваад хааны хүлээлгэсэн ял таны байсан гяндны дотор суулгав. Тэнд тэр нь гяндны дотор байв. 21 Жахуа нь Иосибэй байсан бөгөөд түүнд хайрыг үзүүлэвч гяндны түшмэлийг өмнө хайрыг өгөв. 22 Тийнхүү гяндны түшмэл нь гяндны дотор агч хамаг хоригдогсдыг Иосибийн гарт өгөв. Бас юу ч тэнд үйлдвээс эл, тэр нь үйлддэг бөлгөө. 23 Тэр гяндны түшмэл нь түүний гарт байгаагаас юуг ч эс үзэв. Яагаад гэвэл, Жахуа нь түүнтэй байсан бөлгөө. Жахуа нь түүний үйлдсэнийг бүтээмжит болгов.

Дөчдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд энэ мэт болсны дараа Египетийн хааны аягыг баригч болон идээг бэлдэгч нь өөрийн эзэн Египетийн хаанд бурууг үйлдэв. 2 Тийнхүү Ворау нь өөрийн аяга баригчдын тэргүүлэгч болон идээг бэлтгэгчдийн тэргүүлэгч хоёрт ихэд хилэгнээд, 3 тэднийг биеийг сахигчдын тэргүүлэгчийн гэр болох хүлэгдсэн Иосибийн байсан гянданд өгөв. 4 Тийм бөгөөд биеийг сахигчдын тэргүүлэгч тэднийг Иосиб тушааж, өгсөнд тэр нь тэдэнд үйлчилж явав. Тэд ч хэдэн хэдэн цаг болтол гянданд байв. 5 Тийм бөгөөд гяндан дотор хүлэгдсэн Египетийн хааны аяга баригч болон идээг бэлтгэгч хоёр хоёулаа тайлбартай зүүдийг зүүдэлж, өөр өөрийн зүүдийг нэг шөнө зүүдлэв. 6 Тийм бөгөөд Иосиб нь тэдэнд өглөө ирж тэднийг хараад, тэдний гомдолтой байхыг үзэв. 7 Тийм бөгөөд тэр нь өөртэйгээ хамт гянданд байгч өөрийн эзний түшмэдээс асуув; Таны бие энэ өдөр яагаад гашуудалтай байна вэ? 8 гэсэнд тэд нь Бид зүүд зүүдэлсэн бөгөөд түүнийг

тайлагч нь үгүй байна гэж өгүүлсэнд Иосиб нь тэдэнд; Тайлбарууд нь бурхнаас гарах биш үү? Тэднийг надад өгүүлэн үйлд! 9 гэж өгүүлсэнд аяга баригчдын тэргүүлэгч нь өөрийн зүүдийг Иосиб өгүүлэв. Миний зүүдлэх нь; Миний өмнө нэг үзмийн иш буй бөгөөд 10 тэр үзмийн иш нь гурван салаатай болон хүлээтэй мэт болоод, цэцгүүдийг дээш гаргав. бас түүний мөчрүүд нь боловсорсон үзмийг гаргав. 11 Тийм байхад Вораугийн аяга нь миний гарт буй бөгөөд би үзмүүдийг аваад, Вораугийн аяганд шахаад, аягыг Вораугийн гарт өгөв гэж би зүүдлэв 12 гэсэнд Иосиб нь түүнд; Үүний тайлбар нь; Тэр гурван салаа нь гурван өдөр буй. 13 Үүнээс гурван өдрийн турш Ворау нь чиний заргуудыг шүүгээд, чамайг чиний оронд хариулах буй. Тийнхүү чи урьдын ёсоор Вораугийн аяга баригч байсан мэт түүний аягыг түүний гарт өгөх буй. 14 Тийм бөгөөд чамд сайн болоход чи намайг санаж, бас миний тухай Ворауд мэдүүлж, энэ гэрээс намайг гаргаж хайрла! 15 Яагаад гэвэл, би Еврей газраас хулгайгаар авагдаад, энд ч энэ гянданд оруулагдахын тулд юуг ч эс үйлдэв гэж өгүүлэв. 16 Тийм бөгөөд идээг баригчдын тэргүүлэгч нь түүнийг сайн тайлбарласныг үзээд, Иосиб; Миний зүүдэнд; Миний толгой дээр гурван цагаар сав буй бөгөөд 17 тэдгээр саван дотор Вораугийн бэлтгэсэн зүйл бүрийн идээ буй бөгөөд миний толгой дээрх савнаас шувууд тэднийг идсэнийг үзэв 18 гэж өгүүлсэнд Иосиб нь хариу; Үүний хариу тайлбар нь; Тэр гурван сав нь гурван өдөр буй. 19 Үүнээс гурван хоногийн турш Ворау чиний заргыг шүүгээд, чамайг модонд өлгүүлэх буй. Тийм бөгөөд шувууд нь чиний биеэс чиний махыг идэх буй гэж өгүүлэв. 20 Тийм бөгөөд гурав дахь өдрөө Вораугийн төрсөн өдөр болсонд тэр нь өөрийн хамаг боолуудад нэг найр үйлдээд, өөрийн боолуудын хооронд байгч аяга баригчдын тэргүүлэгчийн зарга болон идээг бэлтгэгчдийн тэргүүлэгчийн заргыг шүүгээд, 21 аяга баригчдын тэргүүлэгчийг Вораугийн гарт аяга өгөхийн тулд аяга барих оронд хариулав. 22 Иосибийн тайлбарласан мэт тэр нь идээ бэлтгэгчдийн тэргүүлэгчийг өлгүүлэв. 23 Тийм боловч аяга баригчдын тэргүүлэгч нь Иосиб эс санаж мартав.

Дөчин нэгдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд хоёр жилийн дараа Ворау нь зүүдлэхдээ голын дэргэд байв. 2 Тийм бөгөөд долоон үзэсгэлэнтэй болон тарган махтай үхэр нь голоос гараад, нэг нугад идээшлэв. 3 Бас тэдний дараа үзэмж үгүй болон туранхай махтай үхэр нь голоос гараад, өөр үхрүүдтэй голын хөвөөн дээр байв. 4 Тийм бөгөөд үзэмжгүй болон туранхай үхрүүд нь сайн үзэсгэлэнтэй болон тарган махтай долоон үхрийг идэв гэж үзээд сэрэв. 5 Тийм бөгөөд тэр нь унтаж, дахин зүүдлэхдээ; Ганц тарианы ишинд долоон том тариатай болон сайн толгой гарав. 6 Бас тэдний дараа долоон нарийн болон зүүний салхинд хатаагдсан толгой нь гарав. 7 Тийм байхад долоон нарийн толгой нь долоон том дүүрэн толгойг залгив гэж зүүдлээд, сэрснийхээ дараа үүнийг зүүд гэж мэдэв. 8 Тийм бөгөөд Ворау нь өглөөгүүр сэтгэлээр зовиноод, Египетийн хамаг зурхайчид болон хамаг мэргэдийг дуудаад, зүүдийг тэдэнд өгүүлэв. Тийм боловч түүнийг тайлбарлагч эс олдов. 9 Тийм бөгөөд аяга баригчдын тэргүүлэгч нь Ворауд; Би өөрийн бурууг энэ өдөр санав гэхэд 10 Ворау өөрийн боолд хилэгнээд, намайг болон идээ баригчдын тэргүүлэгчийг сахихын

тулд биеийг сахигчийн гэрт өгөв. 11 Би болон тэр нь нэг шөнө зүүд зүүдэлцгээгээд, өөр өөрийн тайлбарт зүүдийг зүүдлэв. 12 Тэнд нэг Еврей залуу нь биеийг сахигчийн боол бөгөөд бидний зүүдэнд түүнд өгүүлсэн нь; Тэр нь бидний зүүдийг тайлбарлан, хүн бүрийн зүүдийг ёсоор тайлбарлав. 13 Тийм байхад түүний бидэнд тайлбарласнаар болов. Тэр нь намайг миний оронд хариулж өлгөв гэж өгүүлэв. 14 Тийм бөгөөд Ворау нь Иосиб дуудаад, гяндангаас түргэн авчруулав. Тэр нь сахлаа аваад, өөр хувцас өмсөөд, Ворауд оров. 15 Тэгээд Ворау нь Иосиб; Би зүүд зүүдэлсэн бөгөөд үүнийг тайлбарлагч үгүй буй. Харин чиний тухай би сонсвол, чи зүүдийг сонсоод, тайлбарлаж, чадна гэж сонсов би 16 гэж өгүүлсэнд Иосиб нь Ворауд; Энэ нь надаас бус. Харин бурхан нь Ворауд амархан хариу зарлиг болох болтугай! 17 гэж өгүүлсэнд Ворау нь Иосиб; Би зүүдээр голын хөвөөн дээр байсан бөгөөд 18 долоон тарган махтай болон сайхан янзтай үхэр нь голоос гараад, нэг нугад идээшлэн байв. 19 Бас тэдний дараа долоон муухай болон маш үзэмжгүй туранхай махтай үхэр гарав. Би тийм мууг Египет газарт эс үзэв. 20 Тийн байхад тэр туранхай муу үхрүүд нь тэргүүн долоон тарган үхрийг идэв. 21 Залгисны дараа тэдний өмнө муу зангаар байсаар байсны тул идсэн нь эс мэдэгдэв гэж би зүүдлээд сэрэв. 22 Бас зүүдээр үзэхэд; Нэг тарианы ишинд долоон толгой ургав. Тэд нь том бөгөөд сайн билээ. 23 Бас тэдний дараа долоон хадайр болон нарийн ба зүүний салхинд хатаагдсан толгой гараад, 24 тэр долоон нэрийн толгой нь долоон сайн толгойг залгив гэж үзэв. Тийнхүү би зурхайч нарт үүнийг өгүүлэвч надад тайлбарлагч эс олдов. 25 гэж өгүүлсэнд Иүшиг нь Ворауд; ораугийн зүүд нь ганц буй. Бурхан нь юу үйлдэхээ Ворауд үзүүлэв. 26 Долоон сайн үхэр нь долоон жил буй. Бас долоон сайн тарианы толгой нь долоон жил билээ. Зүүд нь ганц буй. 27 Бас тэдний дараа гарсан долоон туранхай болон муу үхэр нь долоон жил буй. Бас долоон хоосон болон салхинд хатаагдсан тарианы толгой нь долоон зудан жил буй. 28 Миний Ворауд өгүүлснээр бурхан нь юу өгүүлэхээ Ворауд үзүүлнэ. 29 Үүнээс хойш бүхэл Египет газарт долоон их элбэг жил болох буй. 30 Зүгээр, тэдний дараа долоон зудан жил ирсэнд, Египет газарт урьд элбэг нь мартагдах бөгөөд зуданд газар нь тарагдах бий. 31 Бас тэр хойд зуд нь маш хүнд болох тул элбэг нь энэ оронд үл мэдэгдэх буй. 32 Бас тэр зүүдний хоёр давхарлагдсаны шалтгаан нь; Тэр бурхнаар тогтоогдсон бөгөөд бурхан нь түүнийг удалгүй үйлдэх буй. 33 Тийм учраас Ворау нь нэг мэргэн болон ухаант хүнийг олоод, Египет газрын дээр тавьтугай! 34 Бас Ворау нь газрын таван хувийг авах болтугай! 35 Тэд ч энэ ирэхгүй сайн жилийн идээг хурааж, Вораугийн эрхээр талхыг хадгалаад, балгадын идээ болох тул сахих болтугай! 36 Тэр зудаар газрын үл эвдрэхийн тул тэр идээ нь Египет газарт ирэхгүй зудын долоон жилийн тул хадгалагдах болтугай! гэж өгүүлэв. 37 Тийм бөгөөд тэр нь уг Вроэүд болон түүний хамаг боолуудад зохистой билээ. 38 Бас Ворау нь боолууддаа өгүүлэв; Бид үүнтэй адил хүнийг олох уу? Түүний дотор бурхны тодотгол буй 39 гэж өгүүлээд, Ворау нь Иосиб өгүүлэв; Бурхны чамд энэ бүхнийг мэдүүлсний дараа чамтай адил мэргэн болон ухаантай хүн үгүй. 40 Чи миний гэрийн дээр болох бөгөөд чиний үгээр миний улс бүгдээр эзлэгдэнэ. Би ганц ширээгээр чамаас их болно гэж өгүүлэв. 41 Бас Ворау нь Иосиб өгүүлэв; Би

чамайг бүхэл Египет газрын дээр тавина 42 гэж өгүүлээд, өөрийн гараас бэлзгээ бөгжөө аваад, Иосибийн гарт зүүлгэн нарийн бүс хувцсыг өмсгөөд, нэг алтан оосрыг хүзүүнд зүүлгэв. 43 Бас тэр нь өөрийн хоёр дахь үзэсгэлэнт тэргэндээ явуулж, Түүнийг мөргө! гэж дуудуулав. Энэ мэтээр түүнийг бүхэл Египет газрын дээр тавив. 44 Бас Ворау нь Иосиб өгүүлэв; Би Ворау мөн. Зүгээр, чамгүйгээр бүхэл Египет газарт хэн ч гар буюу хөлөө үл өргөх буй. 45 Бас Ворау нь Иосибийг Саунад Па Аниаа гэж нэрлээд, Оны Бутивура Ламагийн охин Ашипадыг түүнд гэргий болгон өгөв. Тийнхүү Иосиб нь Египет газарт нааш цааш зорчив. 46 Иосиб нь Египетийн хаан Вораугийн өмнө байсан цагт гучин настай байсан бөгөөд Вораугийн өмнөөс гараад, бүхэл Египетийг газрыг алсдав. 47 Тийм бөгөөд долоон элбэг жилээр газар нь атга атгаар ургуулав. 48 Тэр долоон жилийн турш Египетэд байгч хамаг идээг хурааж, балгадын дотор хадгалагдав. Үүнд; аливаа балгасдын тойронд байгч хээрийн идээг тэрхүү балгасад элс мэт маш их талхыг хураагаад, тоолшгүй байсан тул тоолохоо болив. 50 Тийм бөгөөд зудан жилүүдийн болохоос урьд Иосиб хоёр хөвгүүд нь төрөгдөв. Оны Путивура Ламагийн охин Ашипад нь түүнд төрүүлэв. 51 Иосибийн өөрийн том хөвгүүнийг Манасси гэж нэрлэв. Яагаад гэвэл, бурхан нь манай зовлон болон миний эцгийн гэрийг умартуулав. мартуулав гэж өгүүлсний төлөө билээ. 52 Хоёр дахь хөвгүүнийг Ивурайм гэж нэрлэв. Яагаад гэвэл, бурхан нь миний зовлонгийн газарт намайг үрстэй болгов гэж өгүүлсний төлөө билээ. 53 Тийм бөгөөд долоон элбэг жилийн Египет газарт дуусгасанд Иосибийн өгүүлсэн мэт долоон зудан жил эхэлж ирэв. 54 Тийнхүү хамаг гацаадад зуд байсан боловч бүхэл Египет газарт тариа буй билээ. 55 Тийм бөгөөд бүхэл Египет газрын улсын өмсөж, Ворауд талхны төлөө дуудахад Ворау нь Египетийн улс бүгдээрт өгүүлэв; Та Иосиб очигтун! Түний танд юу өгүүлэх мэт түнчлэн үйлдэгтүн! гэж өгүүлэв. 56 Тийн зуд нь бүхэл газар дээр болсонд Иосиб нь хамаг хадгалах гэрүүдийг нээгээд, Египетийн улсад худалдав. Бас зуд нь бүхэлт Египет газарт хүчтэй болов. 57 Хамаг газруудад зуд нь хүчтэй байх тул аливаа газраас идээг худалдаж авахын тулд Египет Иосиб ирлээ.

Дөчин хоёрдугаар бүлэг

1 Тийнхүү Яахоб нь Египетэд талх буй гэж мэдээд, өөрийн хөвгүүдэд өгүүлэв; Та нар өөр өөрөө юуны тул харалцана вэ? 2 Бас өгүүлэв; Миний сонсвол, Египетэд талх буй. Тийм учраас бидний амьд байж, үл үхэхийн тул та нар тэнд очоод, тэндээс бидэнд талх худалдаж авагтун! гэж өгүүлэв. 3 Тийм бөгөөд Иосибийн арван ах нар нь Египетээс талхыг худалдаж авахын тулд тэнд очив. 4 Зүгээр, Яахоб нь Иосибийн дүү Бинзаминий түүний ах нартай эс илгээв. Яагаад гэвэл, Түүнтэй зовлон нь учрах болжээ гэж өгүүлэв. 5 Тийм бөгөөд талхыг худалдаж, авахын тулд ирэгчдийн дунд Израйлийн хөвгүүд ч ирэлцэв. Яагаад гэвэл, зуд нь Ханаван газарт билээ. 6 Иосиб нь газрын дээр тэргүүлэгч болоод, газрын улс бүгдээрт худалддаг билээ. Тийн байхад Иосибийн ах нар нь ирээд, Иосиб нүүрээрээ хөсөр мөргөв. 7 Иосиб нь ах нараа үзээд, танивч эс таньсан мэт болж, хатуу үгсээр тэдэнд өгүүлэв; Та нар хаанаас ирэв? гэж өгүүлсэнд тэд нь; Идээг худалдаж авахын тулд Ханаван газраас ирэв бид гэж өгүүлэв. 8 Иосиб нь өөрийн

ах нарыг танивч тэд нь түүнийг эс танив. 9 Тийнхүү Иосиб нь тэдний тухай өөрийн зүүдэлсэн зүүдийг санаад, тэдэнд өгүүлэв; Та нар туршуулууд буй бөгөөд газрын өлсгөлөн үзэхийн тулд ирэв 10 гэж өгүүлсэнд тэд нь өгүүлэв; Бидний ноён оо! Тийм бус. Чиний боолууд нь талхыг худалдаж авахын тулд ирэв. 11 Бид нар ганц хүний хөвгүүд болон үнэн улс буй. Чиний боолууд нь туршуулууд бус буй. 12 гэж өгүүлсэнд тэд нь өгүүлэв; Тийм бус. Харин та нарын газрын өлсгөлөнг үзэхийн тулд ирэв 13 гэж өгүүлсэнд, тэд нь өгүүлэв; Чиний боолууд нь арван хоёр ах дүү нар буй бөгөөд Ханаван газарт байгч ганц хүний хөвгүүд буй. Бас отгон хөвгүүн нь бидний эцэгтэй буй бөгөөд нэг нь үгүй болов 14 гэж өгүүлсэнд Иосиб нь тэдэнд өгүүлэв; Тэр нь миний танд өгүүлсэн гэвэл, Та нар туршуулууд буй 15 Та үүгээр шинжлэгдэх гэвэл, Танай отгон дүү нь энд үл ирвэл, та нар эндээс үл гарна гэж би Вораугийн амиар тангараглана. 16 Та нар өөрөөсөө нэгийг илгээж, дүүгээ ирүүлэгтүн! Таны үгсийг шинжлэхийн тулд болон танд үнэн буй юу?, үгүй юу? гэж мэдэхийн тулд та гянданд сахигдах буй. Эсвэл, Вораугийн амиар та туршуулууд буй 17 гэж өгүүлсэнд тэднийг гурван өдөр сахихын тулд өгөв. 18 Тийм бөгөөд гурав дахь өдрөө Иосиб тэдэнд өгүүлэв. Та амьд байхын тулд үүнийг үйлдэгтүн! Би бурхнаас айна. 19 Хэрэв та нар үнэн хүмүүс мөн бол танай ах дүү нараас нэг нь таны байсан гяндангийн дотор хүлээгдсээр байтугай! Та явж, өөрийн гэр дэх хүмүүсийн өлсгөлөнгүүдийн тул талхыг аваачигтун! 20 Зүгээр, таны очоод, дүүг надад авчрагтун! Үүгээр таны үгс нь шинжлэгдэх бөгөөд та үл үхнэ гэж өгүүлсэнд тэд нь түүнчлэн үйлдэв. 21 Тийм бөгөөд тэд нь өвөр зуураа хэлэлцэв. Бид өөрийн дүүгийн тухай үнэхээр буруутай билээ. Түүний биднийг гуйхад бид түүний сэтгэлийн гасланг үзэвч, эс сонсов. Тийм учраас энэ зовлон нь бидний дээр ирэв 22 гэж хэлэлцсэнд Рүбин нь тэдэнд хариу өгүүлэв. Хөвгүүний тус хилэнцийг бүү үйлдэгтүн! гэж би өгүүлсэн боловч та эс сонсов. Тийм учраас одоо үүний цус нь нээгдэнэ 23 гэж өгүүлэлдэн байхдаа тэд нь Иосибийн байхыг эс мэдэв. Яагаад гэвэл, тэр нь тэдэнтэй хэлмэрчээр хэлэлцэв. 24 Харин тэр нь тэндээс гараад уйлав. Бас тэдэнд буцаад, тэдэнтэй хэлэлцээд, тэднээс Симионыг аваад, тэдний өмнө хүлэв. 25 Тийм бөгөөд Иосиб нь захив; Тэдний савуудыг талхаар дүүргэж, хүн бүрийн мөнгийг савын дотор оруулж, замын хүнсийг тэдэнд өгөгтүн! гэж захиад тэдэнд түүнчлэн үйлдэв. 26 Тийм бөгөөд тэд нь илжгэндээ талхыг ачаад явав. 27 Тийм бөгөөд нэг үдлэгч гэрт хүрээд, тэдний нэг нь илжгээ идүүлэхийн тулд саваа тайлан савны амсарт өөрийн мөнгө байхыг үзэв. 28 Тийм байхад тэр нь ах дүү нартаа өгүүлэв; Миний мөнгө нь буцаагаад, миний сав нь дотор байна гэж өгүүлсэнд тэдний зүрх нь цочив. Бас тэд нь айгаад, өөр зуураа өгүүлэлцэв; Бурхны бидэнд үйлдсэн нь юу вэ? гэж өгүүлэлцэв. 29 Тийм бөгөөд тэд нь Ханаван газарт өөрийн эцэг Яахобт ирээд; Биедээ тохиолдсон цөмийг түүнд мэдүүлж, өгүүлэв; 30 Тэр Египетийн ноён болсон хүн нь бидэнтэй ширүүн үгсээр хэлэлцэж, биднийг газрын туршуулууд буй гэж санав. 31 Зүгээр, бид өгүүлэв; Бид үнэн улсууд буй. Бид туршуулууд бус. Бид өөрийн эцгийн арван хоёр хөвгүүн буй. 32 Нэг нь үгүй бөгөөд отгон нь өөрийн эцэгтэй Ханаван газарт буй 33 гэж өгүүлсэнд тэр газрын ноён хүн нь бидэнд өгүүлэв; Та үнэн улс мөн гэж би үүгээр мэднэ гэвэл, ах дүү нартаа нэгийг надтай орхин, өөрийн гэр дэх хүмүүсийн өлсгөлөнгийн

тухай талхыг аваад явагтун! 34 Бас бага дүүгээ надад авчрагтун! Тийм бол би таныг туршуулууд бус. Харин үнэн улс мөн гэж мэднэ. Бас би таны орхисон ахыг танд өгөх бөгөөд та энэ газарт худалдаа хийх буй гэж өгүүлэв гэлээ. 35 Тийм бөгөөд тэднийг савуудаа хоосруулахад хүн бүрийн мөнгөний баглаа нь савны дотор байлаа. Тэд болон тэдний эцэг нь энэ мөнгөний баглааг үзээд айлцав. 36 Тийм бөгөөд тэдний Яахоб нь эцэг нь тэдэнд өгүүлэв; Та намайг хөвгүүдгүй болсон буй. Иосибийн болон Симионгүй болов. Бас та Бинзаминыг авах уу? Энэ бүгдээр миний тус буй 37 гэж өгүүлсэнд Рүбин эцэгтээ өгүүлэв; Би чамд түүнийг үл авчирвал, миний хоёр хөвгүүнийг алан үйлд! Миний гарт түүнийг өг! Би түүнийг чамд буцаах буй 38 гэж өгүүлсэнд тэр нь өгүүлэв; Миний хөвгүүн нь тантай үл явна. Түүний ах нөгчсөн бөгөөд тэр ганцаар үлдэв. Хэрэв таны явах харгуйгаар зовлон нь түүнтэй тохиолдвол та миний буурал үсийг хүүрийн булшинд гаслангаар буулгах буй гэж өгүүлэв.

Дөчин гуравдугаар бүлэг

1 Тийм бөгөөд өлсгөлөн нь тэр газарт хүнд буй билээ. 2 Тийм байхад тэдний Египетээс авчирсан талхаа идэж, дууссаны дараа тэдний эцэг нь тэдэнд өгүүлэв; Та дахин очоод, нэг багахан талхыг худалдаж авагтун! 3 гэж өгүүлсэнд Иудей нь түүнд өгүүлэв; Тэр хүн нь бидэнд бат үгээр ийн; Хэрэв таны дүү нь тантай үл ирвэл та миний нүүрийг үл үзэх буй гэж өгүүлэв. 4 Хэрэв чи бидний дүүг бидэнтэй илгээвэл, бид чамд талхыг худалдаж, авахын тул явах буй. 5 Зүгээр, хэрэв чи түүнийг үл илгээвэл, бид үл явах билээ. Яагаад гэвэл, тэр хүн нь ийн өгүүлэв; Хэрэв таны дүү нь тантай үл ирвэл, та миний нүүрийг үл үзэх буй 6 гэж өгүүлсэнд Израйль нь өгүүлэв; Та тэр хүнд нэг дүү буй гэж мэдүүлж, зовлонг надад юуны тулд хүргэв 7 гэж өгүүлсэнд тэд нь өгүүлэв; Тэр хүн нь бидний тухай болон бидний төрлийн тухай нэвтэрхий асуув. Таны эцэг амьд уу? Танд өөр ах дүү бий юу? гэж асуусанд бид энэ үгсийн ёсоор түүнд өгүүлэв. Харин таны дүүг авчрагтун гэж түүний өгүүлэхийг бид мэдсэн үү? гэж өгүүлэв. 8 Бас Иудей нь өөрийн Израйль эцэгтээ өгүүлэв; Тэр хөвгүүнийг надтай илгээн үйлд! Тийм бол бид босоод явах буй. Яагаад гэвэл, бид болон чи ба бидний бяцхан хүүхдийн үл үхэж, амьд байхын тулд билээ. 9 Би түүний төлөө гар даагч болох бөгөөд чи миний гараас түүнийг эрэн үйлд! Хэрэв би түүнийг авчран, чиний өмнө үл тавибал, би чамд хэзээ ч буруутай болох буй. 10 Хэрэв бид эс удвал одоо бид хоёр дахин буцан ирэх билээ 11 гэж өгүүлсэнд тэдний Израйл эцэг нь тэдэнд өгүүлэв; Тийм бол энэ мэтийг үйлдэгтүн! гэвэл, газрын үлэмж сайн үрсээс савнууд дотроо аваад нэг хэдий Балсам болон нэг хэдий бал ба сайхан үнэртэн болон Мийр ба Самур болон шиднүүдийг тэр хүнд бэлгээр баригтун! 12 Бас гартаа хоёр давхар мөнгийг ав. Савны амсар дотор буцаагдсан мөнгийг аваад гартаа аваачигтун! Тэр нь буруу болжээ. 13 Бас дүүгээ аваад босож, тэр хүнд дахин явагтун! Тийн байхад тэр хүний таны үлдсэн ах болон Бинзаминийг буцааж, тавихын тул түүний өмнө аугаа хүчтэй бурхан нь танд хайрыг үзүүлэх болтугай! 14 Хэрэв би хүүхдээ гээвэл, тэднийг гээх буй гэж өгүүлэв. 15 Тийм бөгөөд тэр хүмүүс нь тэр бэлэг болон гартаа хоёр давхар мөнгө ба Бинзамин дүүгээ аваад босож, Египетэд очоод Иосибийн

өмнө байв. 16 Иосиб нь тэдэнтэй байгч Бинзаминыг үзээд, өөрийн гэрийн тэргүүлэгчид өгүүлэв; Тэр хүмүүсийг гэрт оруулж, малыг алаад, идээг бэлтгэж үйлд! Яагаад гэвэл, тэр хүмүүс нь надтай хагас өдөр идээлэх буй 17 гэж өгүүлсэнд тэр хүн нь Иосибийн өгүүлснээр үйлдээд, тэднийг Иосибийн гэрт оруулав. 18 Тийм бөгөөд тэр хүмүүс нь Иосибийн гэрт оруулагдсан учраас айгаад өгүүлэв; Урьд бидний саванд буцаагдсан мөнгөний тухай бид оруулагдсан буй. Яагаад гэвэл, тэр нь биднийг буруутай болгож, биднийг хашиж, биднийг болон бидний илжгүүдийг боолууд болгон авах буй 19 гэж өгүүлэлцээд, Иосибийн гэрийн тэргүүлэгчид шадардаад гэрийн үүдний өмнө түүнд өгүүлэв; 20 Миний ноён оо! Бид анхандаа идээг худалдаж авахын тулд ирэв. 21 Тийм бөгөөд биднийг үдлэх гэрт хүрээд савнуудаа тайлсанд хүн бүрийн мөнгө нь савны амсрын дотор буй билээ. Бид мөнгийг жигнээд гартаа буцааж авчрав. 22 Бас идээг худалдаж авахын тулд бид өөр мөнгийг гартаа авчрав. Бид мөнгийг саванд хэн хийснийг эс мэдэв 23 гэж өгүүлсэнд тэр нь өгүүлэв; Та амраар байж, бүү айгтун! Таны бурхан болон таны эцгийн бурхан нь таны савнуудад энэ нууц санг өгөв. 24 Тийм бөгөөд тэр хүн нь тэднийг Иосибийн гэрт оруулаад, хөлийг угаахын тулд усыг өгөөд тэдний илжгүүдийг идээлүүлэв. 25 Тэд нь тэнд идээг идүүлэхээ сонссон тул Иосибийн хагас өдөр иртэл бэлгийг түүнд гэрийн дотор бэлтгэж үйлдэв. 26 Тийм бөгөөд Иосибийн гэртээ ирэхэд тэд нь гартаа байгч бэлгийг түүнд гэрийн дотор авчираад хөсөр мөргөв. 27 Тэр нь тэдэнд өгүүлэв; Та амар байна уу? Таны өгүүлсэн хөгшин эцэг нь амар байна уу?, Тэр одоо болтол амьд байна уу 28 гэж асуусанд тэд нь өгүүлэв; Чиний боол манай эцэг амар буй бөгөөд тэр нь бас амьд буй гэж өгүүлээд, толгойгоо бөхийлгөж, хөсөр мөргөв. 29 Тийм бөгөөд Иосиб нь нүдээрээ ширтэж, өөрийн эхийн хөвгүүд болон Бинзамин дүүгээ үзээд өгүүлэв; Таны надад өгүүлсэн дүү нь энэ үү? гэж өгүүлээд, Миний хөвгүүнээ бурхан нь чамайг өршөөтүгэй! 30 гэж өгүүлээд дүүдээ сэтгэлээр их өршөөнгүйтэй болоод нэг уйлах газрыг хайж, нэг тасалгаа ороод тэнд уйлав. 31 Тийм бөгөөд тэр нь нүүрээ угаагаад гарав. Тэнд тэр нь сэтгэлээ тайвшруулан Идээс тавигтун! гэж өгүүлэв. 32 Тийм байхад түүнд тусгаар болон тэдэнд тусгаар ба түүнтэй идээлэлцэгч Ихипэтэнд тусгаар идээг тавив. Яагаад гэвэл, Ихипэтэн нь Еврейтэй идээлж эс зохив. Тэр нь Ихипэтэнд жигшүүртэй билээ. 33 Тэд нь түүний өмнө суухдаа ах нь өөрийн насны ёсоор суусан бөгөөд дүү нь өөрийн насны ёсоор суусан буй. Үүнд тэд нь гайхалцав. 34 Бас тэр нь өөрийн өмнөөс идээний хувийг авч тэдэнд илгээв. Зүгээр, Бинзамины хувь нь тэдний хувиас таван давхрын төдий их билээ. Бас тэд нь түүнтэй уулзаж, баясалцав.

Дөчин дөрөвдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд тэр нь өөрийн гэрийн тэргүүлэгчид захиж, өгүүлэв; Тэдгээр хүмүүсийн савуудыг хэдий чинээ өргөж чадах зэргийн идээгээр дүүргээд мөнгийг савны амсарт оруулан 2 миний цагаан мөнгөн аягыг отгон хөвгүүний савны амсарт оруулан, түүний талхны мөнгийг ч оруулан үйлд! гэж өгүүлсэнд тэр нь Иосибийн өгүүлсэн үгээр үйлдэв. 3 Тийм бөгөөд түүний маргааш үүр цайхад, тэр хүмүүс нь илжигтэйгээр тавигдав. 4 Харин тэдний хотоос гарч, хол бус одсонд Иосиб нь

өөрийн гэрийн тэргүүлэгчид өгүүлэв; Чи босоод, тэр хүмүүсийг нэхэж, гүйцэхэд ийн; Та сайны төлөө мууг юуны тулд хариулав? 5 Энэ нь миний ноёны уух аяга биш үү? Та түүнийг ихэд үл нэхнэ гэж санав уу? Таны үйлдсэн нь муу буй гэж өгүүл 6 гэж өгүүлснээр түүнийг тэднийг гүйцээд эдгээр үгсээр өгүүлсэнд тэд нь түүнд өгүүлэв; 7 Миний ноён нь ийм үгсийг юуны тулд өгүүлнэ вэ? Чиний боолууд нь энэ мэтээр бүү үйлдэх болтугай! 8 Бидний савны амсарт олсон мөнгийг бид Ханаван газраас чамд буцаагаад, чиний ноёны гэрээс мөнгө эсвэл алтыг яаж хулгайлж, авах вэ? 9 Чиний боолуудаас хэнээс тэр нь олдвол тэр нь үхэх бөгөөд бид өөрийн ноёны боолууд болох болтугай! 10 гэж өгүүлсэнд тэр нь өгүүлэв; Үнэхээр үгсээр болох болтугай! Хэнээс тэр олдвол тэр нь миний боол болох буй. Тийнхүү та буруугүй болох билээ 11 гэж өгүүлсэнд тэдний хүн бүр нь өөрийн савыг газарт буулгаад, хүн бүр өөрийн савыг тайлав. 12 Тийм бөгөөд тэр нь ахаас эхлээд отгонд дуусган, аягыг Бинзаминий савны дотроос олов. 13 Тийн байхад тэд нь хувцсаа цуучин өөр өөрийн илжгийг ачаад, хотод харив. 14 Бас Иудей болон түүний ах дүү нарын Иосибийн гэрт дахин одсонд тэр нь тэнд буй билээ. 15 Тийнхүү тэд нь түүний өмнө хөсөр унахад Иосиб нь тэдэнд өгүүлэв; Таны үйлдсэн нь юу вэ? Та миний зэргийн хүнийг ихэд нэхнэ гэж эс мэдэв үү? 16 гэж өгүүлсэнд Иудей нь өгүүлэв; Бид миний ноёнд юуг өгүүлэх вэ? уг хэлэх вэ? Өөрөө зөвтэй яаж болох вэ? Бурхан нь чиний боолуудын нүглийг олсон буй. Тийнхүү бид болон биедээ аягыг олуулсан нь миний ноёны боолууд билээ 17 гэж өгүүлсэнд тэр нь өгүүлэв; Тийм бус билээ. Биедээ аягыг олуулсан хүн нь миний боол болно. Харин та эцэгтээ амраар харигтун! 18 гэж өгүүлсэнд Иудей түүнд сандраад, өгүүлэв; Миний ноён оо! Чиний боол нь өөрийн ноёны чихэнд нэг үгийг өгүүлбэл, чи өөрийн боолын тус бүү хилэгнэ! Чи Вораутэй адил билээ. 19 Миний ноён оо! Танд эцэг бий юу? Дүү бий юу? 20 гэж өөрийн боолуудаас асуусанд бид миний ноёнд өгүүлэв; Бидэнд эцэг буй бөгөөд тэр нь хөгширсөн буй. Бас түүний хөгширсөн үед төрөгдсөн отгон хөвгүүн буй. Түүний ах үгүй бөгөөд түүний эхээсээ ганцаар үлдсэн тул түүний эцэг нь түүнийг энхрийлнэ 21 гэж бидний өгүүлсэнд чи өөрийн боолуудад ийн өгүүлэв; Миний түүнийг үзэхийн тулд түүнийг авчрагтун! 22 гэж өгүүлсэнд бид миний ноёнд өгүүлэв; Тэр хөвгүүн нь эцгээ орхиж, үл чадна. Хэрэв эцгээ орхивол тэр нь үхэх билээ 23 гэж өгүүлсэнд чи өөрийн боолуудад өгүүлэв; Хэрэв таны дүү нь тантай үл ирвэл, та миний нүүрийг үл үзэх билээ. 24 Тийм бөгөөд бид чиний боол гэвэл, бидний эцэгт ирээд, миний ноёны үгсийг өгүүлэв. 25 Бас бидний эцэг нь өгүүлэв; Та дахин очоод бидний төлөө багахан талхыг худалдаж авагтун! 26 гэж өгүүлсэнд бид өгүүлэв; Бид явж үл чадна. Хэрэв бидний дүү нь бидэнтэй очвол, бид явах буй. Хэрэв бидний дүү нь үл явбал бид нар хүнийг үзэж үл чадна 27 гэж өгүүлсэнд чиний боол миний эцэг нь өгүүлэв; Миний гэргий нь надад хоёрыг төрүүлснийг та мэднэ. 28 Нэг нь надаас явсанд би түүнийг алагдсан гэж өгүүлээд, одоо болтол эс учрав. 29 Таны үүнийг миний өмнөөс авсанд хэрэг зовлон нь түүнтэй учралдвал, та миний буурал үсийг гаслангаар хүүрийн булшинд буулгах болно гэж өгүүлэв. 30 Тийм бөгөөд миний эцэгтээ ирэхэд тэр хөвгүүн нь бидэнтэй үл байвал, түүний амь нь энэ хөвгүүний амьтай нийлэгдсэн тул 31 тэр нь хөвгүүнгүй гэж үзээд, үхэх буй. Тийнхүү чиний боолууд нь

өөрийн эцгийн буурал үсийг гаслангаар хүүрийн булшинд буулгах буй. 32 Бас чиний боол нь тэр хөвгүүний төлөө өөрийн эцэгт гар дагагч болоод ийн өгүүлэв; Хэрэв би түүнийг үл авчирвал би чиний өмнө хэзээ ч буруутай болох буй. 33 Тийм учраас чиний боол нь тэр хөвгүүний оронд миний ноёнд боол болж, байх бөгөөд тэр хөвгүүн нь өөрийн ах нартай буцах болтугай! гэж гуйна. 34 Яагаад гэвэл, тэр хөвгүүн надтай үл байвал, би өөрийн эцэгт яаж очих вэ? Би эцэгтэй учралдах зовлонг үл үзэх болтугай! гэж өгүүлэв.

Дөчин тавдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Иосиб нь өөртэйгээ байгчдын өмнө сэтгэлээ тайвшруулж ядаад ийн дуудав; Хүн бүгдийг миний өмнөөс гаргагтун! гэж өгүүлсэнд Иосибийн ах дүү нартаа биеэ таниулахад нэг ч хүн эс байв. 2 Тийн байхад Иосибийн уйлж чанга дуу гарахыг Египеттэн болон Вораугийн гэрийн улс нь сонсов. 3 Иосиб нь өөрийн ах дүү нарт өгүүлэв; Би Иосиб буй. Миний эцэг одоо болтол амьд байна уу? гэж өгүүлсэнд түүний ах нар нь түүнд хариу өгүүлж эс чадав. Яагаад гэвэл, тэд нь түүнээс ихэд цочив. 4 Бас Иосиб өгүүлэв; Та ойртогтун! гэж өгүүлсэнд тэд нь ойртов. Бас тэр нь өгүүлэв; Би таны Египетэд худалдагдсан Иосиб дүү буй. 5 Тийм боловч та намайг нааш худалдсаны учир үл гомдож, өөрийн тус бүү хилэгнэгтүн! Яагаад гэвэл, бурхан нь амийг гамнахын тулд намайг таны өмнө нааш илгээв. 6 Хоёр жилд энэ зуд нь газрын дотор байсан бөгөөд өөр таван жил үлдэв. Тэдний туршаар хагалах болон хадах нь үл болох буй. 7 Харин бурхан нь таны үрсийг дэлхий дээр сахих бөгөөд их авралаар таны амийг аврахын тулд таны өмнө намайг илгээв. 8 Тийм учраас та намайг илгээсэн бус. Харин бурхан нь намайг илгээж, намайг Ворауд эцэг болгон түүний гэрийн дээр эзэн болгон Египет газрын дээр тэргүүлэгч болгон тавив. 9 Тийнхүү та яарч очоод, миний эцэгт ийн өгүүлэгтүн! Чиний Иосиб хөвгүүний өгүүлсэн нь ийн; Бурхан нь намайг бүхэл Египетийн дээр тэргүүлэгч болгон тавив. Чи одоо удалгүй надад иртүгэй! 10 Чи Косин газар нутаглаж, миний ойр болох бөгөөд чи болон чиний хөвгүүд ба чиний ач нар болон чиний хоньд ба чиний үхрүүд болон чамд байгаа бүхэн нь надад ойр болох буй. 11 Бас чи болон чиний гэрийн улс ба чамд юу байгаа бүгдийг үл үхүүлэхийн тулд би чамайг тэнд тэжээнэ. Яагаад гэвэл, Жич; Таван жил зуд болох буй гэж өгүүлэгтүн! 12 Бас таны нүд болон миний дүү Бинзамины нүд нь миний амны танд өгүүлснийг үзнэ. 13 Жич, та миний алдар болон цөм үзсэний тухай миний эцэгт өгүүлэн яарч миний эцгийг нааш ирүүлэгтүн! 14 гэж өгүүлээд тэр өөрийн дүү Бинзаминыг хүзүүгээр нь тэврэн уйлав. Бинзамин ч түүний хүзүүн дээр уйлав. 15 Түүнчлэн тэр нь ах бүгдийг үнсэж, тэдний дээр уйлав. Дараа нь түүний ах нар нь түүнтэй хэлэлцэв. 16 Тийм бөгөөд Иосибийн ах дүү нар нь ирэв гэж Вораугийн гэрт сонсогдоод, Ворауд болон түүний улсад тааламжтай болов. 17 Тийм бөгөөд Ворау нь Иосиб өгүүлэв; Та үүнийг үйлдэнэ гэвэл, илжигнүүдээ ачаад, Ханаван газарт очигтун! 18 Бас өөрийн эцэг болон гэрийн улсыг аваад, надад ирэгтүн! Би танд Египет газрын сайн буйнуудыг өгөх бөгөөд та газрын элбэгээс идэх буй. 19 Одоо миний захиснаар та өөрийн гэргийд болон хүүхдийн төлөө Египет газраас тэргүүдийг аваад, өөрийн эцгийг авч ирэгтүн! 20 Бас эд

агуурсаа бүү хайрлагтун! Яагаад гэвэл, Египет газрын аливаа сайн нь таных болох буй гэж өгүүл! 21 гэсэнд Израйлийн хөвгүүд нь түүнчлэн үйлдэв. Бас Иосиб нь Вораугийн захиснаар тэргүүд болон замын хүнсийг тэдэнд өгөв. 22 Жич, тэр нь тэдний хүн бүрт шинэ хувцсыг өгөөд, Бинзаминд мөнгөний гурван зуун жингийн төдий болон таван шинэ хувцсыг өгөв. 23 Бас тэр нь энэ мэтээр өөрийн эцэгт Египетийн сайн буйаар ачигдсан арван азарга илжиг болон замын тулд талх ба идээ хүнсээр ачигдсан арван гүү илжгийг илгээв. 24 Тийнхүү тэр нь өөрийн ах нарыг хариулж, тэднийг явахад тэдэнд ийн; Та замаар бүү хэрэлдэгтүн! гэж өгүүлэв. 25 Тийм бөгөөд тэд нь Египетээс гараад, Ханаван газарт өөрийн эцэг Яахобт хүрээд, түүнд мэдүүлж, өгүүлэв; Иосиб нь одоо болтол амьд буй бөгөөд бүхэл Египет газар дээр тэргүүлэгч буй билээ гэж өгүүлсэнд түүний зүрх нь түгшив. Тэр нь тэдэнд эс итгэв. 26 Харин тэд нь Иосибийн тэдэнд өгүүлсэн хамаг үгсийг түүнд мэдүүлэв. 27 Бас тэдний эцэг нь биеэ аваачихын тулд Иосибийн илгээсэн тэргүүдийг үзээд, сэтгэлээр амархан болов. 28 Тийнхүү Израйль нь өгүүлэв; Миний хөвгүүн Иосиб нь одоо болтол амьд байгаа тул би ханав. Би үхэхээс өмнө түүнийг үзэхээр явна гэж өгүүлэв.

Дөчин зургаадугаар бүлэг

1 Тийм бөгөөд Израйль нь хамаг байснаа дагуулан, нүүж Биршибад хүрээд, өөрийн эцэг Ишагийн бурханд тахилуудыг өргөв. 2 Тэнд бурхан нь шөнийн үзэгдэлээр Израйльд зарлиг болруун; Яахоб оо! Яахоб оо! гэж зарлиг болсонд тэр нь; Би энд байна гэж айлтгав. 3 Бурхан нь зарлиг болруун; Би бурхан мөн бөгөөд чиний эцгийн бурхан буй. Чи Египетэд очихоос бүү айгтун! Яагаад гэвэл, би чамаас нэг улсыг тэнд болгоно. 4 Би чамтай Египетэд буун, чамайг тэндээс гаргах буй. Бас Иосиб нь гараа чиний нүдэн дээр тавих буй гэж зарлиг болов. 5 Тийм бөгөөд Яахоб нь Биршибагаас босоод гарав. Бас Израйлийн хөвгүүд нь өөрийн эцэг Яахоб болон хүүхэд ба гэргийдийг аваачихын тулд Вораугийн илгээсэн тэргүүдээр аваачив. 6 Бас тэд нь мал болон Ханаван газарт олзолсон эд агуурсаа авав. Тийнхүү Яахоб болон түүнтэй түүний үрс нь Египетэд ирэв. 7 Тэр нь өөрийн хөвгүүд болон хөвгүүдийн хөвгүүд ба өөрийн охид болон хөвгүүдийн охид ба хамаг үрсийг Египетэд авчрав. 8 Израйлийн Египетэд ирсэн хөвгүүдийн нэрс нь; Яахобын түрүүнд төрсөн хөвгүүн нь Рүбин билээ. 9 Рүбиний хөвгүүд нь; Хануг болон Палму ба Хижрүн болон Кармия билээ. 10 Симоны хөвгүүд нь; Замуйл бол Замин ба Ухад болон Закин ба Жухар болон нэг Ханаван газрын гэргийн хөвгүүн болсон Шавул билээ. 11 Ливийн хөвгүүд нь; Киршүн болон Күхад ба Мирари билээ. 12 Иудей нь хөвгүүд нь; Ир болон Унан ба Шила болон Париж ба Жара билээ. Зүгээр, Ир болон Унан нь Ханаван газарт нөгчив. Парижийн хөвгүүд нь Хижрун болон Хамул билээ. 13 Иссахарын хөвгүүд нь; Ту Ла болон Пүва ба Иуб ба Шимрун билээ. 14 Сабулуны хөвгүүд нь; Шарад болон Илун ба Захалил билээ. 15 Эдгээр нь Ли Эгийн Яахоб Падан Арамд төрүүлсэн хөвгүүд билээ. Бас түүний Динна охин билээ. Түүний хөвгүүн болон охин үрс нь бүгд хорин гурав билээ. 16 Гадын хөвгүүд нь; Зупиуг болон Хаки ба Шүни болон Ижбун ба Ири хийгээд Аруди ба Арили билээ. 17 Асирын хөвгүүд нь; Зимна болон Ишуа ба Ишүй болон Бирия

бөгөөд тэдний охин дүү Сийр болон Бирияагийн хөвгүүд Хибар болон Малкиял билээ. 18 Эдгээр нь Лабаний Ли Эгийн охиндоо өгсөн Зилпагийн хөвгүүд билээ. Түүнээс эдгээр арван зургаан хүн нь Яахобт үржив. 19 Яахобын гэргий Рахилийн хөвгүүд нь; Иосиб болон Бинзамин билээ. 20 Иосиб Египет газарт төрөгдөгсөд нь; Оны Путивура гэгч ламын охин Аминад нь түүнд Манасиш болон Ивураймыг төрүүлэв. 21 Бинзамины хөвгүүд нь; Билэ болон Бикир ба Ашбил болон Кира ба Нэ Э Ман болон Ихи ба Рус болон Мүпим ба Хүпим болон Ард билээ. 22 Эдгээр Яахобт Рахилээс үржсэн хөвгүүд билээ. 23 Дэнгийн хөвгүүд нь; Хүшим билээ. 24 Наво Талийн хөвгүүд нь; Зажил болон Күни ба Зижар болон Шилим билээ. 25 Эдгээр нь Лабаний Рахил охиндоо өгсөн Билхагийн хөвгүүд билээ. Түүнээс Яахобт хамаг үржигсэд нь долоон хүн билээ. 26 Яахобын бэрүүдээс гадна Яахобын биеэс гарсан болон Яахобтай Египетэд очсон бүгд нь гэвэл, жаран зургаан хүн билээ. 27 Иосиб Египетэд төрөгдсөн хөвгүүд нь хоёр бөгөөд Египетэд очсон Яахобын гэрийн улс бүгдээрээ далан хүн билээ. 28 Тийм бөгөөд Яахоб нь Күшинд уулзъя гэж Иосиб мэдүүлэхийн тулд Иудейг урдаа илгээгээд Кушин газарт ирэв. 29 Тийм бөгөөд Иосиб нь өөрийн тэргийг бэлтгүүлээд, өөрийн эцэг Израйльд очихын тулд Кушинд очиж, түүнийг үзээд, түүний хүзүүнд унаж, өнө болтол уйлав. 30 Тийнхүү Израйль нь Иосиб өгүүлэв; Чиний амьд байх тул би чиний нүүрийг үзээд, одоо нөгчих болтугай! 31 Иосиб нь өөрийн ах дүү нар болон Ворауд мэдүүлж, түүнд ийн өгүүлнэ. Ханаван газарт байсан миний ах нар болон миний эцгийн гэрийн улс нь надад ирэв. 32 Тэр хүмүүс нь малчид буй. Тэдний үйлдэх үйл нь гэвэл, малыг тэжээх буй. Бас тэд нь өөрийн хоньд болон үхрүүд ба хамаг зүгээрийг авчрав. 33 Тийм бөгөөд Ворау нь таныг дуудаж, Таны үйлдэх үйл нь юу вэ? 34 гэж танд өгүүлэхэд та Кушин газарт суухын тулд та ийн; Чиний боолууд бага наснаас бид болон бидний эцэг нар нь малчин улс буй гэж өгүүлэгтүн! Яагаад гэвэл, аливаа малчин нь Египетийн хүнд жигшүүртэй буй гэж өгүүлэв.

Дөчин долдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Иосиб нь Ворауд ирээд, түүнд мэдүүлж, өгүүлэв; Миний эцэг болон ах дүү нар ба тэдний хоньд болон үхрүүд ба тэдний хамаг нь Ханаван газраас ирээд Кушин газарт буй гэж өгүүлэв. 2 Жич, тэр нь өөрийн ах дүү нараас таван хүнийг аваад Вораутэй бараалхуулав. 3 Ворау нь түүний ах нарт өгүүлэв; Таны үйлдэх үйл нь юу вэ? гэж өгүүлсэнд тэд нь Ворауд; Чиний боолууд нь бид болон бидний эцэг нар хоньчид буй бөгөөд 4 энэ газарт нутаглахын тулд ирэв. Яагаад гэвэл, Ханаван газарт зуд хүнд болсон тул чиний боолуудын хоньдод тэжээл үгүй буй. Тийм учраас чи өөрийн боолуудыг Кушин газарт суулгаж хайрла! 5 гэж өгүүлсэнд Ворау нь Иосиб өгүүлэв; Чиний эцэг болон ах дүү нар нь чамд ирсэн байтал 6 Египет газар нь чиний өмнө буй бөгөөд чи өөрийн эцэг болон ах дүү нарыг үлэмж сайн газарт суулган үйлд! Тэд нь Кушин газарт суух болтугай! Бас хэрэв чи тэндээс хэцүү хүмүүсийг мэдвэл, миний малын тэргүүлэгчид болон үйлд! гэж өгүүлэв. 7 Жич, Иосиб нь өөрийн эцэг Яахобыг Ворауд оруулж, Вораугийн өмнө тавьсанд Яахоб нь Ворауг адистидлав. 8 Тийнхүү Ворау нь Яахобт өгүүлэв; Чиний амины нас нь хэд болов? гэж өгүүлсэнд Яахоб нь өгүүлэв; Миний суусан

насны өдрүүд нь зуун гучин нас билээ. 9 Миний амины насны өдрүүд нь бага болон муу болоод, миний эцэг нарын суусан өдрүүд болон тэдний амины насны өдрүүдэд эс хүрэх 10 гэж өгүүлсэнд Яахоб нь Ворауг адистидлаад, Вораугийн өмнөөс гарав. 11 Тийм бөгөөд Иосиб нь өөрийн эцэг болон ах дүү нарыг суулгаж, Вораугийн захисны ёсоор Египет газрын үлэмж сайн газраа тэдэнд нэг өмчийг өгөв. Тэр газар нь Рамисис билээ. 12 Бас Иосиб нь өөрийн эцэг болон ах дүү нар ба өөрийн эцгийн гэрийн улсыг тэдний гэрдэхүүдийн ёсоор талхаар тэжээв. 13 Тэнд зуд маш хүнд болсон тул бүх газарт идээ нь үгүй болов. Бас Египет газар болон Ханаван газар нь тэр зудны тухай зовов. 14 Тийм байхад Иосиб нь худалдсан талхны төлөө Египет газар болон Ханаван газарт олдсон хамаг мөнгийг цуглуулаад, тэр мөнгийг Вораугийн гэрт оруулав. 15 Тийнхүү Египет газар болон Ханаван газарт мөнгөний дууссаны дараа хамаг Египеттэн нь Иосиб ирээд, өгүүлэв; Бидэнд талхыг өгтүгэй! Мөнгө нь үгүй болсон боловч бид чиний өмнө юуны төлөө үхэх буюу? 16 гэж өгүүлсэнд Иосиб нь өгүүлэв; Хэрэв мөнгө дууссан бол малаа авчрагтун! Би таны малын төлөө талхыг өгөх буй 17 гэж өгүүлсэнд тэд нь малаа Иосиб авч ирсэнд тэр нь тэдний адуу болон хонь ба үхэр болон илжгүүдийн төлөө тэдэнд талхыг өгөөд, тэрхүү жилд тэдний хамаг мал адгууснуудын төлөө тэднийг талхаар тэжээв. 18 Тэр жил дууссаны дараа тэд нь хоёр дахь жилд түүнд ирээд өгүүлэв; Бидний мөнгө дууссан бөгөөд бидэнд байсан мал адгуусууд нь миний ноёнд ирсэн тул бидний баяс болон газруудаас миний ноёны өмнө өөр буйыг эс үйлдсэнийг бид миний ноёноос үл далдална. 19 Бид болон бидний газрууд нь миний ноёны өмнө юуны тулд үхэх буюу? Бидний газадыг талхаар худалдаж өг! Бид болон бидний газрууд нь Ворауд боолууд болно. Бидний үл үхэх бөгөөд газрууд хоосон үл болохын тулд бидэнд хөрөнгийг өгтүгэй! 20 гэж өгүүлсэн Иосиб нь Египетийн хамаг газдыг Ворауд худалдаж авав. Яагаад гэвэл, тэр зуд нь тэднийг дарсан тул Египетийн хүн бүр өөрийн газрыг худалдав. Тийнхүү тэд газрууд ч Вораугийнх болов. 21 Бас тэр нь улсыг Египет газрын нэг хязгаараас өөр хязгаар хүртэл балгасаар нүүлгэн суулгав. 22 Харин тэр нь лам нарын газруудыг эс худалдаж авав. Яагаад гэвэл, лам нар нь Вораугийн нэг тогтоосон хувийг авч, Вораугийн өгсөн хувийг иддэг билээ. Тийм учраас тэд нь өөрийн газруудыг эс худалдав. 23 Тийм бөгөөд Иосиб нь улсад өгүүлэв; Би энэ өдөр таныг болон таны газруудыг Ворауд худалдаж авав. Мана. Танд хөрөнгө энд бий. Та түүнийг газарт хаяад 24 ургасан үрсээс Ворауд тавдугаар хувийг өгч, дөрвөн хувийг биедээ байлгана гэвэл, газрын хөрөнгө болон идээ ба өөрийн гэрийн улс болон хүүхдийн тул байлгagtун! 25 гэж өгүүлсэнд тэд нь өгүүлрүүн; Чи биднийг амьдаар байлгасан буй. Бид өөрийн ноёны өмнө хайрыг олох болтугай! Вораугийн боолууд болно. гэж өгүүлэв. 26 Энэ мэтээр Иосиб Ворауд таван хувийг өгнө гэж Египет газарт хуулд болгон энэ өдөр болтол тогтоов. Ямагт лам нарын газар нь Вораугийн биш билээ. 27 Тийм байхад Израйль Египет газрын Кушин газарт суун байхад тэнд өмчийг олоод, үрстэй болж, ихэд үржив. 28 Яахоб нь Египет газарт арван долоон жил суув. Яахобын амины насны өдрүүд зуун дөчин долоон нас болов. 29 Тийн байхад Израйлийн нөгчих цагийн ойр болсонд тэр нь Иосиб хөвгүүнээ дуудаад түүнд өгүүлэв; Хэрэв би чиний өмнө хайрыг олбол гараа

миний гуяны доор тавин, хайрлаад, надад өршөөнгүй хийгээд үнэнийг үйлд! гэвэл намайг Египетийн дотор булж бүү үйлд! 30 Би өөрийн эцэг нартай хэвтсүгэй! Чи намайг Египетээс аваачиж, тэдний булшинд булан үйлд! гэж өгүүлсэнд тэр нь Би чиний өгүүлснээр үйлдэнэ гэж өгүүлсэнд тэр нь өгүүлэв; Надад тангараглан үйлд! гэж өгүүлсэнд тэр нь тангараглав. Тийнхүү Израйль нь өөрийн дэвсгэр дээр мөргөв.

Дөчин наймдугаар бүлэг

1 Тийнхүү энэ мэт болсны дараа Чиний эцэг өвчтэй байна гэж Иосиб өгүүлэгдсэнд Иосиб нь өөрийн Манасши болон Ивурайм хоёр хөвгүүнийг өөртөө авав. 2 Тийм байхад Яахобт чиний Иосиб хөвгүүн нь чамд ирэв гэж өгүүлэгдсэнд Яахоб нь тэнхрүүлэгдэн, өөрийн дэвсгэр дээрээ суугаад Иосибт өгүүлэв; 3 Аугаа хүчит бурхан Ханаван газрын Лүзэд надад үзэгдээд, намайг адистидлав. 4 Бас тэр нь надад зарлиг болруун; Би чамайг үрстэй болгон үржүүлээд, чамайг улсын чуулган болгоод, энэ газрыг мөнх өмч болгон чиний дараа чиний үрсэд өгсүгэй! гэж зарлиг болов. 5 Одоо миний Египет газар чамд ирэхээс өмнө чамд төрөгдсөн хоёр хөвгүүн нь минийх буй. Ивурайм болон Манасши нь Рүбин болон Симон мэт минийх болох бий. 6 Чиний тэдний дараа төрүүлэх үрс нь чинийх болно. Тэд нь өөрийн өмчийн дотор өөрийн ах нарын нэрээр нэрлэгдэх буй. 7 Миний Паданаас ирэхэд, Ефэрадад нэг багахан төдий хүрээгүй байтал чиний Рахил эх нь Ханаван газрын дотор замаар миний өмнө нөгчсөн бөгөөд би тэнд Египетэд очих замд түүнийг булав.

* Verses 8 and 9 missing

10 Израйлийн нүд нь хөгширсөн учраас балар болсон бөгөөд тэр нь илэрхийгээр үзэж эс чадав. Тийнхүү тэднийг түүнд ойртуулсанд тэр нь тэднийг үнсэж, тэврэв. 11 Бас Израйль нь Иосиб өгүүлэв; Би чиний нүүрийг үл үзнэ гэж санавч, бурхан нь үрсийг ч надад үзүүлэв гэж өгүүлэв. 12 Тийнхүү Иосиб нь хоёр өвдөгний хоорондоосоо тэднийг гаргаад, нүүрээрээ хөсөр мөргөв. 13 Бас Иосиб нь тэд Ивураймыг барин, зүүн гартаа Израйлийг, баруун гарын тус Манасшийг барив. 14 Тийнхүү Израйль нь баруун гараа өргөөд, бага хөвгүүн байсан Авураймын тэргүүний дээр тавьж, Манасшийн их хөвгүүн боловч мэдлээр зүүн гараа Манасшийн тэргүүн дээр тавив. 15 Тийнхүү тэр нь Иосибийг адистидлаж өгүүлэв; Миний Абрахам болон Ишаг эцэг нарын хэний өмнө явсан тэр бурхан нь миний төрснөөс одоо өдий болтол намайг тэжээсэн бурхан болон 16 намайг хамаг зүгээрээс тонилгосон элч нь эдгээр хөвгүүдийг адистидлах болтугай! Тэд нь миний нэр болон миний Абрахам ба Ишаг эцэг нарын нэрээр нэрлэгдэн, газрын дунд загас мэт үржээд, олон болох болтугай! гэж өгүүлэв. 17 Тийнхүү Иосиб нь өөрийн эцгийн баруун гараа Ивураймын тэргүүн дээр тавьсныг үзэж, эс таалаад, өөрийн эцгийн гарыг Ивураймын тэргүүнээс Манасшийн тэргүүнд тавихын тулд өргөөд эцэгтээ өгүүлэв; 18 Миний эцэг ээ! Тийм биш билээ. Энэ нь их хөвгүүн буй. Баруун гараа түүний тэргүүний дээр тавь! 19 гэж өгүүлсэнд түүний эцэг нь эс зөвшөөрөн

өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Би үүнийг мэднэ. Би үүнийг мэднэ. Тэр нь нэг улс болон их болно. Түүний дүү нь түүнээс үлэмж их болох бөгөөд түүний үрс нь дүүрэн улс болох буй гэж өгүүлэв. 20 Энэ мэтээр тэр нь тэр өдрөө тэднийг адистидлаж, өгүүлэв; Чамд Израйль нь адистидлаж, ийн өгүүлнэ. Бурхан нь чамайг Ивурайм болон Манасшийн мэт болох болтугай! гэлээ. Энэ мэтээр тэр нь Ивураймыг Манасшийн урьд тавив. 21 Тийм бөгөөд Израйль нь Иосибээ өгүлэв; Би үхнэ. Зүгээр, бурхан нь таны эцэг нарын газарт таныг хариулах буй. 22 Жич, би чиний ах дүү нараас дээр чамд нэг хувийг өгнө. Би түүнийг өөрийн илд болон нумаар Амурийн улсын гараас авав.

Дөчин есдүгээр бүлэг

1 Тийм бөгөөд Яахоб нь хөвгүүдээ дуудан өгүүлэв; Миний хөвгүүн ээ! Хойт цагт тантай юу учралдахыг миний танд үзүүлэхийн тулд цуглагтун! 2 Яахобын хөвгүүн ээ! Та цуглаад, сонсогтун! Өөрийн Израйль эцгийг сонсогтун! 3 Рүбин ээ! Чи миний анхны төрөгдсөн болон миний хүч болон миний тэнхээгийн эхэн буй. Чи эрмэлзлэлээр эрхэм болон хүчээр эрхэм буй. 4 Харин чи ус мэт хальж, үл дэвших буй. Яагаад гэвэл, чи өөрийн эцгийн хэвтэрт оров. Чи миний дэвсгэрт ороод, түүнийг бузарлав. 5 Симон болон Ливи нь ах дүү мөн. Тэдний илдүүд нь дээрэмдлэгтэй зэвсгүүд буй. 6 Миний сүнс ээ! Чи тэдний нууцад бүү ор! Миний хүндлэл ээ! Чи тэдний хуралтай бүү нийл! Тэд нь өөрийн хилэнгээр хүнийг алж, өөрийн дураар үхрийг таслав. 7 Тэдний хилэн нь хараагдах болтугай! Яагаад гэвэл, тэр нь хүчтэй билээ. Тэдний уурлал нь хараагдах болтугай! Яагаад гэвэл, тэр нь догшин билээ. Би Яахобын дотор тэднийг салган, Исра Ийлийн дотор тэднийг тараах буй. 8 Иудей ээ, чиний ах дүү нар нь чамайг магтах буй. Чиний гар нь өөрийн дайсны хүзүүнд болно. Чиний эцгийн хөвгүүд ч чамд мөргөх буй. 9 Иудей нь нэг арслангийн зулзага буй. Миний хөвгүүн ээ! Чи олзоос харив. Тэр нь арслан мэт бөхийн арслан мэт хэвтэнэ. Түүнийг хэн босгох вэ? 10 Шилуйн иртэл очир нь Иудейнээс үл хагацах бөгөөд түүний хөлийн дундаас тогтоолж, үл хагацах буй. Улсын хурал нь түүнд болох буй. 11 Тэр нь өөрийн илжгийг үзмийн ишинд уяж, өөрийн илжигний унагыг сайн үзмийн ишинд уяна. Тэр нь хувцсаа ундаагаар угааж, дээлээ үзмийн шүүсээр угаах буй. 12 Түүний хоёр нүд нь үзмийн ундаагаар уйлах бөгөөд түүний шүд нь сүүгээр цагаан болох буй. 13 Сабулун нь; далайн гарамд нутаглан, их онгоцуудын гарамд нутаглах буй. Түүний хязгаар нь Сийдүн хүртэл болох буй. 14 Иссахар нь хоёр ачааны хооронд хэвтэгч хүчтэй илжиг буй. 15 Тэр амрыг сайн болон газрыг тааламжтай гэж үзээд, ачааг өргөхийн тулд мөрөө бөхийлгөн, албат боол болов. 16 Дэн нь Израйлийн нэг овог мэт өөрийн улсыг шийтгэх буй. 17 Дэн нь харанхуйн дээр нэг могой болон замын нэг хорт могой болно. Тэр нь мөрний морины нагсагайг зууж, унагчийг гэдрэг унагах буй. 18 Жахуа аа! Би чиний авралыг хүлээн авна. 19 Гадь нь ; нэг чуулган нь түүнийг дийлнэ. Тэр нь дараа дийлэх буй. 20 Амир нь түүний идээ нь тарган болох бөгөөд тэр нь хааны тансаг идээг авчрах буй. 21 Наутали гэвэл нэг сул тавигдсан марал мэт болон сайхан үгтэй буй. 22 Иосиб нь; нэг үрстэй гишүүн болон худгийн дэргэд таригдсан үрсүүдтэй гишүүн буй. Түүний салаанууд нь хүрээний дээр гарна. 23

Харвагчид нь түүнийг машид гашуудуулан, түүнийг харвалдан өшөөлсөн буй. 24 Зүгээр, түүний нум нь чанга байсан бөгөөд түүний гарын чадвах нь Яахобын аугаа хүчит бурхны мутраар хүчтэй байсан буй. Тэндээс Израйлийн хоньчин болон хаад болсон буй. 25 Тэр нь чамд туслагч чиний эцгийн бурхнаас болон чамайг адистидлах аугаа хүчит бурхнаас болсон буй. Тэр ч дээрээс огторгуйн адистан болон доор хэвтэгчийн адистадуудаар чамайг адистидлах буй. 26 Чиний эцгийн адистад нь мөнх хаадуудын хязгаар хүртэл миний эцэг нарын адистадуудаас үлэмжилсэн буй. Тэд нь Иосибийн толгой дээр тогтон өөрийн ах дүү нараас салгагдсаны оройн дээр тогтох болтугай! 27 Бинзамин гэвэл нэг чоно мэт таслах буй. Тэр нь өглөөгөөр олзоо идэж, үдшээр булааснаа хуваах буй. 28 Эдгээр хамаг нь Израйлийн арван хоёр овгууд юм. Бас энэ мэтээр тэдний эцэг нь тэдэнд өгүүлж, хүн бүрийн адисын ёсоор тэднийг адистидлав. 29 Жич, тэр нь тэдэнд захиж өгүүлэв; Би өөрийн улсад хураагдах болов. Та миний эцэг нартай Хитийн тариалангийн хөндий дотор намайг булж, 30 Ханаван газрын Мамрийн өмнө булах, газар болохын тулд Абрахамын Хитигийн Ипарунаас худалдаж авсан Магпилагийн хөндийд булагтун! 31 Тэнд Абрахам нь өөрийн гэргий Са Ратай булагдав. 32 Тэр тариалан болон түүний дотор байгч хөндий нь Хитийн хөвгүүдээс худалдан авагдсан билээ. 33 Тийм бөгөөд Яахоб нь хөвгүүддээ захиж, дуусаад хөлөө дэвсгэртээ татан, амиа гаргаж, өөрийн улсад хураагдав.

Тавьдугаар бүлэг

1 Тийм бөгөөд Иосиб нь өөрийн эцгийн нүүрэнд унаад, түүний дээр уйлж түүнийг үнсэв. 2 Тийнхүү Иосибийн эцгийнхээ ясыг анхилах үнэртнээр гамнагтун! гэж эмч боолууддаа захисанд тэд эмч нар нь Израйлын ясыг анхилуун үнэртнээр гамнав. 3 Тийм бөгөөд тэр нь анхилуун үнэртнээр гамнах ёсыг бүтээхэд дөчин хоног нь дуусав. Жич, Египеттэн нь түүний төлөө далан хоног цорхиров. 4 Тийм бөгөөд цорхирох цаг дууссаны дараа Иосиб нь Вораугийн гэрийн улсад өгүүлэв; Хэрэв би таны өмнө хайрыг олбол та Вораугийн чихэнд өгүүлэгтүн! 5 Миний эцэг нь намайг тангараглуулж ийн; Би нөгчих буй. Ханаван газарт миний биеийн төлөө малтсан булшны тэнд намайг булан үйлд! гэж өгүүлэв. Тийм учраас өөрийн эцгийг булахын тулд намайг тавин хайрла! Би буцаж ирэх буй 6 гэж өгүүлсэнд Ворау нь өгүүлэв; Чиний эцэг нь чамайг тангарагласан мэт түүнийг булахын тулд явтугай! 7 гэж өгүүлсэнд Иосиб нь эцгээ булахын тулд явав. Бас түүнтэй Вораугийн хамаг боол болон түүний гэрийн ахас ба Египет газрын ахас явалцав. 8 Бас Иосибийн хамаг гэрийн улс болон түүний ах дүү нар ба түүний эцгийн гэрийн улс нь одолцов. Ямагт тэдний хүүхэд болон хоньд ба үхрүүд Кушин газарт үлдэв. 9 Бас түүнтэй тэргэс болон морьтой их чуулган нь явалцав. 10 Тийм бөгөөд тэд нь Иорданы цаана байгч Атид гэдэг талд хүрээд, их болон хүнд цорхиролоор цорхиролдон, түүний эцгийн тухай долоон өдөр цорхиров. 11 Тийм бөгөөд тэр газар суугч Ханаваны улс нь Атад гэдэг талд тэр цорхирлыг үзээд ийн; Энэ нь Египет улсын хүнд цорхирол буй гэж өгүүлэв. Тийм учраас тэр газар нь Абил Мижрайм гэж нэрлэгдэв. Тэр нь Иорданы цаана буй билээ. 12 Энэ мэтээр түүний хөвгүүд нь түүний захисан мэт түүнчлэн үйлдэв. 13 Түүний хөвгүүд нь түүнийг Ханаван газарт

аваачаад, Абрахамын булах газрын өмч болохын тул Атадын Ипарунаас Мамрийн өмнө байгч худалдаж авсан тариалангийн хөндийд булав. 14 Тийм бөгөөд Иосиб болон түүний ах дүү нар ба түүний эцгийг булахын тулд явалцагсад нь түүний эцгийг булсны дараа Египетэд харив. 15 Тийм бөгөөд Иосибийн ах дүү нар нь өөрийн эцгийн нөгчсөнийг үзээд ийн өгүүлэлцэв; Иосиб нь биднийг өшөөлөөд, бидний түүнд хүргэсэн хамаг мууг бидэнд буцаах болжээ. 16 Тийм учраас тэд нь Иосиб илгээж, ийн өгүүлэв; Чиний эцэг нь нөгцөхөөс өмнө захиж ийн; 17 Та Иосиб ийн өгүүлэгтүн! Чиний ах нар нь чамд мууг йүлдсэн боловч тэдний нүгэл болон хилэнцийг өнгөрүүлж хайрла! гэж өгүүлэв. Тийм учраас чиний эцгийн бурхны боолуудын бурууг өнгөрүүлэн хайрла! гэж бид одоо гуйна гэж өгүүлсэнд Иосиб нь уйлав. 18 Бас түүний ах дүү нар нь очоод, түүний өмнө унаад; Бид чиний боолууд мөн буй! 19 гэж өгүүлсэнд Иосиб нь тэдэнд өгүүлэв; Та бүү айгтун! Би бурхнаас айдаг. 20 Та надад мууг үйлдсэнээ санавч бурхан нь одоо өдөр үйлдсэн мэт олон улсыг амьдаар байлгахын тулд түүнийг сайн болгохоо санав. 21 Тийм бөгөөд та одоо бүү айгтун! Би таныг болон таны хүүхдийг тэжээх буй гэж өгүүлснээр тэднийг амруулж, тэдэнтэй хайртайгаар хэлэлцэв. 22 Энэ мэтээр Иосиб болон түүний эцгийн гэрийн улс нь Египетэд суув. Иосиб нь зуун арван настай болтлоо суув. 23 Бас Иосиб нь Ивураймын гучин хөвгүүнийг үзсэн бөгөөд Манасшийн Махирын хөвгүүд нь Иосибийн өвдөгний дээр авчрагдав. 24 Тийм бөгөөд Иосиб нь өөрийн ах нарт өгүүлэв; Би нөгчинө. Зүгээр, бурхан нь эрхгүй таныг зулгаагаад, энэ газраас гарган, Абрахам болон Исаг ба Яахобт тангарагласан газарт оруулах буй гэж өгүүлэв. 25 Бас Иосиб нь Израйлын хөвгүүдийг тангараглуулан, өгүүлэв; Бурхан нь таныг эрхгүй зулгаах буй. Тийн болбол миний ясыг эндээс биетэй аваачигтун! гэж өгүүлэв. 26 Тийм бөгөөд Иосиб нь зуун арван настай болоод нөгчив. Түүний яс нь Египет газарт анхилуун үнэртнээр гамнагдаад, хайрцагны дотор агуулагдав.